

Төрийн ажлын хариуцагчид
чөлсөн ёслол



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 1

- Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль
- Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай Монгол Улсын хууль
- Монгол Улсын 1997 оны Улсын төвлөрсөн төсвийн тухай Монгол Улсын хууль
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хууль



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ,
ШИЙДВЭР, ХУУЛИЙН ТАЙЛБАР

Монгол Улсын Их Хурлын Хэвлэл

№ 1997 оны 1-р сар №1 /56/

ГАРЧИГ

1. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1.	Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	3
2.	Протокол соёрхон батлах тухай	5
3.	Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай	6
4.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай	49
5.	Хууль хүчингүй болсонд тооцох тухай	49
6.	Монгол Улсын 1997 оны Улсын төвлөрсөн төсвийн тухай	50
7.	Хэлэлцээрүүдийг хүлээн зөвшөөрч тэдгээрт нэгдэн орох тухай	52
8.	Конвенц соёрхон батлах тухай	52
9.	Хэлэлцээр соёрхон батлах тухай	53
10.	Хэлэлцээр соёрхон батлах тухай	53

2. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

11.	Ерөнхийлөгчийн хоригийн тухай №47	54
12.	Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тухай №48	54
13.	Хуулийн төсөл буцаах тухай №49	55
14.	"Ардын эрх" сонины Ерөнхий эрхлэгчийг томилох тухай №50	55
15.	Засгийн газрын гишүүнийг томилох тухай №51	56
16.	Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх, нөхөн томилох тухай №52	56
17.	Орон сууцны хөлсний дээд хэмжээ тогтоох тухай №54	57
18.	Хуулийн төсөл буцаах тухай №55	57
19.	Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай №56	58

20.	Шүүгчид нэмэгдэл олгох журам батлах тухай №57	59
21.	Прокурорт нэмэгдэл олгох журам батлах тухай №58	62
22.	Д. Моломжамцыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай №59	64
23.	Монголбанкны Ерөнхийлөгчийг томилох тухай №60	65
24.	Хуулийн төсөл буцаах тухай №62	65
25.	Хуулийн төсөл буцаах тухай №63	66
26.	Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тухай №64	66
27.	Эдийн засаг, худалдааны чөлөөт бүс байгуулах бэлтгэл ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай №65	67
28.	Хилийн зааг тогтоох тухай №66	68
29.	Улсын төвлөрсөн төсвийн алдагдлыг багасгах зарим арга хэмжээний тухай №67	69
30.	Хуулийн төсөл буцаах тухай №70	72
31.	Дэлхийн худалдааны байгууллагад гишүүнээр элссэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай №71	72
32.	Бүгд Найрамдах Перу Улстай дипломат харилцаа тогтоох тухай №72	73
33.	Төрөөс мөнгөний бодлогын талаар 1997 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай №73	73
34.	"Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 1997 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл"-ийг батлах тухай №74	77
35.	Монгол Улсын Үндсэн хуулийн 5 жилийн ойг тэмдэглэх тухай №75	11
36.	Улсын Их Хурлын Аюулгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай №76	11
37.	Байнгын хорооны гишүүнээс чөлөөлөх, гишүүнээр батлах тухай №77	1

3. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

38.	Зэрэг дэв олгох тухай №214	1
39.	Ч. Дашнямыг албан тушаалаас чөлөөлөх тухай №217	1
40.	Цэрэндашийн Цолмон, Надмидын Бавуу нарыг элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай №230	1
41.	Цэрэндашийн Цолмонг элчин сайдаар томилох тухай №231	1
42.	Тойтогийн Төмөрхүлэгийг элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай №232	1
43.	Лувсандоржийн Баяртыг элчин сайдаар томилох тухай №233	1
44.	Зарлиг хүчингүй болсонд тооцох тухай №234	1
45.	Багш нарын талаар авах зарим арга хэмжээтэй холбогдуулан Засгийн газарт чиглэл өгөх тухай №235	1

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 10 дугаар
сарын 25-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний хуульд дор дурдсан агуулгатай 181¹ дүгээр зүйл нэмсүгэй:

"181¹ дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа (импотек)

1. Хуульд өөрөөр заагаагүй бол газар, түүн дээр ургаж байгаа олон наст ургамал, тарьц болон газраас салган хэрэглэж үл болох бусад баялаг, үйлдвэр, барилга, байгууламж, орон сууцны байшин, сууц зэрэг үл хөдлөх эд хөрөнгө барьцааны зүйл байж болно.

2. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээг бичгээр хийж, нотариатаар гэрчлүүлэх ба уг эд хөрөнгө байгаа газрын үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар бүртгүүлдэ.

Энэ журмыг зөрчсөн барьцааны гэрээ хүчин төгөлдөр бус байна.

Барьцаалсан эд хөрөнгийн өмчлөх эрх өөр этгээдэд шилжсэн, эсхүл үүрэг гүйцэтгүүлэгч шаардах эрхээ өөр этгээдэд шилжүүлсэн тохиолдолд барьцааны гэрээг бүртгэсэн бүртгэлд хуульд заасан журмын дагуу зохих гэмдэгтэл хийнэ.

3. Үүрэг хүлээгчийн гүйцэтгэвэл зохих үүргийг хангуулахаар үл хөдлөх эд хөрөнгөө барьцаалсан барьцаалуулагч (өмчлөгч) нь үүрэг хүлээгчийн үүрэг гүйцэтгүүлэгчид тавибал зохих шаардлагыг үүрэг гүйцэтгүүлэгчид нэгэн ажил тавих эрхтэй.

4. Үйлдвэр барьцаалсан тухай гэрээнд өөрөөр заагаагүй бол барьцааны гэрээ байгуулах үед тухайн үйлдвэрийн газрын балансад байсан үндсэн ба эргэлтийн, хөдлөх ба үл хөдлөх эд хөрөнгө болон шаардах эрх түүнчлэн онцгой эрхийг оролцуулан тухайн үйлдвэрийн газрын бүх эд хөрөнгө цогцолбороороо уг барьцааны гэрээний зүйл байна.

5. Гэрээнд өөрөөр заагаагүй бол барьцааны хугацаанд барьцаалсан үл хөдлөх эд хөрөнгийг ашигласны үр дүнд олж авсан ашиг, эрлого, бүтээгдэхүүн, үр шим барьцааны зүйл болно.

6. Гэрээнд өөрөөр заагаагүй бол газар барьцаалахад түүн дээр зайгаа буюу шинээр баригдаж байгаа барилга, байгууламж барьцааны зүйлд үл хамаарна.

Барьцаалсан газрын үнээс үүрэг гүйцэтгүүлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг хангахаар болбол тухайн газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч уг хөрөнгөө зориулалтаар нь ашиглахын тулд

газрын зохих хэсгийг хязгаартай ашиглах эсэх талаар сонирхогч талууд тохиролцоно.

Хэрэв ийнхүү ашиглахтай холбоотой асуудлаар талууд маргавал шүүх шийдвэрлэнэ.

7. Газрыг гадаадын иргэн болон хуулийн этгээд, харьяалалгүй хүнд барьцаалахыг хориглоно.

8. Барилга, байгууламж барьцаалахад тухайн барилга, байгууламж байгаа дэвсгэр газар буюу түүний тодорхой хэсэг нь эсхүл тухайн газар түүний тодорхой хэсгийг ашиглах эрх уг барилга, байгууламжийн хамт нэгэн зэрэг барьцаалагдана.

9. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол гэрээ байгуулах үед барьцаалуулагчийн эзэмшилд байгаагүй боловч түүний өмчлөлд хожим бий болох үл хөдлөх эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эрх барьцааны зүйл байж болно.

10. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол барьцаалуулагч нь барьцаалсан үл хөдлөх эд хөрөнгөө даатгуулах, тухайн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах, үр ашигт чанарыг хэвээр хадгалах шаардлагатай арга хэмжээ авах үүрэгтэй.

11. Барьцаалсан үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч нь тухайн үл хөдлөх эд хөрөнгөө өөрийн үзэмжээр ашиглах, бусдад ашиглуулах, бусдын эзэмшилд шилжүүлэх, худалдах, өвлүүлэх зэргээр захиран зарцуулах эрхтэй. Энэ тохиолдолд барьцааны гэрээ хүчин төгөлдөр хэвээр байна.

Барьцаалуулагчийн дээрх эрхийг хязгаарласан хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

12. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээнд энэ хуулийн 181 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасан гол нөхцөлүүдийн аль нэг нь байхгүй бол барьцааны гэрээ байгуулагдаагүйд тооцогдоно.

Үйлдвэр барьцаалсан бол тухайн үйлдвэрийн баланс, нягтлан бодох бүртгэлийн тайлан, хөдлөх ба үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл, бүрэлдэхүүн хэсэг, үйлдвэрийн газрын байршил, бүдүүвч зураг, онцгой эрхэд хамаарах зүйлсийн жагсаалт, үнэлгээ зэрэг зайлшгүй шаардлагатай баримтыг гэрээнд хавсаргана.

13. Хуульд өөрөөр заагаагүй бол барьцаалагдах үл хөдлөх эд хөрөнгийн үнэ буюу үнэ тодорхойлох аргыг талууд тохиролцон тогтооно.

Энэ талаар барьцааны гэрээний талууд маргавал шүүх шийдвэрлэнэ.

14. Өмчлөх эрхгүй боловч газрыг насаараа эзэмших, ийнхүү эзэмших эрхээ өвлүүлэх эрх бүхий иргэн уг газраа бусдад барьцаалуулах эрхгүй. Харин хууль буюу газар өмчлөгчтэй байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол өмчлөгчийн зөвшөөрлөөр тухайн

иргэн эзэмшилдээ байгаа газраа бусдад түрээслүүлэх, үнэ төлбөргүй хугацаатай ашиглуулах хэлбэрээр газар эзэмших эрхээ барьцаалж болно. Хуульд өөрөөр заагаагүй бол барилга, байгууламж, сууц эзэмшигчдэд энэ заалтыг хамааруулж болно.

15. Дундын өмчлөлд байгаа үл хөдлөх эд хөрөнгийг бүхэлд нь барьцаалахад барьцаалуулагч нь өмчлөгч тус бүрийн зөвшөөрлийг бичгээр авна.

Үл хөдлөх эд хөрөнгийг дундаа хэсгээр өмчилж байгаа өмчлөгч бүр өөрт оногдох хэсгээ барьцаалуулахад энэ заалт хамаарахгүй.

16. Барьцаалсан үл хөдлөх эд хөрөнгийг дахин барьцаалахаар хэд хэдэн гэрээ байгуулж болно. Энэ тохиолдолд барьцаалуулагч тухайн үл хөдлөх эд хөрөнгө нэгэнт барьцаанд байгаа тухай дараа дараагийн барьцаа баригчид урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.

Дахин барьцаалах гэрээг энэ зүйлд заасан хэлбэр, журмын дагуу байгуулна.

Барьцаалсан үл хөдлөх эд хөрөнгөөс үүрэг гүйцэтгүүлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг хангахдаа барьцааны гэрээг бүртгүүлсэн бүртгэлийн дарааллыг баримтална.

17. Барьцаалсан үл хөдлөх эд хөрөнгийн үнээс үүрэг гүйцэтгүүлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг хангахдаа шүүхийн шийдвэрийг үндэслэн дуудлагын худалдаа явуулна.

Барьцаалуулагч, барьцаалагчийн хамтран гаргасан хүсэлтийг харгалзан шүүх өөр хэлбэр тогтоож болно.

18. Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахад энэ хуулийн 181 дүгээр зүйлийн 1, 3, 4, 5, 6, 7, 9, 11, 12, 13, 15, 16, 17, 18 дахь хэсэгт заасныг дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл. Иргэний хуулийн 181 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 8 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэрийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Их Хурлын дэд дарга

Ц. ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 10 дугаар
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

ПРОТОКОЛ СОЁРХОН БАГЛАХ ТУХАЙ

Монгол Улс, Дэлхийн худалдааны байгууллагын хооронд 1996 оны 7 дугаар сарын 18-ны өдөр Женев хотноо гарын үсэг зурсан

"Дэлхийн худалдааны байгууллага байгуулах Мэррежешийг Хэлэлцээрт Монгол Улс нэгдэн орох тухай Протокол"-ыг соёрхон баталсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

ШҮҮХИЙН ШИЙДВЭР БИЕЛҮҮЛЭХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооход оршино.

2 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль тогтоомж

1. Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль тогтоомж нь Үндс-хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөр журам тогтоосон бол олон улсын гэрээний эвцлийг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим

Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллага нь үйл ажиллагааны хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны эрх ашгийг хүн дэгтэх, ялсны эрхийг зөвхөн хуульд зааснаар хянаарлах, хорих ёл дэглэмээр нь алгамжтай нөхцөлд эдлүүлэх зарчмыг баримтална.

4 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр биелүүлэх үндэслэл

Шүүхийн шийдвэр биелүүлэх үндэслэл нь шүүхийн хүчин төгө-дөр шийдвэр, хуульд заасан бол бусад байгууллагын шийдвэр байна.

5 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын тогтолцоо

1. Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын тогтолцоо нь шүүхийн шийдвэр биелүүлэх төв байгууллага /цаашид "Шүүхийн

шийдвэр биелүүлэх газар" гэх/, аймаг, нийслэл дэх шүүхийн шийдвэр биелүүлэх тасагас бүрдэнэ. Ажлын шаардлагыг үндэслэн Шүүхийн шийдвэр биелүүлэх газрын даргын шийдвэрээр сум, түүрэгт шүүхийн шийдвэр биелүүлэх хэсэг байгуулж болно.

2. Шүүхийн шийдвэр биелүүлэх газар нь эд хөрөнгийн (олбогдолтой эрүүгийн болон иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх, хорих ял эдлүүлэх, шүүхийн зарим төрлийн шийдвэрийг бусад байгууллагаас биелүүлэх үйл ажиллагаанд нэгдсэн бүртгэл хөгөлж, хяналт тавих албадтай байна.

6 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын бүрэн эрх

1. Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллага нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлдэг:

1/ эрүү, иргэний хэргийн талаар гарсан торгох, эд хөрөнгө зурах, гаргуулах шүүхийн шийдвэр, хуульд заасан бол бусад байгууллагын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

2/ хорих ял эдлүүлэх талаар гарсан шүүхийн шийдвэрийн биелэлтийг нэгтгэн зохион байгуулах;

3/ шүүхийн зарим төрлийн шийдвэрийг бусад байгууллагаас эрэгжүүлэх үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар ангал, нэгдсэн тоо бүртгэл хөгөлж, хяналт тавих;

4/ боловсон хүчний бодлого боловсруулах;

5/ ажлын төлөх, чөлөөлөх, цэргийн цол олгох;

6/ улсын төвлөрсөн төсвөөс олгосон хөрөнгийг харьяалах шүүхийн шийдвэр биелүүлэх тасаг, хэсэг, хорих ангид хуваарилах, өрийн мэдлийн төвлөрсөн хөрөнгийг захиран зарцуулах, батлагдсан өсвийн хүрээнд багтаан харьяалах алба, хорих анги, байгууллагын рон тоо, цалингийн санг батлах;

7/ шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын ажил мөрдөх зурмыг энэ хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн батлах, биелэлтийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих.

2. Хуульд өөрөөр заагаагүй бол шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллага нь дэргэдээ төрийн өмчид үндэслэсэн аж ахуйн нэгжтэй айж болно.

7 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын санхүүжилт

Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын бүх зардлыг улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлдэг.

8 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын ажилтан

1. Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын ажилтан нь шийдвэр гүйцэтгэгч болон хорих байгууллагын албан хаагчаас

бүрдэнэ. Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын ажлалт төрийн төлөөлөгч мөн.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь Улсын ерөнхий гүйцэтгэгч шадар гүйцэтгэгч, ахлах гүйцэтгэгч, гүйцэтгэгчээс бүрдэнэ.

3. Улсын ерөнхий болон шадар, ахлах гүйцэтгэгч нь улсын байцаагчийн эрх эдэлнэ.

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн нийтлэг эрх:

1/ шийдвэрийг сайн дураар биелүүлэхийг шаардах, шийдвэр мэдэгдлийг биелүүлсэн эсэхийг аж ахуйн нэгж, байгууллагын захиргаанд шалгах;

2/ харнуулагч шийдвэрийг сайн дураар биелүүлдэггүй буюу биелүүлэхээс үшээлэлгүйгээр татгалзсан, орлого, эд хөрөнгөнүүсн тохиолдолд хуульд заасан журмын дагуу аж ахуйн нэгж байгууллага, иргэний орон байранд нэвтрэн орж, биед болон эд хөрөнгөнд үзлэг, нэгжлэг хийх, эд хөрөнгө битүүмжлэх, барьцаалах хураах, нуугдмал хөрөнгө илрүүлэх, хураагдсан эд хөрөнгө худалдан борлуулах зэргээр албадан гүйцэтгэх;

3/ албан үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан хүч хэрэглэх буюу хэрэглэхээр завдаж эсэргүүцсэн этгээдэд энэ хуульд заасан тусгай хэрэгсэл хэрэглэх;

4/ хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах эрүүгийн хэрэг, захиргааны зөрчлийн шинж бүхий баримт илэрвэл холбогдох байгууллагад мэдэгдэх.

5. Ахлах гүйцэтгэгч энэ зүйлийн 4 дэх хэсэгт зааснаас гадн шийдвэр гүйцэтгэлийн тасаг, хэсгийн ажлыг шуурхай удирдлагаа хангах, гүйцэтгэгчийн шийдвэрийг хянаж өөрчлөх, хүчингүй болгох гүйцэтгэгчийн шийдвэр биелүүлэх ажлалаганд баримтын шалгалт хийх, гүйцэтгэх баримт бичгийн нэгдсэн тоо бүртгэл, данс хөтлөх мэдээ, тайлан тэнцлийг хуульд заасан журмын дагуу нэгтгэн гаргах эрх эдэлнэ.

6. Шадар гүйцэтгэгч энэ зүйлийн 4 дэх хэсэгт зааснаас гадн шүүхийн шийдвэр биелүүлэх тасаг, хэсгийн ажилд баримтын шалгалт хийх, ахлах гүйцэтгэгч, гүйцэтгэгчийн шийдвэрийг өөрчлөх хүчингүй болгох эрх эдэлнэ.

7. Ерөнхий гүйцэтгэгч энэ зүйлийн 4, 6 дахь хэсэгт зааснаа гадна гүйцэтгэлийн албыг мэргэжлийн удирдлагаар хангах, шадар ахлах гүйцэтгэгчийн шийдвэрийг хянаж өөрчлөх, хүчингүй болгох эрх эдэлнэ.

8. Шүүхийн шийдвэр биелүүлэх газрын дарга шийдвэр биелүүлэх, хорих ял эдлүүлэх болон бусад албыг зохион байгуулалтын Ерөнхий, шадар гүйцэтгэгчийн болон бусад албадын даргын үйл

ажиллагааг өдөр тутмын шуурхай удирдлагаар хангаж, Ерөнхий гүйцэтгэгчийн шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох эрх эдэлнэ.

9. Шийдвэр биелүүлэхээс санаатайгаар зайлсхийсэн, энэ зорилгоор хуурамч гэрээ хийж эд хөрөнгийг бусдад шилжүүлсэн, нуун дарагдуулсан, битүүмжилсэн эд хөрөнгийг санаатайгаар үрэгдүүлсэн, төлбөр төлөгчийн цалин, орлогоос суутгал хийгээгүй буюу дутуу суутгасан, эсхүл суутгасан мөнгийг хуульд заасан хугацаанд олгоогүй буюу шилжүүлээгүй, төлбөр төлөгчийг ажлаас халагдсаныг мэдэгдээгүй иргэн, албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хуульд заасан журмын дагуу улсын байцаагч захиргааны шийтгэл ногдуулна.

10. Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын ажилтны хууль ёсны шаардлагыг аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэд завал биелүүлэх ба биелүүлэхгүй бол хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

11. Хорих ангийн албан хаагч дараахь эрх эдэлнэ:

1/ оргосон хоригдол байгаа, эсхүл энэ талаар лавтай сэжиг байвал хуульд заасан журмын дагуу тухайн байгууллага, иргэний байр, орон сууцанд нэвтрэн орох, байр, орон сууц, тээврийн хэрэгсэл, түүнчлэн оргололд туслалцаа үзүүлсэн буюу туслалцаа гзүүлсэн гэж үзэх лавтай сэжиг бүхий иргэний бичиг баримтыг шалгах, биед үзлэг хийх, албан тушаалтан, иргэнээс тайлбар, годорхойлолт, шаардлагатай мэдээллийг гаргуулан авах;

2/ хорих ангийн байр болон үйлдвэрлэлийн талбайд орж, гэрч хайгаа тээврийн хэрэгсэлд үзлэг хийх;

3/ оргосон хоригдлыг эрэн сурвалжлах, мөрдөн хөөх, баривчлах яед зайлшигүй шаардлагатай тохиолдолд иргэн, байгууллагын тээврийн хэрэгслийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр түр дайчлах, холбоо, мэдээллийн хэрэгсэлээр дараалал харгалзахгүй үйлчлүүлэх. Карин дипломат төлөөлөгчдийн болон албан тушаалын, түүнчлэн үргээ гүйцэтгэж яваа түргэн тусламжийн, гал унтраах албаны, техникийн ослын дуудлагын автомашиныг ийнхүү дайчилж болохгүй;

4/ энэ зүйлийн 11 дэх хэсгийн 3-т заасны дагуу тээвэр, холбоо, мэдээллийн хэрэгсэл ашигласны хөлс, зардлыг тухайн үеийн нэлгээгээр тооцож, зохих иргэн, байгууллагад олгоно.

9 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын ажилтны тангараг, дүрэмт хувцас, цол

1. Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын ажилтан төрийн үлдэнэ: "Монгол Улсын иргэн би шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагад алба хаахдаа хуулийг дээдлэн биелүүлд, хүний эрх, эрх өлөөг хүндэтгэн, төрийн өмнө хуулиар хүлээсэн үүргээ үнэнчээр нелүүлж, эх орныхоо төлөө чин шударгаар зүтгэж, шаардлага

гарвал амь насаа үл хайрлахаа батлан тангараглаа. Би тангарагсаа няцаах төрийн хуулийн цээрлэл хүлээнэ.” гэж тангараг өргөнө.

2. Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын ажилтан цэргийн цол, дотоодын цэргийн дүрэмт хувцастай байна.

10 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын ажилтны сахилгын дүрэм, шийтгэл

1. Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын ажилтны сахилгын дүрмийг Хууль зүйн сайд батална.

2. Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын ажилтан сахилгын дүрэм зөрчсөн тохиолдолд дараахь шийтгэл ногдуулна:

1/ сануулах;

2/ цолны мөнгийг гурван сар хүртэл хугацаагаар хасах;

3/ сарын үндсэн цалинг гурван сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;

4/ цол бууруулах буюу хасах;

5/ ажлаас халах.

11 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын ажилтны эрх зүйн баталгаа

1. Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын ажилтан дор дурсан эрх зүйн баталгаагаар хангагдана.

1/ албан үүргээ гүйцэтгэж байх үедээ нийтийн тээврийн хэрэгслээр зорчсон зардалыг тогтоосон журмын дагуу байгууллагаас нь олгох;

2/ албан үүргээ биелүүлж яваад амь насаа алдсан тохиолдолд аг гэрт нь түүний гурван жилийн үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж олгох;

3/ албан үүрэгтэй нь холбогдуулан эрүүл мэндэд нь хохирол учруулсны улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдсан, тэжир дутуу болсон тохиолдолд үндсэн цалингийн зөрүүг олгох;

4/ 24 цагийн жижүүрийн үүрэг гүйцэтгэж байгаа офицер, ахлагч нар байгууллагын зардалаар хооллох;

5/ шилжин томилогдох үед гэр бүлийн гишүүд болон амь тээшийг байгууллагын тээврийн хэрэгслээр хүргэх боломжгүй бол шаардагдах зардалыг автомашин, төмөр замын тээвэрт тухайн үл мөрдөж байгаа үнэлгээгээр тооцож олгох;

6/ офицер, ахлагч ээлжийн эмралтаараа өөрийн буюу эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт очиж, ирэх бол замын зардалыг автомашин, төмөр замын тээвэрт тухайн үед мөрдөж байгаа үнэлгээгээр тооцож 2 жил нэг удаа олгох;

7/ хорих ял эдлүүлэх байгууллагын албан хаагчийн үндсэн цалинд дээр нэмж олгох, хориндолтой ажилдасны, шийдвэр гүйцэтгэгчийн

удаан жил ажилласны болон тусгай албаны нэмэгдлийг Засгийн газар тогтооно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Эд хөрөнгийн холбогдолтой эрүүгийн болон иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх

12 дугаар зүйл. Эд хөрөнгийн холбогдолтой эрүүгийн болон иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр

Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллага нь эд хөрөнгийн холбогдолтой эрүүгийн болон иргэний хэргийн талаар гарсан дараахь шийдвэрийг биелүүлдэг:

1/ иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр;
2/ эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийн торгох, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эд хөрөнгө хураах ял болон эд хөрөнгө тэргүүлэх заалт;

3/ Монгол Улсын олон улсын гэрээнд зааснаар биелүүлбэл зохих таваад улсын шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр, холбогдох баримт бичиг;

4/ хуульд заасан бол захиргааны шийтгэвэр;

5/ арбитрын шийдвэр.

13 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагааны харьяалал

1. Шийдвэр биелүүлэх ажиллагааг төлбөр төлөгчийн оршин суугаа /оршин байгаа/ буюу ажиллаж байгаа, эсхүл эд хөрөнгө нь байгаа газрын шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэнэ.

2. Төлбөр төлөгч нь өөр орон нутагт шилжсэн бөгөөд хаяг нь одорхой бол гүйцэтгэх баримт бичгийг түүний шилжин очсон газрын шийдвэр биелүүлэх албанд шилжүүлж, энэ тухай төлбөр вагчинд мэдэгдэнэ.

14 дүгээр зүйл. Гүйцэтгэх баримт бичиг

1. Энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан шийдвэрийг биелүүлэх эрх үйн үндэс нь гүйцэтгэх баримт бичиг болно. Шийдвэр биелүүлэх ажиллагааг гүйцэтгэх баримт бичиггүйгээр явуулж болохгүй.

2. Гүйцэтгэх баримт бичиг:

1/ шүүхийн шийдвэрийн үндсэн дээр олгогдсон гүйцэтгэх хуудас;
2/ энэ хуулийн 12 дугаар зүйлийн 3, 4, 5-д заасан шийдвэр, усад баримт бичиг хамаарна.

15 дугаар зүйл. Гүйцэтгэх хуудасны агуулга

1. Гүйцэтгэх хуудсанд дараахь зүйл заавал тусгагдсан байна:

- 1/ гүйцэтгэх хуудас олгосон шүүхийн нэр;
- 2/ шийдвэр гаргасан огноо, шийдвэрийн дугаар;
- 3/ ямар хэргийн шийдвэрийг үндэслэж гүйцэтгэх хуудас олгосон;
- 4/ шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн заалт;
- 5/ шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон огноо;
- 6/ гүйцэтгэх хуудас бичсэн шүүгчийн нэр, олгосон огноо;
- 7/ төлбөр төлөгч, төлбөр авагчийн овог, нэр, ажлын болон гэрийн хаяг /аж ахуйн нэгж, байгууллагын оноосон нэр, үйл ажиллагаагаа явуулж байгаа газрын хаяг;
- 8/ шаардлагатай тохиолдолд төлбөр төлөгчийн биеийн зураг, иргэний паспортын болон регистрийн дугаар, аж ахуйн нэгж, байгууллагын улсын бүртгэлийн дугаар.

2. Гүйцэтгэх хуудас нь төрийн сүлд бүхий хэвтэмэл хуудас байна.

3. Гүйцэтгэх хуудсанд шүүгч гарын үсэг зурж, тамга дарна.

16 дугаар зүйл. Гүйцэтгэх хуудас бичих, олгох

1. Шүүгч нь шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болмогц гүйцэтгэх хуудас бичнэ. Харин нэн даруй биелүүлэх шүүхийн шийдвэрийн гүйцэтгэх хуудсыг шүүхийн шийдвэр гарсан өдөрт нь бичнэ.

2. Шийдвэр өөр өөр газар биелэгдэх, эсхүл хэд хэдэн төлбөр төлөгч буюу төлбөр авагчтай бол гүйцэтгэх хуудсыг тэдгээрийн тоогоор бичнэ.

3. Шүүх гүйцэтгэх хуудсыг бичсэн өдрөөс хойш 3 хоногийн дотор шүүхийн шийдвэр биелүүлэх тасаг, хэсгийн даргад шууд гардуулах буюу эсхүл төлбөр авагчид хүргүүлнэ.

4. Дараахь тохиолдолд гүйцэтгэх хуудсыг шүүхийн шийдвэр биелүүлэх тасаг, хэсгийн даргад шууд олгоно:

- 1/ төлбөрийг улсын төсвийн орлогод оруулах бол;
 - 2/ төлбөр төлөгч, авагчийн аль нэг нь өөр улс, аймаг, сум, дүүрэгт оршин суудаг /оршин байдаг/ бол;
 - 3/ бусдын амь нас, эрүүл мэндэд учирсан гэм хорыг нөхөн төлүүлэх бол;
 - 4/ хуулийн дагуу эд хөрөнгийг битүүмжилсэн бол;
 - 5/ шийдвэрийг даруй биелүүлэх бол.
5. Төлбөр авагч хүсвэл гүйцэтгэх хуудсыг тасаг, хэсгийн даргад шууд олгож болно.

6. Тасаг, хэсгийн дарга хүлээн авсан гүйцэтгэх хуудсыг бүртгэж шийдвэр гүйцэтгэгчдэд хуваарилна.

7. Гүйцэтгэх хуудсанд шүүхийн шийдвэр, битүүмжилсэн буюу хураасан эд хөрөнгийн акт, иргэдийн хувийн хадгалэмж, хуулийн этгээдийн харилцах дансны зарлагын гүйлгээг хаасан баримт бичиг тодорхойлолт зэргийг хавсаргана.

17 дугаар зүйл. Бусад гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авах

Гүйцэтгэх хуудаснаас бусад гүйцэтгэх баримт бичгийг төлбөр төлөгчийн оршин суугаа /оршин байгаа/ газрын шүүхийн шийдвэр биелүүлэх тасаг, хэсгийн дарга хүлээн авна.

18 дугаар зүйл. Гүйцэтгэх хуудсыг дахин олгох

Гүйцэтгэх хуудсыг үрэгдүүлсэн тохиолдолд түүнийг тухайн шүүхийн шүүгчийн захирамжаар хүчингүйд тооцож, дахин бичиж олгоно.

19 дүгээр зүйл. Гүйцэтгэчийг татгалзах

Шийдвэр гүйцэтгэгч нь төлбөр төлөгч, төлбөр авагчийн аль нэгний төрөл садан /эдэг, эх, эхнэр, нөхөр, төрсөн ах, эгч, дүү, хүүхэд, тэдний гэр бүлийн хүн/-гийн холбоотой бол нөгөө тал нь түүнийг татгалзаж болно. Энэ тухай хусалтийг шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагад бичгээр гаргах ба түүнийг 3 хоногийн дотор шийдвэрлэнэ.

20 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагаанд төлбөр төлөгч, төлбөр авагчийн эдлэх эрх

1. Төлбөр төлөгч, төлбөр авагч нь шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагаа явагдах үед байлцах, холбогдох акт, бусад баримт бичигтэй танилцах, тэдгээрийн хуулбарыг авах эрхтэй.

2. Төлбөр төлөгч, төлбөр авагч нь шийдвэр биелүүлэх ажиллагааг мөшөөрөөхгүй бол ажиллагаа явагдсан өдрөөс, уг ажиллагаа хэзээ, яана, явагдахыг мэдэгдээгүй бол мэдсэн өдрөөс хойш 14 хоногийн дотор энэ тухай гомдлоо шүүхэд гаргаж болно.

21 дүгээр зүйл. Шийдвэрийг сайн дураар биелүүлэх

1. Шүүгч нь гүйцэтгэх хуудсыг төлбөр авагчид хүргүүлэхийн хамт шийдвэрийг сайн дураар биелүүлэхийг шаардан, төлбөр төлөгчид хугацаатай мэдэгдэл өгнө.

2. Төлбөр авагч гүйцэтгэх хуудсыг хүлээн аваад түүнийг сайн дураар биелүүлэхийг төлбөр төлөгчөөс шаардаж болно.

3. Шийдвэр гүйцэтгэгч хүлээж авсан гүйцэтгэх баримт бичгийн дагуу хугацаатай мэдэгдэл бичиж, шийдвэрийг сайн дураар биелүүлэхийг төлбөр төлөгчөөс шаардана.

4. Шийдвэрийг сайн дураар биелүүлэх хугацааг 45 хүртэл оноогоор тогтооно.

22 дугаар зүйл. Шийдвэрийг албадан биелүүлэх

Төлбөр төлөгч энэ хуулийн 21 дүгээр зүйлийн 4-г заасан хугацаанд шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй буюу биелүүлэхээс атгалзвал шийдвэр гүйцэтгэгч шийдвэрийг албадан биелүүлэхээр арахь арга хэмжээ авна.

1/ төлбөр төлөгчийн хөрөнгө, биед үзлэг, нэгжлэг хийх, э хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах, хураах, худалдан борлуулах;

2/ төлбөр төлөгчийн шалин, бусад орлогоос суутгал хийлгүүлэх;

3/ төлбөр төлөгчийн бусдад байгал эд хөрөнгө, мөнгөнөөс төлбөр гаргуулах;

4/ шийдвэрт заасан тодорхой зүйлийг төлбөр төлөгчөөс гаргуулж төлбөр авагчид шилжүүлэх, тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэх;

5/ хуульд заасан бусад арга хэмжээ.

23 дугаар зүйл. Төлбөр төлөгчийн эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийх, эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах, хураах

1. Төлбөр төлөгчийн эд хөрөнгийн хэмжээг тогтоох зорилгоо түүний өөрт нь болон бусдын эзэмшилд байгаа эд хөрөнгө нэгбүрчлэн үзлэг хийнэ.

2. Төлбөр төлөгчийн эд хөрөнгөд үзлэг хийх, битүүмжлэх барьцаалах, хураах явцад түүний биедээ буюу ямар нэг газар, бус эгтгээдэд нуусан эд хөрөнгийг илрүүлэх зорилгоор тэдний бие болон тухайн газарт нэгжлэг хийж болно.

3. Шаардлагатай гэж үзвэл шийдвэр гүйцэтгэгч нь төлбөр төлөгчийн банкин дахь дансны зарлагын хөдөлгөөнийг тухайн э хөрөнгөөс төлбөрийг төлөхөд хүрэлцэхүйц хэмжээний эд хөрөнгийг битүүмжлэх буюу барьцаалж төлбөр төлөх хугацаагаар тогтоож өгнө.

4. Төлбөр төлөгчийн эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийж, түүний хөрөнгийн хэмжээг тогтоосны дараа тухайн банкинд мэдэгдэл өгө замаар төлбөр төлөх хүртэл хугацаагаар зогсоож болно.

5. Тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй бол битүүмжилсэ буюу барьцаалсан эд хөрөнгийг хураана.

6. Тогтоосон хугацаанд төлбөрийг төлсөн, эсхүл битүүмжилсэн барьцаалсан эд хөрөнгийг уг хугацаа дуусахаас өмнө чөлөөлөх туха шүүхийн шийдвэр гарсан бол эд хөрөнгийг буцааж олгоно.

24 дүгээр зүйл. Эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийх, түүнийг битүүмжлэх, барьцаалах, хураах ажиллагаа явуулах журам

1. Төлбөр төлөгчийн эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийх, түүнийг битүүмжлэх, барьцаалах, хураах ажиллагааг явуулахад уг хэрэг хувийн сонирхолгүй, эрх зүйн бүрэн чадамжтай, хөндлөнгийн гэрчийг байлцуулна. Хөндлөнгийн гэрч нь уг ажиллагааны яв агуулгыг баталж өгөх үүрэгтэй.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан ажиллагааг явуулахад төлбөр төлөгч, эсхүл түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, өмгөөлөгч хэрэв боломжгүй бол нутгийн захиргааны зохих байгууллагы төлөөлөгчийг байлцуулна.

3. Төлбөр төлөгч нь хуулийн этгээд байвал уг байгууллагын төлөөлөгчийг байлцуулна.

4. Шийдвэр гүйцэтгэгч нь эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийх, түүнийг битүүмжлэх, барьцаалах, хураах ажиллагааны явцад тэмдэглэл хөгөлж, байлцсан этгээдүүдээр гарын үсэг зуруулна. Тэмдэглэлд засвар оруулахаар санал гаргах эрхтэйг шийдвэр гүйцэтгэгч тэдэнд тайлбарлаж өгнө.

25 дугаар зүйл. Эд хөрөнгөөс төлбөр гаргуулах

1. Төлбөрийг төлбөр төлөгч иргэний хувийн өмчийн эд хөрөнгөөс гаргуулна. Төлбөр төлөгч хуулийн этгээдийн төлбөрийг гүүний банк дахь дансанд байгаа мөнгөн хөрөнгө, түүнцэн үл тэдлөх ба эд хөрөнгөөс гаргуулна.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эд хөрөнгө нь төлбөр төлөхөд сүрэлшэхгүй байвал төлбөр төлөгчийн дундаа хэсгээр буюу хамтран эмчлэх эд хөрөнгийн түүнд ногдох хэсгээс гаргуулна.

3. Төлбөр төлөгч ямар эд хөрөнгөө төлбөрт өгөх хүсэлтээ тавих эрхтэй бөгөөд шийдвэр биелүүлэхэд саад болохгүй бол энэ хүсэлтийг харгалзан үзнэ.

26 дугаар зүйл. Төлбөрт хураан авч болохгүй эд хөрөнгө

1. Төлбөр төлөгч иргэний зайлшгүй хэрэгцээт дараахь эд хөрөнгийг төлбөрт хураан авч болохгүй:

- 1/ зайлшгүй хэрэгцээт хоол, хүнсний зүйл;
- 2/ улирал бүрийн нэг ээлжийн хувилс;
- 3/ хүйтний улиралд түлээ, гүнш.

27 дугаар зүйл. Эд хөрөнгийг үнэлэх

Шийдвэр гүйцэтгэгч нь төлбөр төлөгчийн эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах, хураахдаа түүний чанар, хэрэгцээ, элэгдсэн байдал болон төлбөр төлөгчийн саналыг харгалзан орон нутгийн зах зээлийн тухайн үеийн ханшлар үнэлж, энэ тухай тэмдэглэл үйлдэнэ. Гухайн эд хөрөнгийг үнэлэхэд хүндрэл учирсан, гүйцэтгэгчээс огтоосон үнэлгээг төлбөр төлөгч зөвшөөрөхгүй байгаа тохиолдолд шинжээч томилж болно. Үнийн талаар гарсан маргаан, гомдлыг цүүх шийдвэрлэнэ.

28 дугаар зүйл. Эд хөрөнгийг хадгалах

1. Шийдвэр гүйцэтгэгч нь битүүмжилсэн, барьцаалсан, хураасан эд хөрөнгийг төлбөр төлөгч болон бусад этгээдэд хадгалуулж болно.

2. Хадгалагч эд хөрөнгийг хэвийн байдлаар арчлан хадгалах үрэтэй.

3. Эд хөрөнгө хадгалагч нь төлбөр төлөгч буюу түүний гэр үдлийн гишүүн биш бол хадгалсны хөлсийг тохиролцсоны дагуу авна. Мал, амьтан хадгалуулсны хөлсийг тэдгээрт зарцуулсан ардлыг тооцон авна.

4. Төлбөр төлөгчөөс хураасан үнэт металл, эрдэнийн чулуу, гадаад валютыг банкинд хадгалуулна.

29 дүгээр зүйл. Эд хөрөнгийг худалдан борлуулах

1. Хураагдсан эд хөрөнгийг хураагдсан эд хөрөнгө худалдах дэлгүүр болон үнэ хаялцуулах, зуучлах худалдаагаар худалдана. Шаардлагатай тохиолдолд орон нутгийн аллагдсан байршлаас хамаарч тасаг, хэсгийн даргын зөвшөөрлөөр шийдвэр гүйцэтгэгч нь хураагдсан эд хөрөнгийг өөрөө шууд худалдаж болно.

2. Үнэт металл, эрдэнийн чулуу, гадаад валют, үнэт цаасыг хууль тогтоомжид заасан журмын дагуу худалдана.

3. Галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх зүйлс, химийн хорт бодис зэрэг тусгай зөвшөөрөлтэйгээр олж авах зүйлийг холбогдох байгууллагад худалдах буюу шүүхийн шийдвэрийн дагуу шилжүүлнэ.

4. Эд хөрөнгийг, түүнийг хураахад тогтоосон үнийг харгалзан орон нутгийн зах зээлийн тухайн үеийн ханшаар үнэтж худалдана.

5. Эд хөрөнгийг хураан авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, хүнсний болон хурдан гэмтэж муудах зүйлийг мөн даруй худалдана. Энэ хугацаанд худалдаагүй эд хөрөнгийг төлбөр авагчид төлбөртөө тооцон авахыг санал болгох буюу төлбөр төлөгчид мэдэгдэн үнэ хямдруулан худалдаж болно. Төлбөр авагч авахаас татгалзсан буюу худалдаагдаагүй эд хөрөнгийг төлбөр төлөгчид буцан өгнө.

30 дугаар зүйл. Албадан биелүүлэх ажиллагааг баримтжуулах

1. Шийдвэр гүйцэтгэгч нь төлбөр төлөгчийн эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийх, түүнийг битүүмжлэх, барьцаалах, хураах, үнэтэх, худалдах, шилжүүлэх, хариуцагчийг тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэх зэрэг ажиллагаа явуулах бүрд акт үйлдэн /шаардлагатай үед жагсаалтыг хавсарган/ тэмдэглэл хөтөлж, уг ажиллагаанд оролцсон, байлцсан бүх этгээдээр гарын үсэг зуруулна.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан актын загварыг Шүүхийн шийдвэр биелүүлэх газрын дарга батална.

31 дүгээр зүйл. Албадан биелүүлэх ажиллагааны явцад

**холбогдох этгээдийг дуудах,
мэдэгдэл өгөх**

1. Шийдвэр гүйцэтгэгч нь албадан биелүүлэх ажиллагааны явцад төлбөр төлөгч, төлбөр авагч, холбогдох бусад этгээдийг мэдэгдэл хуудсаар дуудан ирүүлж асуух, тэдгээрээс баримт бичиг гаргуулан авч болох ба төлбөр төлөхийг шаардах, хөдөлмөрийн хэлс, орлогоос суутгал хийх хугацаатай мэдэгдлийг өгнө.

2. Шүүгч, шийдвэр гүйцэтгэгч нь төлбөр төлөгчийг дуудан ирүүлж, шийдвэрийг сайн дураар биелүүлэх мэдэгдлийг гардуулна.

3. Мэдэгдлийг гардуулан өгөх боломжгүй бол баталгаат шуудангаар илгээх буюу биечлэн хүргүүлнэ. Дуудах, мэдэгдэл хүргүүлэхэд

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 76 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

32 дугаар зүйл. Төлбөр төлөгчийн хөдөлмөрийн хөлс, бусад орлогоос төлбөр гаргуулах

1. Төлбөр нь төлбөр төлөгчийн сарын дундаж цалин, хөлс, түүнтэй адилтгах бусад орлогын 50 хувиас хэтрэхгүй хэмжээтэй, түүнчлэн эд хөрөнгөгүй нь тогтоогдсон, эд хөрөнгө нь төлбөрийг бүрэн төлж хүрэлцэхгүй байвал түүний цалин, хөлс, бусад орлогоос төлбөрийг гаргуулна.

2. Хөдөлмөрийн хөлс, тэтгэвэр, тэтгэмжээс өөр орлогын эх үүсвэргүй төлбөр төлөгчийн сарын цалин, тэтгэвэр, тэтгэмжийн 50 хувиас хэтрүүлэн суутгал хийж болохгүй. Үүнд шүүхийн шийдвэрээр засан хүмүүжүүлэх ажил хийх ял эдэлж байгаа төлбөр төлөгчийн хөдөлмөрийн хөлснөөс суутгаж байгаа суутгал хамаарахгүй.

33 дугаар зүйл. Төлбөр гаргуулж болохгүй орлого

Төлбөр төлөгчийн дараахь орлогоос төлбөр гаргуулж болохгүй:

1/ байгалийн гамшиг, гэнэтийн аюул, онцгой нөхцөл байдлын улмаас үзүүлж буй тусламж, хандив;

2/ албан томилолт болон өөр газар шилжин очсоны зардал;

3/ буцалтгүй олгосон нэг удаагийн эд хөрөнгийн болон мөнгөн тусламж;

4/ Тэтгэмжийн хуулийн дагуу олгож байгаа хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмжээс бусад тэтгэмж;

5/ донор болон эхийн сүүнд олгож буй нөхөн олговор;

6/ нэмэгдэл хоол, амралт, сувиллын эмчилгээ, хиймэл эрхтэн хийлгэхэд олгосон зардал;

7/ тахир дутуугийн нэгдүгээр зэрэгтэй тэтгэвэр авагчийн асрамжид зориулсан нэмэгдэл;

8/ хүүхдийн тэтгэлэг.

34 дүгээр зүйл. Цалин, бусад орлогоос төлбөр гаргуулах журам

1. Шийдвэр гүйцэтгэгч нь төлбөр төлөгчийн хөдөлмөрийн хөлс, бусад орлогоос нь суутгал хийлгүүлэхээр түүний ажиллаж, суралцаж байгаа буюу тэтгэвэр, тэтгэмж олгож байгаа аж ахуйн нэгж, байгууллагад мэдэгдлийг хүргүүлднэ.

2. Аж ахуйн нэгж, байгууллага мэдэгдлийг хүлээн авмагц төлбөр төлөгчөөс суутгалыг сар тутам зохих хувиар хийж, суутгасан өнгийг суутгал хийснээс хойш 3 хоногийн дотор төлбөр авагчид дууд олгох буюу мэдэгдэл өгсөн шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын дансанд шилжүүлднэ.

3. Шүүхийн шийдвэрийн дагуу гаргуулах төлбөрийг бусад төлбөрийн өмнө тэргүүн ээлжинд суутгана.

4. Төлбөр төлөгч ажлаас халагдвал халагдсан өдрөөс хойш 7 хоногийн дотор аж ахуйн нэгж байгууллага нь түүнээс төлбөрт суутгасан мөнгөний хэмжээ, тэрээр хаана шилжсэнийг мэдэгдэл тэмдэглэж шийдвэр гүйцэтгэгчид буцаана.

5. Хорих ял эдэлж байгаа ялтны төлбөрийг түүний хөрөнгө байгаа газраар төлүүлсний дараа дутуу хэсгийг төлүүлэхээр гүйцэтгэх баримт бичгийг ялтны ял эдэлж байгаа хорих ангийн захиргаанд явуулж, хөдөлмөрийн хөлснөөс нь суутгуулна. Хоригдож байх хугацаанд төлбөрийг бүрэн төлж дуусаагүй бол түүний суллагдсаны дараа гүйцэтгэх баримт бичиг, бусад холбогдох материалыг уг этгээдийн байнга оршин суух газрын хаягийн дагуу шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагад шилжүүлнэ.

35 дугаар зүйл. Мөнгөн хөрөнгөнөөс төлбөр гаргуулах журам

1. Хуулийн этгээдийн банкны дансан дахь мөнгөн хөрөнгөнөөс төлбөр гаргуулах мэдэгдлийг шийдвэр гүйцэтгэгч зохих банкинд хүргүүлэх бөгөөд түүнийг үндэслэн банк нь төлбөр төлөгчийн данснаас төлбөрийг гаргаж, заасан хугацаанд төлбөр авагчид олгох буюу мэдэгдэл өгсөн шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын дансанд шилжүүлнэ.

2. Төсөвт байгууллагын дансанд байгаа мөнгө нь төлбөрт хүрэлцэхгүй бол түүнийг санхүүжүүлдэг байгууллагад төлбөрийг гаргуулах мэдэгдлийг хүргүүлэх буюу дараагийн төсөвт нэмж тусгахыг шаардана.

36 дугаар зүйл. Хуулийн этгээдийн үйл ажиллагаа зогсоогдох үед төлбөр гаргуулах

1. Төлбөр төлөгч хуулийн этгээд дампуурах, татан буугдах, өөрчлөн байгуулагдах зэргээр үйл ажиллагаа нь зогсоогдох үед гүйцэтгэх баримт бичгийг татан буулгах комисс буюу хэрэг гүйцэтгэгчид шилжүүлнэ.

2. Татан буулгах комисс буюу хэрэг гүйцэтгэгч нь гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авмагц уг төлбөрийг тэргүүн ээлжинд гаргуулан төлбөр авагчид, эсхүл гүйцэтгэх баримт бичиг өгсөн шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын дансанд шилжүүлнэ.

37 дугаар зүйл. Төлбөр төлөгчийн бусдад байгаа эд хөрөнгө, мөнгөнөөс төлбөр гаргуулах

1. Шийдвэр гүйцэтгэгч нь төлбөр төлөгчийн эд хөрөнгө, мөнгө бусдад байгаа эсэхийг тодруулж, хэрэв байвал түүнээс төлбөрт шаардагдах хэмжээгээр гаргуулна.

2. Төлбөр төлөгчийн банкын дахь данснаас болон хадгаламжид байгаа үнэт металл, эрдэнийн чулуу, үнэт цэвс, мөнгө, түүнчлэн төлбөр төлөгчөөс бусдад, бусдаас төлбөр төлөгчид бэлэн ба бэлэн бусаар шилжүүлсэн хоорондын төлбөр тооцооны мөнгөнөөс төлбөр авч болно.

38 дугаар туйл. Төвөрхой үйл ажиллагаа гүйцэтгүүдэхээр хармуцагчид даалгасан шийдвэрийг биелүүлэх

1. Барилга, орон сууцнаас нүүдлэн гаргах, хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид шилжүүлэх зэрэг төвөрхой үйл ажиллагаа гүйцэтгүүдэх шийдвэрийг хармуцагч нь шүүхээс тогтоосон хугацаанд биелүүдээгүй бол гүйцэтгэгч албадан гүйцэтгэнэ.

2. Хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид шилжүүлэхдээ асран хамгаалах, харгалзан дэмжих байгууллагын төлөөлөгчийг байлцуулна.

3. Барилга, орон сууцнаас нүүдлэн гаргах тухай хугацаатай мэдэгдлийг сайн дураар биелүүдээгүй бол шийдвэр гүйцэтгэгч нь албадан нүүдлэх өдөр, цагийг тогтоосон мэдэгдлийг нүүн гарвал юух эггээдэд өгнө.

4. Нүүдлэн гаргах ажиллагааг нүүн гарч байгаа эггээд, хөнд-
лөнгийн 2 гэргийг байлцуулан, шаардлагатай бол цагдаа, орон сууц
шиглалтын байгууллагын төлөөлөгчийг оролцуулан гүйцэтгэнэ.

5. Нүүн гарах эггээд албадан нүүдлэх мэдэгдэлд заасан хугацаанд гүндэгтэн үзэх шалтгаангүйгээр гэртээ байхгүй байвал түүний эггүйд
ид хөрөнгийг нь битүүмжлэн, зохих эггээдэд тэдгэдуулахаар
үлээглэн өгч, барилга, орон сууцыг чөлөөлнө.

6. Шийдвэр биелүүдэх явцад барилга, орон сууцнаас албадан
нүүдлэх боломжгүй нөхцөл байдал илэрвал гүйцэтгэгч энэ тухай акт
йлдэж, гүйцэтгэх баримт бичгийг шүүхэд буцаана.

7. Шүүхийн шийдвэрээр аль ч улиралд албадан нүүдлэнэ.

8. Орон сууцнаас нүүн гарч байгаа эггээдэд өөр орон сууц
еггохоор шийдвэрт заасан бол гүйцэтгэгч тухайн байгууллагад уг
шийдвэрийг гүйцэтгэх хугацаатай мэдэгдэл явуулна.

39 дүгээр туйл. Ажилтныг урьдах ажил, албан тушаалд нь эгүүлэн тогтоох тухай шийдвэрийг биелүүдээгүйн холбогдол

Хууль бусаар хадгасан буюу шилжүүлэгдсэн ажилтныг ажилд нь
уюу урьдахь албан тушаалд нь эгүүлэн тогтоох тухай шүүхийн
шийдвэрийг биелүүдээгүй бол тухайн ажилтны ажилгүй байсан
угацааны цалин хөлс буюу бага цалин хөлстэй ажил хийж байсны
өрүүг шийдвэр гарсан өдрөөс түүнийг биелүүдэх өдөр хүртэл хуга-
цанд шийдвэр биелүүдээгүй буруутай албан тушаалтнаас гаргуулан

олгуулахаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 128 дугаар зүйлд заасан журмын дагуу шүүгч захирамж гаргана.

40 дүгээр зүйл. Гаргуулсан төлбөрийг олгох журам

1. Шийдвэр гүйцэтгэгч нь гаргуулсан төлбөрийн мөнгийг төлбөр авагч хуулийн этгээдийн банкин дахь дансанд бэлэн буюу бэлэн буцаар хийнэ. Дансны дугаар мэдэгдэхгүй байвал уг мөнгийг шийдвэр биелүүлэх байгууллагын дансанд оруулна.

2. Шийдвэр гүйцэтгэгч нь төлбөрт бэлнээр гаргуулсан мөнгийг төлбөр авагч иргэнд бэлнээр олгох буюу түүний хадгаламжийн дансанд шилжүүлнэ. Хэрэв төлбөр авагч ирэхгүй буюу хадгаламжийн данс нь мэдэгдэхгүй байвал мөнгийг шийдвэр биелүүлэх байгууллагын дансанд оруулна. Төлбөр төлөгчөөс илүү төлөгдсөн мөнгийг түүнд буцаан олгоно.

3. Гадаадад оршин суугаа /оршин байгаа/ төлбөр авагчид төлбөрийн мөнгийг шийдвэр биелүүлэх байгууллагын данснаас банкаар дамжуулан гадаад төлбөр тооцооны журмаар олгоно. Уг журмыг Хууль зүйн сайд Монголбанкттай хамтран батална.

41 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын данснаас мөнгө олгох

1. Тасаг, хэсгийн дарга нь дансанд мөнгө шилжиж ирсэн тохиолдолд төлбөр авагчид мэдэгдэх, мөнгийг олгох ажиллагааг 14 хоногийн дотор гүйцэтгэх бөгөөд төлбөр авагчийн овог, нэр, хаяг тодорхойгүй буюу буруу хаягаар шилжиж ирсэн бол тодруулах ажиллагаа хийнэ.

2. Дансанд мөнгө шилжүүдэгч нь төлбөр төлөгч, төлбөр авагчийн овог, нэр, хаягийг үнэн зөв, тодорхой бичих үүрэгтэй. Овог, нэр, хаягийг буруу бичсэнээс гарсан нэмэгдэл зардлыг буруутай этгээд харууцна.

42 дугаар зүйл. Хүүхдийн тэтгэлгийн мөнгийг олгох

Хүүхдийн тэтгэлгийн мөнгийг дараах журмаар олгоно:

1/ тэтгэлэг төлөгчийн цалин, түүнтэй адилтгах бусад орлогоос суутгал хийсэн аж ахуйн нэгж, байгууллагаас төлбөр авагчид шууд бэлнээр олгох буюу төлбөр авагчийн хадгаламжид шилжүүлнэ;

2/ шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын дансанд орж ирсэн тэтгэлгийн мөнгийг банкаар дамжуулан тэтгэлэг авагчид бэлнээр олгох буюу түүний хадгаламжийн дансанд, эсхүл өөрийнх нь заасан хуулийн этгээдийн дансанд шилжүүлнэ.

43 дугаар зүйл. Төлбөрийг бодитой биелүүлсэнд тооцох

Төлбөр төлөгчөөс гаргуулсан эд хөрөнгө, мөнгийг төлбөр авагчид хуульд заасан журмаар бүрэн олгосныг төлбөрийг бодитой биелүүлсэнд тооцож, гүйцэтгэх баримт бичгийг гаргана.

44 дүгээр зүйл. Төлбөр авагчдын шаардлагыг хангах дараалал

1. Төлбөр төлөгчөөс гаргуулсан эд хөрөнгө, мөнгө нь хэд хэдэн төлбөр авагчийн шаардлагыг нэгэн зэрэг хангахад хүрэлцэхгүй байвал гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авсан дарааллыг баримтлан төлбөр авагчдын шаардлагыг хангана.

2. Хэд хэдэн гүйцэтгэх баримт бичгийг нэг өдөр хүлээн авсан бол төлбөр авагч нэг бүрийн авах төлбөрийн хэмжээгээр хувь тэнцүүлэн бодно.

3. Хүүхдийн тэтгэлэг, бусдын амь нас, эрүүл мэндэд учирсан хохирлын төлбөрийг тэргүүн ээлжинд олгоно.

45 дугаар зүйл. Хаяг тодруулах буюу эрэн сурвалжлах ажлыгатаа

1. Төлбөр төлөгч шүүхийн шийдвэрт заасан хаягаа өөрчилснөө мэдэгдээгүйгээс түүний хаяг тодорхойгүй болсон тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч нь иргэний бүртгэл мэдээллийн, татварын, зохих нутгийн захиргааны болон холбогдох бусад байгууллагаас лавлагаа авч, тухайн хүний төрөл садангийн хүмүүсийг дуудан ирүүлж тайлбар гаргуулан, хаягийг тодруулна.

2. Төлбөр төлөгчийн хаягийг тогтоох боломжгүйгээс шүүхийн шийдвэр биелэгдэхгүйд хүрвэл шийдвэр гүйцэтгэгч нь холбогдох материалыг бүрдүүлж тухайн шүүхэд өгнө. Шүүгчийн захирамжаар төлбөр төлөгчийг эрэн сурвалжлах ажлыгатааг шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллага өөрийн хүчээр гүйцэтгэнэ.

46 дугаар зүйл. Гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаах

1. Гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид дараахь тохиолдолд буцаана:

- 1/ төлбөр авагч хүсэлт гаргасан бол;
- 2/ төлбөр гаргуулж болох эд хөрөнгө, орлого төлбөр төлөгчид байхгүй бол;
- 3/ төлбөр авагч нь шүүхийн шийдвэрт нэрлэн заасан эд өрөнгийг авахаас, түүнслэн төлбөрт гаргуулсан худалдаагүй эд өрөнгийг төлбөрт тооцон авахаас татгалзсан бол.

2. Төлбөр авагчийн хүсэлтээр буцааснаас бусад тохиолдолд гүйцэтгэх баримт бичгийг шүүгчийн зөвшөөрснөөр буцаана. Төлбөрт гаргуулж болох эд хөрөнгө, орлого төлбөр төлөгчид байхгүй ухай шийдвэр гүйцэтгэгчийн тэмдэглэлийг шүүгч батлан ювшөөрөхдөө төлбөр төлөгчийн эд хөрөнгийг зохих ёсоор итгүүмжилсэн, хураасан, бүрэн борлуулсан эсэх, нуусан эд өрөнгийг олж илрүүдэх талаар шаардлагатай арга хэмжээ авсан үзэхийг хянах үүрэгтэй.

3. Гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаасан нь шийдвэрийг биелүүлэхээр дахин ирүүлэхэд саал болохгүй.

47 дугаар зүйл. Гүйцэтгэх баримт бичгийг ирүүлсэн газарт буцаах

Гүйцэтгэх баримт бичиг буруу бичигдсэнээс шийдвэр биелүүлэх боломжгүй байгаа бол түүнийг ирүүлсэн газарт нь буцаана.

48 дугаар зүйл. Шийдвэр биелүүлэх ажиллагааг түдгэлзүүлэх

1. Шийдвэр биелүүлэх ажиллагааг шүүгч дараахь үндэслэл, хутагцаагаар түдгэлзүүлнэ:

1/ төлбөр төлөгч эсвэл төлбөр авагч иргэн нас барсан буюу хуулийн этгээдийн үйл ажиллагаа зогссон үед тэдгээрийн эрх, үүрэг бусдад шилжих ёстой бол нийнхүү шилжих хүртэл;

2/ төлбөр төлөгч нь хүнд өвчний учир эмнэлэгт хэвтэж эмчлүүлж байгаа бол эмнэлгээс гарах хүртэл;

3/ төлбөр төлөгчийн хаягийг тодруулах буюу эрон сурвалжилж байгаа бол олох хүртэл;

4/ битүүмжилсэн эд хөрөнгийг чөлөөтүүлэх тухай нээхэмжлэл гарсан бол шийдвэр гаргал;

5/ шийдвэр биелүүлэх ажиллагааны талаар гомдол гарсан бол түүнийг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгал.

2. Шийдвэр гүйцэтгэгч нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл илэрвэл шүүгчид мэдэгдэнэ.

3. Түдгэлзүүлэх шалтгаан арилмагц төлбөр авагчийн буюу шийдвэр гүйцэтгэгчийн хүсэлтээр шүүгч захирамж гарган, биелүүлэх ажиллагааг сэргээнэ.

49 дүгээр зүйл. Шийдвэр биелүүлэх ажиллагааг хэрэгсэхгүй болгох

1. Шүүгч дараахь тохиолдолд захирамж гарган, шийдвэр биелүүлэх ажиллагааг хэрэгсэхгүй болгоно:

1/ төлбөр авагч нь төлбөр авахаас татгалзвал түүний хүсэлтээр;

2/ төлбөр төлөгч, төлбөр авагч хоорондоо ээлзрвэл тэдгээрийн гаргасан тодорхойлолтоор;

3/ төлбөр төлөгч, төлбөр авагч иргэн нас барсан, хуулийн этгээдийн үйл ажиллагаа зогссоны дараа түүний эрх, үүрэг нь эрх залгамжлагчид шилжээгүй бол;

4/ шийдвэр хүчингүй болбол.

2. Шийдвэр биелүүлэх ажиллагааг хэрэгсэхгүй болговол гүйцэтгэх баримт бичигт энэ тухай тэмдэглэл үйлдэж төлбөр авагчид хүргүүлнэ.

3. Нэгэнт хэрэгсэхгүй болгосон шийдвэр биелүүлэх ажиллагааг дахин сэргээхгүй.

**50 дугаар зүйл. Шийдвэр гүйцэтгэгч бэлэн мөнгө хүлээн авах,
олгох**

1. Шийдвэр гүйцэтгэгч төлбөрт бэлэн мөнгө хүлээн авах, түүнийг төлбөр авагчид олгоходоо баримтыг тухай бүр хоёр хувь үйлдэж, үйлдсэн огноог бичиж, гарын үсэг зуруулан, нэг хувийг нь төлбөр төлөгч болон төлбөр авагчид өгнө.

2. Бэлэн мөнгө хүлээн авсан баримт нь ямар нэгэн засваргүй байна. Бэлэн мөнгө хүлээн авах баримт нь нэгдсэн дугаартай, хэвлэмэл маягт байна.

3. Шийдвэр гүйцэтгэгч нь хүлээн авсан бэлэн мөнгийг нийслэл, дүүрэг, хороодод буюу аймаг, сумын төвд 24 цаг, бусад газарт 7 хоногийн дотор төлбөр авагчид олгох буюу шийдвэр биелүүлэх байгууллагын дансанд шилжүүлнэ.

**51 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын
дансанд мөнгө хадгалах**

1. Төлбөр авагчийн хаяг тодорхойгүйгээс олгогдоогүй мөнгийг шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын дансанд, нийтэд зарласнаас хойш дараахь хугацаанд хадгална:

1/ иргэнд олгох бол 3 жил;

2/ хуулийн этгээдэд шилжүүлэх бол 1 жил.

2. Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын дансанд байгаа мөнгийг өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаа өнгөрсөн тохиолдолд мөнгийг улсын төсвийн орлогод шилжүүлнэ.

4. Төлбөр авагчийн хаяг буюу дансны дугаар тодорхой болбол энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар улсын орлогод оруулсан мөнгийг хугацаа харгалзахгүйгээр буцааж олгоно.

**52 дугаар зүйл. Шийдвэр албадан биелүүлэх
ажиллагааны зардал**

1. Шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэхтэй холбогдсон бүх зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

2. Төлбөр төлөгчийн эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах, хураах, хадгалах, гэвэрлэх, шилжүүлэх, худалдан борлуулах, нуусан эд хөрөнгийг илрүүлэх ажиллагааны зардлыг төлбөр төлөгчөөс нөхөн гаргуулж, шийдвэр биелүүлэх байгууллагын дансанд оруулна.

3. Шийдвэр гүйцэтгэгч энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан ажиллагааны тэмдэглэлд уг ажиллагааны үед гарсан зардлыг тооцож, төлбөр төлөгчөөр гарын үсэг зуруулна.

4. Төлбөр төлөгч нь зардлын хэмжээг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргаж болно.

53 дугаар зүйл. Биелэгдсэн шийдвэрийг цуцлах

1. Биелэгдсэн шийдвэр хүчингүй болсон бол уг шийдвэрээр

төлбөр авагчид олгогдсон бүх зүйлийг эгүүдэн гаргуулж төлбөр төлөгчид буцаан олгох буюу тийм боломжгүй бол буцаан олгох үеийн ханшаар үнийг төлнө.

2. Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, торгох, эд хөрөнгө хураах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, ял шийтгэгдсэн этгээдийг цагаатгах шийдвэр гарсан бол хөдөлмөрийн хөлснөөс хийсэн суутгал, торгуулийн мөнгө, хураасан эд хөрөнгө буюу түүний үнийг буцаан олгох үеийн ханшаар тооцож буцааж олгоно.

54 дүгээр зүйл. Торгох ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх

1. Торгох ял оногдуулсан шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болмогц ялтан 14 хоногийн дотор шийдвэрийг сайн дураар биелүүлэх үүрэгтэй.

2. Ялтан энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаанд торгуулийн мөнгийг төлөөгүй буюу бүрэн төлөөгүй тохиолдолд шүүгч гүйцэтгэх хуудас бичиж, шийдвэрийн хамт ялтны оршин суугаа буюу ажиллаж байгаа, эсхүл эд хөрөнгө нь байгаа газрын шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагад нэн даруй хүргүүлнэ.

3. Шийдвэр гүйцэтгэгч торгуулийн мөнгийг 14 хоногийн дотор шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын дансанд тушаах, үл хугацаанд торгууль төлөөгүй буюу бүрэн төлөөгүй бол ялыг албадан биелүүлэхийг 7 хоногийн дотор ялтанд мэдэгдэх хуудсаар мэдэгдэнэ.

4. Ялтан торгуулийн мөнгийг бүрэн тушааснаар торгох ялыг бодитой биелүүлсэнд тооцож, шийдвэр гүйцэтгэгч энэ тухай шийдвэр гаргасан шүүх болон ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж байгаа прокурорт мэдэгдэнэ.

55 дугаар зүйл. Торгох ялыг албадан биелүүлэх

Ялтан энэ хуулийн 54 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан хугацаанд торгуулийг төлөөгүй буюу бүрэн төлөөгүй бол шийдвэр гүйцэтгэгч энэ бүлэгт заасан журмын дагуу торгуулийн мөнгийг ялтны эд хөрөнгөөс албадан гаргуулна.

56 дугаар зүйл. Торгох ялыг хорих ялаар сольх санал гаргах

1. Ялтан эд хөрөнгө, цалин, орлогоо нуух, бусдад хууль бусанг шилжүүлэх, үрэгдүүлэх, шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэлгүйгээр байнга оршин суугаа газраа өөрчлөх зэргээр ял эдлэхээс ноцтойгоор зайлсхийвэл шийдвэр гүйцэтгэгч зохих шалгалт явуулж, торгох ялыг хорих ялаар сольх тухай саналыг шүүхэд гаргана.

2. Шийдвэр гүйцэтгэгчийн санал, прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх Эрүүгийн хуулийн 29 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу торгох ялыг хорих ялаар сольж болно.

57 дугаар зүйл. Шүүхийн шийдвэрийн эд хөрөнгө хураах болон бусад заалтыг биелүүлэх

1. Эд хөрөнгө хураах нэмэгдэл ял оногдуулсан шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болмогц шүүх шийдвэрийн хувь, гүйцэтгэх хуудас, эд хөрөнгө дансалсан буюу битүүмжилсэн актыг ялтны эд хөрөнгө байгаа газрын шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагад нэн даруй хүргүүлнэ.

2. Шийдвэр гүйцэтгэгч нь эд хөрөнгө хураах ял биелүүлэхдээ гүйцэтгэх хуудсыг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор энэ хуульд заасан журмын дагуу эд хөрөнгийг битүүмжилж, бусад ажиллагааг 30 хоногийн дотор дуусгавар болгоно.

3. Дундаа хэсгээр буюу хамтран өмчлөх эд хөрөнгөөс тодорхой эд хөрөнгийг хураахаар шүүхийн шийдвэрт нэрлэн заасан бол түүнийг хураана.

4. Шүүхийн шийдвэрт заасан эд хөрөнгийг бүрэн хурааж улсын орлогод оруулснаар эд хөрөнгө хураах ялыг бодитой биелүүлсэнд тооцож, шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх хуудсыг хааж, шийдвэр гаргасан шүүхэд мэдэгдэнэ.

58 дугаар зүйл. Эд хөрөнгө хураах ялыг биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлага

1. Шүүхийн шийдвэрт хураахаар заасан эд хөрөнгийг үрэгдүүлсэн, нуусан, бусдад шилжүүлсэн, завшсан гэм буруутай этгээдэд хуульд заасны дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас тухайн эд хөрөнгийг хураах боломжгүй болсон бол түүний үнийг хуульд заасан журмын дагуу нөхөн төлүүлж, улсын орлогод оруулна.

59 дүгээр зүйл. Захиргааны зөрчил гаргасан этгээдэд торгууль, төлбөр ногдуулсан шийтгэврийг биелүүлэх

Захиргааны зөрчил гаргасан этгээдээс торгууль, төлбөр гаргуулах талаар Захиргааны харнуцлагын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан албан тушаалтны гаргасан шийтгэврийг албадан биелүүлэх ажиллагааг шийдвэр гүйцэтгэгч энэ бүлэгт заасан журмаар биелүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Шүүхийн зарим төрлийн шийдвэрийг бусад байгууллагаас биелүүлэх үйл ажиллагаа

60 дугаар зүйл. Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх

1. Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял оногдуулсан шүүхийн

шийдвэр хүчин төгөлдөр болмогц шүүх шийдвэрийн хувийг засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг эдлүүлэхээр заасан аж ахуйн нэгж, байгууллагын захиргаа, шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагад тус тус хүргүүлнэ.

2. Аж ахуйн нэгж, байгууллагын захиргаа дор дурдсан үүрэг хүлээнэ:

1/ шүүхийн шийдвэр хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор ялтныг эрхэлж байсан ажил, албан тушаалд нь үлдээх, эсхүл аж ахуйн нэгж, байгууллага дотроо өөр ажил, албан тушаалд шилжүүлэн ажиллуулах эсэхийг хууль тогтоомжид заасан журмын дагуу шийдвэртэй, хамт олонд мэдээлэх;

2/ ял эдлэх хугацааны турш ялтны хөдөлмөрийн хөлснөөс шүүхийн шийдвэрт заасан хэмжээгээр суутгал хийх;

3/ ялтанд хууль тогтоомжийн дагуу оногдуулсан сахилгын шийтгэл болон сайшаал, урамшууллын талаар шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэж байх;

4/ ялтны хүсэлтээр хөдөлмөрийн гэрээг цуцлахгүй, ял эдлэх хугацаанд нь ээлжийн амралт олгохгүй байх;

5/ ялтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээг Хөдөлмөрийн хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 4-т заасан үндэслэлээр цуцлахад хүрвэл түүнийг ажлаас өөрчилсөн, чөлөөлсөн тухай шийдвэр гүйцэтгэгчид нэн даруй мэдэгдэх.

3. Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял эдлүүлэхэд хяналт тавих журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн Хууль зүйн сайд тогтооно.

61 дүгээр зүйл. Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял эдэлж байгаа ялтны хөдөлмөрийн хөлснөөс суутгал хийх

Аж ахуйн нэгж, байгууллагын захиргаа ялтны хөдөлмөрийн хөлснөөс суутгал хийхдээ дараахь журмыг баримтална:

1/ суутгалыг ажилласан сар бүрийн сүүлчийн хөдөлмөрийн хөлснөөс, харин ажлаас халах үед тухайн сард ажилласан хугацааны цалин, хөлснөөс хийнэ;

2/ ялтан ажил хавсран хийж байгаа бол ажил олгогч тус бүр хөдөлмөрийн хөлснөөс суутгал хийнэ;

3/ хөдөлмөрийн хөлснөөс суутгасан мөнгийг гүйцэтгэх хуудас байгаа шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын дансанд шилжүүлнэ.

62 дугаар зүйл. Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял эдлэх хугацааг тооцох тухай

1. Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял эдлэх хугацааг ялтны хөдөлмөрийн хөлснөөс суутгал хийсэн сар, өдрөөр тооцно.

2. Ялтан шүүхээс оногдуулсан ялын хугацаанд ногдох ажлын өдрөөс цөөнгүй өдөр ажигласан байвал зохих бөгөөд ажиллагүй өдрийг энэ хуульд зааснаар ял эдэлсэн хугацаанд оруулан тооцох үндэслэлгүй байвал дутуу ажлын өдрийг нөхөн ажиллуулна.

3. Жирэмсний болон амаржсаны амралт, хүүхэд асрах чөлөөтэй байсан хугацааг ял эдэлсэн хугацаанд оруулан тооцно.

4. Ял эдлэх хугацаанд согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх, хуурамчлар өвчлөх, бие эрхтэн, эрүүл мэнддээ санзатайгаар гэмтэл учруулах, захиргааны журмаар баривчлагдах, албадан сануулагдах, цагдан хоригдсоны улмаас ажиллагүй зугаааг ял эдэлсэн хугацаанд оруулан тоонохгүй.

5. Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял эдлэх хугацаа дууссан бол тухайн өдрөөс, хуульд заасан бусад үндэслэлээр ялаас чөлөөтсөн бол энэ тухай баримт бичгийг ялны ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад ирсэн өдрөөс эхлэн хуулиар тогтоосон эрхийн хязгаарлалтыг зогсооно.

63 дугаар зүйл. Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг өөр төрлийн ялаар сольх

1. Шүүхийн шийдвэр гарсны дараа ялныг хөдөлмөрийн чадвараа байнга буюу удаан хугацаагаар алдсанд тооцсон, ялтан хөдөлмөрт үнэнч шударга хандаж засарч хүмүүжсэнээ баттай харуулж чадсан, гүүнчлэн аж ахуйн нэгж, байгууллагын захиргаа Хөдөлмөрийн хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 4-т заасан үндэслэлээр хөдөлмөрийн гэрээг цуцалсан бол засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг өөр төрлийн хөнгөн ялаар сольж буюу ялыг хугацааны өмнө тэнсэх тухай саналыг шийдвэр гүйцэтгэгч шүүхэд гаргана.

2. Шийдвэр гүйцэтгэгчийн санал, прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх Эрүүгийн хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг тэнсэх буюу өөр төрлийн хөнгөн ялаар сольж болно.

3. Ялтан хөдөлмөрийн сахилгыг удаа дараа зөрчих, хөдөлмөрийн гэрээг шууд цуцлахаар зөрчил гаргах, ажлаа дур мэдэн орхих зэргээр ял эдлэхээс ноцтой зайлсхийвэл аж ахуйн нэгж, байгууллага энэ тухай шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэх бөгөөд шийдвэр гүйцэтгэгч зохих шалгалт хийж, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг хорих ялаар сольж тухай саналаа холбогдох баримт бичгийн хамт шүүхэд ирүүлнэ.

4. Шийдвэр гүйцэтгэгчийн санал, прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх Эрүүгийн хуулийн 27 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг хорих ялаар сольж болно.

64 дүгээр зүйл. Тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх

1. Тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах ялыг үндсэн болон хорихоос өөр төрлийн ялд нэмэгдэл ялын чанартай оногдуулсан шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болмогц шүүх шийдвэрийн хувийг уг албан тушаалд томилсон, сонгосон, эсхүл тодорхой үйл ажиллагаа явуулах эрх олгосон төрийн захиргааны болон бусад байгууллагад хүргүүлж, ялтны оршин суугаа газрын цагдаагийн байгууллагад энэ тухай бичгээр мэдэгдэнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шүүхийн шийдвэр хүлээн авсан байгууллага ялтныг тухайн албан тушаалд томилсон, сонгосон, эсхүл тодорхой үйл ажиллагаа явуулах эрх олгосон шийдвэрээ хүчингүй болгож, шаардлагатай бол мэргэжлийн үнэмлэх, тодорхой үйл ажиллагаа явуулах эрх олгосон баримт бичгийг нь хураан авч, энэ тухай шийдвэр гаргасан шүүх болон ялтны оршин суугаа газрын цагдаагийн байгууллагад 10 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

3. Тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах ялыг хорих ялд нэмэгдэл ялын чанартай оногдуулсан бол хорих анги ялтныг суллагдмагц шүүхийн шийдвэрийн хувь, шаардлагатай бол хувийн бичиг баримтыг ялтны оршин суух газрын цагдаагийн байгууллагад нэн даруй хүргүүлнэ.

4. Цагдаагийн байгууллага нь энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасны дагуу ирүүлсэн мэдэгдэл, шүүхийн шийдвэр, баримт бичгийг хүлээн авмагц ялтныг дуудан ирүүлж, ялын хугацаанд шүүхээс хориглосон албан тушаал эрхлэх буюу үйл ажиллагаа явуулж болохгүйг түүнд анхааруулж, ял эдлэлтийн байдалд тавих хяналтын хэрэгжүүлнэ.

5. Тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах ял шийтгүүлсэн этгээд ял эдлэх хугацаанд шинээр өөр ажил, албан тушаалд орох буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх бол цагдаагийн байгууллагаас зөвшөөрөл авна.

6. Тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах ял эдлүүлэхэд хяналт тавих журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн Хууль зүйн сайд тогтооно.

65 дугаар зүйл. Тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах ял биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцагыг

Тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа

явуулах эрх хасах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг биелүүлдэггүй этгээдэд Эрүүгийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

66 дугаар зүйл. Тэнсэгдсэн ялтныг хянан харгалзах

1. Хорих буюу засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг тэнсэж хянан харгалзах тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болмогц шийдвэрийн хувийг ялтны оршин суугаа газрын цагдаагийн, эсхүл цэргийн анги, байгууллагад хүргүүлж, харьяа сум, дүүргийн Засаг дарга болон уг этгээдийн ялыг тэнсэх тухай хүсэлт гаргасан буюу хараа хяналтдаа байлгаж хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн аж ахуйн нэгж, байгууллага буюу иргэнд ялыг тэнссэн тухай бичгээр мэдэгдэнэ.

2. Ялыг тэнсэх тухай хүсэлт гаргасан буюу хараа хяналтдаа байлгаж хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн аж ахуйн нэгж, байгууллага, иргэн тэнсэгдсэн ялтанг хянан харгалзах хугацааны турш уг ялтны хөдөлмөр эрхлэлт, засрал, хүмүүжлийн байдлыг хариуцаж, энэ талаар цагдаагийн байгууллагад үнэн зөв мэдээлэл өгч байх үүрэгтэй.

3. Сум, дүүргийн Засаг дарга өөрийн эрх хэмжээнд хамаарах асуудлын хүрээнд тэнсэгдсэн ялтанд туслалцаа үзүүлж, ялтныг хүмүүжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч, шаардлагатай бол түүний засрал хүмүүжлийн байдал, гаргасан зөрчлийн талаар цагдаагийн байгууллагатай мэдээлэл солилцоно.

4. Тэнсэгдсэн ялтныг хянан харгалзах талаар цагдаагийн байгууллага дараахь үүрэг хүлээнэ:

1/ шийдвэрийн хувийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор хяналтын хувийн хэрэг нээж, ялтныг тэнсэх тухай хүсэлт гаргасан буюу хараа хяналтдаа байлгаж хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөгч буюу иргэнийг дуудан уулзаж, тэдгээрийн эрх, үүрэг, ялтанд хууль, шүүхийн шийдвэрээр тогтоосон хязгаарлалт, даалгасан үүргийг танилцуулах;

2/ ялтан, түүнийг тэнсэх тухай хүсэлт гаргасан, хараа хяналтдаа байлгаж хүмүүжүүлэхийг зөвшөөрсөн аж ахуйн нэгж, байгууллагын захиргаа буюу иргэнд үүргээ биелүүлэх талаар шаардлага тавьж, биелэлтийг хангуулах;

3/ ялтны засрал хүмүүжил, шүүхээс даалгасан үүргийн биелэлтийн талаар сар тутам хяналтын хувийн хэрэгт тэмдэглэл гийх;

4/ хянан харгалзах хугацаа дуусмагц энэ тухай шүүх болон тэнсэгдсэн этгээдэд бичгээр мэдэгдэх.

5. Цэргийн албан хаагчид оногдуулсан ялыг тэнссэн бол хянан харгалзах үүргийг цэргийн анги, байгууллага энэ хуульд заасан журмын дагуу гүйцэтгэнэ.

**67 дугаар зүйл. Ял тэнссэнийг хүчингүй болгож,
ялыг биелтэн эдлүүлэх**

1. Ялтан нь хянан харгалзах хугацаанд хөдөлмөрийн сахилга, нийгмийн хэв журмыг зөрчсөн, эсхүл захиргааны шийтгэлийн буку сахилгын арга хэмжээ авагдсан бол ял тэнссэнийг хүчингүй болгож, шүүхийн шийдвэрээр оногдуулсан ялыг биелтэн эдлүүлэх тухай аж ахуйн нэгж, байгууллага, иргэн хүсэлтээ, Засаг дарга, цагдаагийн байгууллага саналаа ялсны оршин суугаа газрын шүүхэд гаргана.

2. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хүсэлт, Засаг дарга, цагдаагийн байгууллагын санал, прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх Эрүүгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 6, 7 дахь хэсэгт заасны дагуу ял тэнссэнийг хүчингүй болгож, шүүхийн шийдвэрээр оногдуулсан ялыг биелтэн эдлүүлэхээр шийдвэрлэж болно.

**68 дугаар зүйл. Хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэр
биелүүлэхийг хойшлуулсан насанд хүрээгүй
ялтныг хянан харгалзах**

1. Шүүх насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэр биелүүлэхийг хойшлуулсан бол шийдвэрийн хувийг ялсны оршин суугаа газрын цагдаагийн байгууллагад нэн даруй хүргүүлж, сум, дүүргийн Засаг дарга, ялтныг хараа хяналтдаа байлгаж хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн аж ахуйн нэгж, байгууллага буюу иргэнд энэ тухай бичгээр мэдэгдэнэ.

2. Насанд хүрээгүй этгээдийг хянан харгалзах талаар цагдаагийн байгууллага дараахь үүрэг хүлээнэ:

1/ шийдвэрийн хувийг хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногт багтаан хяналтын хувийн хэрэг нээж, ялтан, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, түүнчлэн ялтныг хараа хяналтдаа байлгаж хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөгч буюу иргэнийг дуудан уулзаж, тэдгээрийн эрх, үүрэг, ялтанд хууль, шүүхийн шийдвэрээр тогтоосон хязгаарлалт, даалгасан үүргийг танилцуулах;

2/ ялтны эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хараа хяналтдаа байлгаж хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн аж ахуйн нэгж, байгууллага буюу иргэнд үүргээ биелүүлэх талаар шаардлага тавьж, биелэлтийг хангуулах;

3/ ялтны сахилга, засрал хүмүүжил, шүүхээс даалгасан үүргийн биелэлтийн талаар сар тутам хяналтын хувийн хэрэгт тэмдэглэл хийх;

4/ шүүхийн шийдвэр биелүүлэхийг хойшлуулсан хугацаа дуусмагч энэ тухай шүүх болон ял шийтгүүлсэн этгээдэд бичгээр мэдэгдэх.

3. Засаг дарга ялтанд боловсрол, мэргэжил эзэмшихэд нь зохих туслалцаа үзүүлж, ялтны сахилга, шүүхээс даалгасан үүргийн биелэлт, засрал хүмүүжлийн байдлыг шалгин танилцаж, шаардлагатай бол цагдаагийн байгууллагатай мэдээлэл солилцоно.

4. Ялтны эцэг, эх, эсрэн хамгаалагч, харгалзан дэмжигч, хараа хяналтаа байлгаж хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн аж ахуйн нэгж, байгууллага буюу иргэн, түүний засрал хүмүүжлийн байдлыг хариуцан, эрх зүйн хүмүүжил олгох, иргэнийхээ үүргийг шударгаар биелүүлдэг болгон хүмүүжүүлэх, сурч боловсрох, хөдөлмөр эрхлэх нөхцөлөөр хангах арга хэмжээ авах үүрэгтэй.

69 дүгээр зүйл. Насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэр биелүүлэхийг хойшлуулсныг хүчингүй болгох, ялаас чөлөөлөх

1. Хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэр биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд ялтан өөрийн засарч хүмүүжсэнээ үлгэр жишээ зан төлөв, сурлага, хөдөлмөрт үнэнч шударга хандлагаараа харуулбал түүнийг ялаас чөлөөлөх тухай саналыг зохих шатны Засаг дарга, эсхүл цагдаагийн байгууллага шүүхэд гаргаж болно.

2. Ялтан шүүхээс даалгасан болон энэ хуульд заасан үүргээ биелүүлдэггүй, хараа хяналтаа байлгаж хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн аж ахуйн нэгж, байгууллага буюу иргэний итгэл найдаарыг хөсөрдүүлсэн, эсхүл нийгмийн хэн журам зөрчиж, захиргааны арга хэмжээ авагдсан бол хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэр биелүүлэхийг хойшлуулсныг хүчингүй болгож, хорих ялыг биечтэн эдлүүдэх тухай Засаг дарга, цагдаагийн байгууллага саналаа, аж ахуйн нэгж, байгууллага буюу иргэн хүсэлтээ шүүхэд гаргана.

3. Хараа хяналтаа байлгаж хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хүсэлт, цагдаагийн байгууллага, Засаг даргын санал, прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх насанд хүрээгүй ялтныг ялаас чөлөөлөх, эсхүл хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэр биелүүлэхийг хойшлуулсныг хүчингүй болгож, шүүхийн шийдвэрээр оногдуулсан хорих ялыг биечтэн эдлүүдэхээр шийдвэртэй болно.

70 дугаар зүйл. Тэнсэгдсэн болон хорих ял нь шүүхийн шийдвэрээр хойшлогдсон ялтанд хяналт тавих

Хорих, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг тэнсэж хянан саргалзсан болон хорих ял нь шүүхийн шийдвэрээр хойшлогдсон ялтны засрал хүмүүжилд хяналт тавих журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн Хууль зүйн сайд тогтооно.

71 дүгээр зүйл. Сэтгэшийн өвчтэй буюу согтуурах, мансуурах донтой этгээдэд албадан эмчилгээний чанартай арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг биелүүлэх

1. Хэрэг хариуцах чадваргүй үедээ гэмт хэрэг үйлдсэн, эсхүл хэрэг хариуцах чадвартай байхдаа гэмт хэрэг үйлдсэн боловч шүүхийн шийдвэр гарахын өмнө буюу ял эдэлж байх үедээ сэтгэшийн өвчнөөр өвчилж, өөрийн үйлдлийг хариуцаж буюу жолоодож чадахгүй болсон этгээд, түүнчлэн гэмт хэрэг үйлдсэн согтуурах, мансуурах донтой этгээдэд албадан эмчилгээний чанартай арга хэмжээ хэрэглэхээр шийдвэртэсэн бол шүүх уг этгээдийг сэтгэл мэдрэлийн ердийн буюу тусгай эмнэлгийн алинд байлгахыг шийдвэртээ заана.

2. Албадан эмчилгээний чанартай арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болмогц уг этгээдийг албадан эмчлэх байгууллагад хүргэх үүргийг цагдаагийн, хэрэв уг этгээд хорих ял эдэлж байсан бол хорих ял эдлүүлэх байгууллага тус тус хүлээх бөгөөд шүүхийн шийдвэр, шүүхийн сэтгэц-гэм судлалын шинжилгээний дүгнэлт, холбогдох бусад бичиг баримтыг хамтад нь хүргүүлнэ.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан этгээдийн эмчилгээний зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

4. Албадан эмчлүүлж байгаа этгээд гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эмнэлгийн болон цагдаагийн байгууллага хамтран авна.

5. Албадан эмчлүүлэх байгууллага дор дурдсан үүрэг хүлээнэ:

1/ албадан эмчлүүлж байгаа этгээдэд зайлшгүй шаардлагатай шинжилгээ, эмчилгээг цаг тухайд нь хийж, эмчилгээний явцыг өвчний түүхэнд үнэн зөв, тодорхой бичнэ;

2/ эмчилгээний үр дүн, өвчний шинж байдлыг харгалзан уг этгээдийг цаашид албадан эмчлэх шаардлагатай эсэхийг сэтгэц-гэм судлалын болон холбогдох мэргэжлийн эмч нарын зөвлөлтөөнөөр хэлэлцүүлж дүгнэлт гаргуулах, уг арга хэмжээг цаашид хэрэглэх шаардлагагүй гэж үзвэл энэ тухайгаа шүүхэд нэн даруй мэдэгдэх;

3/ албадан эмчилгээний чанартай арга хэмжээ хэрэглэхийг зогсоох тухай шүүхийн шийдвэр хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор албадан эмчлүүлсэн этгээдийг шүүхийн шийдвэрт заасан байгууллага, хууль ёсны төлөөлөгчид хүлээлгэн өгөх.

6. Албадан эмчлүүлж байгаа этгээдийн хууль ёсны төлөөлөгч өмгөөлөгчийн хүсэлт, прокурорын саналаар энэ зүйлийн 5 дэх хэсгийн 2-г заасан дүгнэлтийг албадан эмчлэх хугацаа дуусахаас өмнө гаргуулж болно.

7. Албадан эмчлэх нөхцөл журмыг эрүүл мэнд, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, албадан эмчлэх эмнэлгийн хамгаалалтын журмыг Хууль зүйн сайд тус тус Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн батална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Хорих байгууллага, хорих ял эдлүүлэх нөхцөл, журам

72 дугаар зүйл. Хорих байгууллага

1. Хорих байгууллага нь насанд хүрээгүйчүүдийн болон насанд хүрэгчдийн хорих анги, гяндан /цаашид "хорих анги" гэх/, тэдгээртэй адил дэглэм бүхий байгууллагаас бүрдэнэ.

2. Хорих анги нь Шүүхийн шийдвэр биелүүлэх газрын, эсхүл, аймаг, нийслэлийн харьяалалтай байна.

3. Хорих ангитай адил дэглэм бүхий байгууллага гэдэгт хорихын нэгдсэн эмнэлэг /цаашид "нэгдсэн эмнэлэг" гэх/, хугацаагүй хорих тусгай салбар, дамжин өнгөрүүлэх анги хамаарна.

4. Гяндан, хугацаагүй хорих тусгай салбар, дамжин өнгөрүүлэх анги, нэгдсэн эмнэлэг, чанга, онцгой дэглэмтэй хорих ангийг төвлөрсөн хэлбэрээр Шүүхийн шийдвэр биелүүлэх газрын харьяанд байгуулна.

73 дугаар зүйл. Хорих анги байгуулах, өөрчлөх, татав буулгах

1. Төвлөрсөн буюу бүсчилсэн хорих анги байгуулах, өөрчлөх, татав буулгах асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

2. Жирийн дэглэмтэй хорих ангийг Хууль зүйн сайд Засаг даргатай зөвшилцсөн саналыг үндэслэн аймаг, нийслэлийн харьяанд байгуулна.

3. Шаардлагатай бол жирийн дэглэмтэй хорих ангийг Хууль зүйн сайдын саналыг үндэслэн төвлөрсөн буюу бүсчилсэн хэлбэрээр шийдвэр биелүүлэх газрын харьяанд байгуулж болно.

4. Гяндан, хугацаагүй хорих тусгай салбар, дамжин өнгөрүүлэх анги, нэгдсэн эмнэлэг, чанга, онцгой дэглэмтэй хорих ангийг Хууль зүйн сайдын саналыг үндэслэн Шүүхийн шийдвэр биелүүлэх газрын харьяанд байгуулна.

74 дүгээр зүйл. Хорих байгууллагын үйлдвэрлэлийн чиглэл, байршил

1. Төвлөрсөн буюу бүсчилсэн хорих ангийн үйлдвэрлэлийн чиглэл, байршлыг тогтоох, ажлаар хангах асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

2. Аймаг, нийслэлийн харьамалтай хорих ангийн үйлдвэрлэлийн чиглэл, байршлыг тогтоох, тэдгээрийг ажлаар хангах асуудлыг аймаг, нийслэлийн Засаг дарга шийдвэрлэнэ.

75 дугаар зүйл. Хорих анги, түүний эрх хэмжээ

1. Хорих анги нь шүүхийн шийдвэрээр оногдуулсан хорих ялыг албадан эдлүүлэх төрийн албан газар мөн бөгөөд хуулийн этгээдийн эрх эдэлнэ.

2. Хорих ангийн дотоод журмыг Хууль зүйн сайд батална.

3. Хорих анги хорих ял эдлүүлэх талаар дараахь үүрэг хүтээнх:

1/ хорих ялыг албадан эдлүүлэх;

2/ хоригдлын аюулгүй байдлыг хангаж, тэдний дунд хууль ёс, дэг журмыг сахиулах, хоригдлоос нийгэм, иргэдэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх;

3/ хоригдолд хүмүүжлийн нөлөө үзүүлэх;

4/ хоригдлыг албадан хөдөлмөртүүлж, эрхэлсэн үйлдвэрлэлийн чиглэлээр түүнд дадлага олгох;

5/ насанд хүрээгүй хоригдлыг ерөнхий боловсролын сургалтад хамруулах, мэргэжлийн дадлага олгох;

6/ хоригдлын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах;

7/ нийгмийн аюултай халдварт өвчтэй болон согтуурах, мансуурах донтой хоригдлыг албадан эмчлэх;

8/ гэмт хэрэг үйлдсэнний улмаас иргэн, байгууллагад учруулсан хохирол, талбөрийг хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс суутгаж хохирогчид шилжүүлэх;

9/ хуульд заасан бусад үүрэг.

4. Хорих ангийн эрх бүхий албан тушаалтан хуулиар хүтээсэн үүргээ биелүүлэхдээ дараахь эрх эдэлнэ:

1/ хэрэг бүртгэх ажиллагаа явуулах;

2/ хоригдол оргох, үймээн гаргах, бусдыг барьцаанд авах, хорлон сүйтгэх зэрэг ноцтой гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох болон гарсан гэмт хэргийг илрүүлэх зорилгоор хоригдлуудын дотор, түүнчлэн оргосон хоригдлыг баривчлахын тулд хуулиар тогтоосон үндэслэл, журмын дагуу гүйцэтгэх ажил явуулах;

3/ хоригдлын ял эдэлж байгаа дэглэмийг өөрчлөх тухай санал шүүхэд гаргах;

4/ хоригдлыг хорих ялаас хугацаанаас өмнө тэнсэн судлах буюу хорих ялыг өөр төрлийн хөнгөн ялаар сольх болон эмнэлгийн тодорхойлолтыг үндэслэн өвчний учир ялаас чөлөөлүүлэх тухай санал шүүхэд гаргах;

5/ энэ хуулийн 88 дугаар зүйлд заасны дагуу хоригдолд чөлөө олгох;

6/ оногдсон ажлаа чанартай сайн гүйцэтгэсэн бөгөөд сахилгын зөрчил гаргаагүй хоригдода удирдал 30 хүртэл шалгалын хоног өгөх;

7/ хуурамчаар болон санаатай өвчнөсөн, эсхүл эрүүл мэнд, бие эрхтэндээ санаатайгаар гэмтэл учруулж эмчлүүлсэн, дур мэдэн ажилд гараагүй, чөлөөнөөс хоцорсон хутацааг ял эдэлсэн хутацаанаас тасч тооцох.

5. Хорих анги хоригдлыг хөдөлмөрт татан оролцуулах зорилгоор үйлдвэртэлийн салбар, нэгжтэй байж болно.

6. Энэ зүйлийн 4 дэх хэсгийн 2-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэхдээ цагдаагийн байгууллагаас туслалцаа авч, хамтран ажиллана.

76 дугаар зүйл. Хорих ангийг адил дэглэм бүхий байгууллага

1. Нэгдсэн эмнэлэг дараах үүрэгтэй:

1/ хоригдлыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэхтэй холбогдсон нэгдсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

2/ хорих ангийн эмнэлгийн салбарыг мэргэжлийн удирдлагаар хангах;

3/ тахир дутуугийн зэрэгт оруулах шаардлагатай хоригдлын талаархи тодорхойлолтыг эрүүл мэндийн зохих байгууллагад гаргах;

4/ өвчний учир хоригдлыг ялаас чөлөөлүүлэх тухай тодорхойлолт, чөлөөлөх саналыг хорих ангид гаргах.

2. Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэгдсэн эмнэлгийг мэргэжил, арга зүйн удирдлага, боловсон хүчинээр хангана.

3. Хорих ялаас чөлөөлөх өвчний жагсаалт, хүнд өвчтэй хоригдода эмнэлгийн бусад байгууллагын туслалцаа үзүүлэх журмыг Хууль зүйн сайдтай зөвшилцөн Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд батлана.

4. Хутацаагүй хорих тусгай салбар нь шаамар авах ял нь уучлагдаж, хутацаагүй хорих ялаар солигдсон хоригдлыг хорих байгууллага мөн.

5. Дамжин өнгөрүүлэх анги нь хоригдлыг ял эдлэх ангид нь хүргэхийн өмнө болон шаардлагатай бусад тохиолдолд түр хорих байгууллага мөн.

6. Нэгдсэн эмнэлэг, дамжин өнгөрүүлэх анги дахь дэглэм чанга дэглэмтэй хорих ангийнхтай адил байна.

7. Хутацаагүй хорих тусгай салбар болон дамжин өнгөрүүлэх ангид мөрдөх журмыг Удсын ерөнхий прокурортой зөвшилцөн Хууль зүйн сайд тогтооно.

77 дугаар зүйл. Хорих байгууллага дахь хяналт, харуул хамгаалалт

1. Хоригдода хяналт гавихдаа хоригдлын бие, байранд үзлэг,

нэгжлэг тогтмол хийж, зэвсэг, хутга, мөс, зэвсгийн чанартай бусад зүйл, мансууруулах болон хордуулах үйлчилгээний эм тариа, өвс ургамал, согтууруулах ундаа, хориглосон тоглоом болон зөвшөөрснөөс бусад зүйлийг хураан авах, эсхүл устгах, зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү төгрөг, валют, үнэт зүйлсийг хураан авч, акт тогтоон, бүртгэж хадгална.

2. Жирийн дэглэмтэй хорих ангийн харуул хамгаалалтыг хорих байгууллагын ажилтны хүчээр гүйцэтгэнэ.

3. Харуул хамгаалалтын хэсэг нь хорих ангийн аюулгүй байдал, түүнд мөрдөх дэг журмыг сахиулах зорилгоор хоригдолд байнгын хяналт тавина.

4. Жирийн дэглэмтэй хорих анги нь үндсэн хашааны эргэн тойронд хоёроос доошгүй хамгаалалтын бүстэй байна. Насанд хүрээгүйчүүдийн хорих ангийн харуул хамгаалалт нь насанд хүрэгчдийн жирийн дэглэмтэй хорих ангийнхтай адил байна. Жирийн дэглэмтэй хорих ангийн харуул хамгаалалтын болон хоригдолд хяналт тавих журмыг Хууль зүйн сайд тогтооно.

5. Гяндан, хугацаагүй хорих тусгай салбар, чанга, онцгой дэглэмтэй хорих анги нь улсын онцгой объектод хамаарах бөгөөд тэдгээрийн амьдралын болон үйлдвэртэлийн бүсийн гаднах дохиолол, харуул хамгаалалтыг дотоодын цэрэг хариуцан гүйцэтгэнэ. Гяндан, хугацаагүй хорих тусгай салбар, чанга, онцгой дэглэмтэй хорих ангийн харуул хамгаалалтын болон хоригдолд хяналт тавих журмыг Хууль зүйн сайд тогтооно.

6. Чанга дэглэмтэй хорих анги хамгаалалтын дараахь бүстэй байна:

- 1/ дотоодын хориотой бүс;
- 2/ цахилгаан дохиолол бүхий сийрэгжүүлсэн хөрстэй бүс;
- 3/ үндсэн хашаа;
- 4/ нохой гүйх бүс;
- 5/ өнгөлөн далдлах хашаа.

7. Гяндан, хугацаагүй хорих тусгай салбар, онцгой дэглэмтэй хорих анги хамгаалалтын дараахь бүстэй байна:

- 1/ дотоодын хориотой бүс;
- 2/ цахилгаан дохиолол бүхий сийрэгжүүлсэн хөрстэй бүс;
- 3/ үндсэн хашаа;
- 4/ нохой гүйх бүс;
- 5/ гэрэл дохионы төхөөрөмж бүхий бүс;
- 6/ өнгөлөн далдлах хашаа.

8. Хорих байгууллага дахь хяналт, харуул хамгаалалтад телекамерийн тоног төхөөрөмж ашиглаж болно. Хорих ял эдлүүлэх байгууллага угсан болон агзарын холбоогоор тоноглогдсон байна.

9. Хорих ангийн харуул хамтралалтыг зохион байгуулах, оргосон хоригдлыг мөрдөн хөөх, баривчлахад албаны нохой ашиглаж болох бөгөөд үүнийг зохих алба хариуцан гүйцэтгэнэ.

10. Оргосон хоригдлыг мөрдөн хөөх, баривчлах ажиллагааг эрэн сурвалжлах хэсэг гүйцэтгэнэ.

11. Онц аюултай буюу зэвсэглэсэн хоригдлыг мөрдөн хөөх, баривчлах, түүнчлэн хоригдлын дунд гарсан эмх замбараагүй байдлыг өөрийн хүчээр таслан зогсоох боломжгүй болсон тохиолдолд зохих байгууллагаас нисдэг тэрэг, хуягт тээвэрлэгч, хүн хүч, тусгай тоног төхөөрөмжийн тусалцаа авах болон бусад шаардагдах арга хэмжээг нэгдсэн журмаар авч хэрэгжүүлж болно. Уул журмыг Засгийн газар тогтооно.

78 дугаар зүйл. Хоригдлын эрх, үүрэг

1. Хоригдол дараахь эрх эдэлнэ:

1/ шүүхээс оногдуулсан ял эдтэх нөхцөл, журам болон өөрийнхөө эрх, үүрэг, хязгаарлалтын талаар мэдээлэл авах;

2/ өөрт холбогдох асуудлаар аль ч байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах;

3/ өмгөөллийн болон хууль зүйн тусалцаа авах;

4/ холбогдох зардалаа өөрөө хариуцаж шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих;

5/ тогтоосон хэмжээний илчлэгтэй хоол, түүнчлэн хувцас байраар хангагдах, эмнэлгийн тусламж авах;

6/ энэ хуульд заасны дагуу төрөл саантайгаа удаан, бусад хүнтэй түр хугацаагаар уулзах, захидлаар харилцах, илгээмж авах, өөрийн нэр дээр мөнгөн гуйвуулга авах, явуулах;

7/ сонин, сэтгүүл захиалах, хорих байгууллага дахь номын санг ашиглах.

2. Хоригдол дараахь үүрэг хүлээнэ:

1/ хорих ангид мөрдөх хууль тогтоомж, байгууллага ажилтнаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

2/ эрх бүхий албан тушаалтнаас даалгасан ажлыг заавал гүйцэтгэх, хөдөлмөр хамгаалах, аюулгүй ажиллагсаны журмыг чанд сахих;

3/ тогтоосон журмын дагуу зохиож байгаа хөдөлмөрийн дадлага олгох болон ерөнхий сургалтад хамрагдах;

4/ эрүүл мэндээ хамгаалах, эмчийн зөвлөлтгөө шаардлагыг биелүүлэх, хуурамчаар болон санаатайгаар өвчилсөн, эрүүл мэнд, бие эрхтэндээ гэмтэл учруулсан бол холбогдох зардлыг төлөх.

3. Гаднын иргэн хоригдол энэ зүйл заасан эрх эдэлж, үүрэг хүлээх бөгөөд хорих байгууллагаар улаажлан өөрийн орны дипломат галөөлөгчийн болон консулын газар буюу түүний үүрэг гүйцэтгэгчтэй харилцана.

79 дүгээр зүйл. Хорих ял эдлүүлэх дэглэм

1. Хоригдлын ял эдлэх ангийн төрөл, дэглэмийг шүүх тогтооно.
2. Насанд хүрээгүй болон эмэгтэй хоригдлын ялыг жирийн, чанга, насанд хүрсэн эрэгтэй хоригдлын ялыг жирийн, чанга, онцгой дэглэмтэй хорих ангид тус тус эдлүүлнэ.
3. Гянданд ял эдлүүлэхээр шийтгүүлсэн хоригдлын ялыг жирийн чанга дэглэмтэй гянданд эдлүүлнэ.

80 дугаар зүйл. Хоригдлыг хүргэх, хүлээн авах

1. Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 10 хоногийн дотор цагдаагийн байгууллага нь аймаг, нийслэлийн харьяалалтай хорих ангид ял эдлэх ялтныг шууд, шүүхийн шийдвэр биелүүлэх газрын харьяалалтай хорих ангид ял эдлэх ялтныг дамжин өнгөрүүлэх ангид хүргэнэ. Шүүхийн шийдвэр биелүүлэх газар хоригдлыг үйлдсэн гэмт хэргийн болон хувийн байдлыг харгалзан хувиарилсны дагуу түүнийг ял эдлэх хорих анги, хугацаагүй хорих тусгай салбарт хүргэхийг дамжин өнгөрүүлэх анги хариуцан гүйцэтгэнэ.

2. Хорих ангийн холбогдох албан тушаалтан нь шүүхийн шийдвэрээр ял эдлэх ялтан мөн эсэхийг нягтлан хүлээн авч, түүний овог, нэр, шүүхийн шийдвэрийн огноо, агуулга, ялтныг хүлээн авсан он, сар, өдөр, цагийг тэмдэглэнэ. Хорих ангийн дарга хоригдлыг ял эдлүүлэхээр хүлээн авахтай холбогдсон асуудлыг шийдвэрлэнэ.

81 дүгээр зүйл. Хоригдлыг тусад нь ял эдлүүлэх

1. Насанд хүрээгүй болон эмэгтэй, эрэгтэй хоригдлыг тус тусад нь ял эдлүүлнэ.
2. Ил хэлбэрийн сүрьеэ өвчтэй, дархлалын өдмөл хомсдоор халтварласан, өвчилсөн хоригдлыг бусад хоригдлоос тусгаарлан ял эдлүүлнэ.
3. Нэг дэглэмтэй хорих ангид анх удаа ял эдэлж байгаа хоригдлыг давтан гэмт хэрэг үйлдсэн хоригдлоос, засарч хүмүүжиж байгаа хоригдлыг засрал олохгүй байгаа хоригдлоос, гүүнчлэн эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн хоригдлыг тус тусад нь ял эдлүүлнэ.

82 дугаар зүйл. Насанд хүрээгүй хоригдол

1. Насанд хүрээгүй хоригдлын ялыг зөвхөн насанд хүрээгүйчүүдийн хорих ангид эдлүүлнэ.
2. Насанд хүрээгүй хоригдлыг ердийн нийтийн байранд байлгана.
3. Насанд хүрээгүй хоригдлыг хөдөлмөрийн дадлага олгох зорилгоор хууль тогтоомжид заасан хөнгөлөлттэй нөхцөлөөр ажиллуулж болно.
4. Насанд хүрээгүй хоригдлыг 18 нас хүрмэгц ялыг нь насанд хүрэгчдийн хорих ангид эдлүүлэхээр шилжүүлнэ.

5. Хоригдлын ялын хугацаа, хувийн байдлыг харгалзан Хорих ангийн даргын шийдвэрээр түүнийг насанд хүрээгүйчүүдийн хорих ангид 2 жил хүртэл хугацаагаар үргэлжлүүлэн ял эдлүүлж болно.

6. Хоригдлыг насанд хүрмэгц насанд хүрэгчдийн хорих ангид шилжүүлэх асуудлыг Хорих ангийн даргын тодорхойлсноор шүүх шийдвэртэнэ.

7. Насанд хүрээгүй хоригдол жирийн дэглэмтэй хорих ангид ял эдэлж байгаа бол илгээмж авах, түр уулзалт хийх тоог хязгаарлахгүй бөгөөд жилд найман удаа удаан хугацааны уулзалт хийж болно.

8. Насанд хүрээгүй хоригдол чанга дэглэмтэй хорих ангид ял эдэлж байгаа бол сард нэг удаа түр, хоёр сард нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, сард нэг удаа илгээмж авч болно.

83 дугаар зүйл. Эмэгтэй хоригдол

1. Эмэгтэй хоригдлын ялыг зөвхөн эмэгтэйчүүдийн хорих ангид эдлүүлнэ.

2. Эмэгтэй хоригдлыг ердийн нийтийн байранд байлгана.

3. Жирэмсэн болон насанд хүрээгүй эмэгтэй хоригдлыг тусад нь байлгана.

4. Эмэгтэй хоригдол жирийн дэглэмтэй хорих ангид ял эдэлж байгаа бол сард нэг удаа түр, жилд найман удаа удаан хугацааны уулзалт хийж, сард нэг удаа илгээмж авч болно.

5. Эмэгтэй хоригдол чанга дэглэмтэй хорих ангид ял эдэлж байгаа бол сард нэг удаа түр, жилд найман удаа удаан хугацааны уулзалт хийж, сард нэг удаа илгээмж авч болно.

84 дүгээр зүйл. Эрэгтэй хоригдол

1. Хугацаагүй хорих тусгай салбар, гандангаас бусад хорих ангид эрэгтэй хоригдлыг дэглэм харгалзахгүйгээр нийтийн байранд байлгана.

2. Эрэгтэй хоригдол жирийн дэглэмтэй хорих ангид ял эдэлж байгаа бол хоёр сард нэг удаа түр, жилд дөрвөн удаа удаан хугацааны уулзалт хийж, хоёр сард нэг удаа илгээмж авч болно.

3. Эрэгтэй хоригдол чанга дэглэмтэй хорих ангид ял эдэлж байгаа бол гурван сард нэг удаа түр, дөрвөн сард нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, гурван сард нэг удаа илгээмж авч болно.

4. Эрэгтэй хоригдол онцгой дэглэмтэй хорих ангид ял эдэлж байгаа бол жилд хоёр удаа түр, нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, жилд хоёр удаа илгээмж авч, сард нэг удаа захидал явуулж болох бөгөөд ялынхаа тал хувь эдэлсний дараа жилд хоёр удаа илгээмж нэмж авч болно.

85 дугаар зүйл. Гяндангийн хоригдол

1. Гяндангийн хоригдлыг ганцаарчилсан тасалгаанд хорино. Шаардлагатай гэж үзвэл Хорих ангийн дарга прокурортой

зөвшилцөж, гяндангийн хоригдлыг нийтийн тасалгаанд хорьж болно.

2. Гяндангийн хоригдлыг тусгай төхөөрөмжлөгдсөн газарт зохих хяналт хамгаалалтын дор өдөрт 1 цагаас доошгүй хугацаатай гадаалуулна. Гяндангийн хоригдол гадаалж байхдаа тогтоосон журам зөрчвөл гадаалахыг даруй зогсооно.

3. Жирийн дэглэмтэй гяндангийн хоригдол жилд хоёр удаа түр уулзалт хийж, сард нэг удаа захидал явуулж болно.

4. Чанга дэглэмтэй гяндангийн хоригдол жилд нэг удаа түр хугацааны уулзалт хийж, хоёр сард нэг удаа захидал явуулж болно.

86 дугаар зүйл. Хугацаагүй хорих тусгай салбарын хоригдол

1. Хугацаагүй хорих ял шийтгүүлсэн хоригдлын ялыг дотоодын цэргийн хамгаалалттай тусгай салбарт ганцаарчилсан тасалгаанд эдлүүлнэ.

2. Хугацаагүй хорих ял шийтгүүлсэн хоригдлыг хугацаагүй хорих тусгай салбарт нь эхний 5 жилийг чанга дэглэмтэй гяндангийн, үлдэх хугацааг онцгой дэглэмтэй хорих ангийн нөхцлөөр ганцаарчилсан тасалгаанд ял эдлүүлнэ.

3. Хугацаагүй хорих тусгай салбарын хоригдол захидал, илгээмж явуулах, хүлээн авах, төрөл садан, бусад хүнтэй уулзахдаа гяндан болон онцгой дэглэмтэй хорих ангийн хоригдолтой адил эрх эдэлнэ.

87 дугаар зүйл. Хоригдол бусадтай уулзах, харилцах

1. Хоригдол зохих хяналт, хамгаалалтын дор төрөл садан /эхнэр, нөхөр, хүүхэд, төрсөн болон хадам эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, өвөг эцэг, эмэг эх, нэг ам бүлд хамт амьдардаг эч, хээ/-тай удаан, бусад хүнтэй түр хугацааны уулзалт хийж болно.

2. Түр хугацааны уулзалтын үргэлжлэх хугацаа 3 цагаас дээшгүй, удаан хугацааны уулзалтын үргэлжлэх хугацаа 72 цагаас дээшгүй байх бөгөөд холбогдох зардлыг хорих байгууллага хариуцахгүй.

3. Хоригдолтой удаан хугацаагаар уулзах хүн түүний төрөл садан мөн болохыг нотолсон хууль ёсны бичиг баримт, эсхүл харьяалах сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолттой байна.

4. Хорих байгууллагын болон хоригдлын аюулгүй байдлыг хангах зорилгоор хорих байгууллагын эрх бүхий албан тушаалтан хоригдлын захидлыг задлан үзэж, түүнд ирсэн илгээмжид үзлэг хийнэ.

88 дугаар зүйл. Хоригдолд чөлөө олгох

1. Жирийн дэглэмтэй хорих ангийн хоригдолд дор дурдсан онцгой нөхцөл байдалд эмнэлгийн магадлагаа, сум, дүүргийн Засаг даргын албан ёсны тодорхойлолтыг үндэслэн зам хоногийн оролцуулалгүйгээр 7 хүртэл хоногийн чөлөө олгож болно:

1/ энэ хуулийн 87 дугаар зүйлд заасан төрөл садангийн хүн хүндээр өвчилсөн буюу нас барсан;

2/ байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсоны улмаас ар гэрт нь үлэмж хор, хөнөөл учирсан.

2. Чөлөөг хоригдлын хувийн байдлыг харгалзан Хорих ангийн дарга олгоно.

89 дүгээр зүйл. Хоригдлын хөдөлмөр

1. Хоригдлын хөдөлмөрийг Хөдөлмөрийн хууль тогтоомжид заасан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журамд нийцүүлэн зохион байгуулна. Хоригдлоор ажил хийлгэхдээ түүний мэргэжил, хөдөлмөрийн чадварыг харгалзана. Зохио мэргэжлийн ажил байхгүй нь тухайн хоригдлыг хөдөлмөрөөс чөлөөлөх үндэстэл болохгүй.

2. Хоригдлыг хорих байгууллагын өөрийн үйлдвэртэл, хорих байгууллагын хувь нийлүүлсэн болон хамтарсан аж ахуйн нэгж, гэрээний үндсэн дээр урьдчилан хорих байрны аж ахуйн үйлчилгээ, бусад аж ахуйн нэгжид хөдөлмөрлүүлнэ.

3. Улсын нууц, цэрэг стратегийн холбогдолтой зэрэг тусгай дэглэм бүхий онцгой объектод хоригдол ажиллуулахыг хориглоно.

4. Гянданд ял эдэлж байгаа хоригдлыг зөвхөн гяндангийн байранд хөдөлмөрлүүлж болно.

5. Онцгой, чанга дэглэмтэй хорих ангид жирийн дэглэмд хорих ял эдлэх хоригдлыг хөдөлмөрлүүлж болно.

6. Хуульд өөрөөр заагаагүй бол хоригдлыг харуул, хамгаалалт-тайгаар хөдөлмөрлүүлнэ.

90 дүгээр зүйл. Хоригдлын хөдөлмөрийн хөлс

1. Хоригдолд хөдөлмөрийнх нь тоо, чанарт тохирсон хөлс олгоно.

2. Хоригдлын хөдөлмөрийн хөлсийг түүний нэрийн дансанд шилжүүлэх бөгөөд түүнээс гүйцэтгэх баримт бичгийг үндэслэн иргэн, байгууллагад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх болон хуульд заасан бусад суутгал хийнэ.

3. Хоригдлын нэрийн дансанд үлдсэн мөнгийг түүнийг суллагах үед олгоно.

4. Хоригдлын хөдөлмөрийн норм, хөлсний үнэлгээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн Шүүхийн шийдвэр биелүүлэх газар тогтооно.

91 дүгээр зүйл. Хоригдлын хөдөлмөрийн нөхцөл

1. Насанд хүрээгүй болон жирийн дэглэмтэй хорих ангийн хоригдлын ажил, амралтын цаг нь Хөдөлмөрийн хуульд нийцсэн байна.

2. Чанга дэглэмтэй хорих ангийн хоригдлын ажлын ердийн өдрийн үргэлжлэх хугацаа 9 цаг байна.

3. Онцгой дэглэмтэй хорих ангийн хоригдлын ажлын ердийн өдрийн үргэлжлэх хугацаа 10 цаг байна.

4. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан хоригдлыг долоо хоногт нэг өдөр амраана.

5. Амралт, баяр ёслолын өдөр, эсхүл илүү цагаар ажилдуулсан бол Хөдөлмөрийн хуульд заасан журмын дагуу нөхөн амраана.

92 дугаар зүйл. Хоригдлыг харуул хамгаалалтгүй ажиллуулах

1. Хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэгт анх удаа ял шийтгүүлсэн, ялын тал хувийг эдэлсэн хоригдлыг засрал хүмүүжил, хувийн байдал, ажлын онцлогийг нь харгалзан, Хорих ангийн дарга прокурортой зөвшилцөн, харуул хамгаалалтгүй ажиллуулах тухай шийдвэр гаргаж болно.

2. Онц аюултай гэмт хэрэгтэн, хорих ял эдэлж байхдаа гэмт хэрэг санаатай үйлдсэн, хорих ангиас оргосон буюу оргохыг завдаж байсан, түүнчлэн согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэдэг, эсхүл тийнхүү хэрэглэснээс албадан эмчлүүлж байсан хоригдлыг харуул хамгаалалтгүй ажиллуулахыг хориглоно.

93 дугаар зүйл. Хүмүүжлийн ажил

1. Хүмүүжлийн ажил нь хоригдлыг үйлдсэн гэмт хэргийг ухамсарлуулж түүний нийгмийн хор аюулыг ойлгуулах, хорих ялын зорилгыг хангахад чиглэгдэнэ.

2. Хүмүүжлийн ажлыг хоригдлын үйлдсэн гэмт хэргийн болон хувийн байдал, нас, хүйс, ял эдлүүлэх дэглэмийг харгалзан ялгамжтай явуулна.

94 дүгээр зүйл. Хүмүүжлийн ажлын хэлбэр, зохион байгуулалт

1. Хоригдлыг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дэдлага, мэргэжлийн баримжаа олгох, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, эрдэн уламжлалт зан үйлд сургах болон бусад хэлбэрээр зохион байгуулна.

2. Хүмүүжлийн ажилд хорих байгууллагын ажилтнуудаас гадна шашны, буяны болон бусад байгууллага, иргэнийг оролцуулж болно.

3. Хоригдолд хүмүүжлийн нөлөө үзүүлэх, тэднийг хамтач үйл ажиллагааны хэм хэмжээнд сурах зорилгоор хоригдлын сайн дурын байгууллага ажиллуулж болно.

95 дугаар зүйл. Хорих анги дахь сургалт

1. Насанд хүрээгүй хоригдлыг ерөнхий боловсролын сургалтад бүрэн хамруулж, бусад хоригдол бие дааж мэдлэгээ дээшлүүлэхэд хорих байгууллага туслалцаа үзүүлнэ. Боловсролын сургалтыг зөвхөн хорих ангийн байранд зохион байгуулна.

2. Хорих анги нь өөрийн эрхэлж байгаа үйлдвэртэйг чиглэлээр хоригдолд хөдөлмөрийн дадлага олгох сургалт зохион байгуулж болно.

Хөдөлмөрийн дадлага олгох сургалтад хоригдлыг сайн дурын үндсэн дээр хамруулна.

96 дугаар зүйл. Хоригдлыг сайншаах, урамшуулах

1. Хорих ангийн дэг журмыг чанд сахиж, хөдөлмөрийн үүргээ амжилттай биелүүж байгаа хоригдлыг Хорих ангийн даргын шийдвэрээр дараахь хэлбэрээр сайншааж, урамшуулна:

1/ баар хүргэх, сайншаалын үнэмлэх олгох;

2/ хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх;

3/ урьд оногдуулсан сахилгын шийтгэлийг хутагцамаас нь өмнө арилгах;

4/ төрөл садантайгаа уулзах уулзалтын болон гэднээс авах илгээмжийн тоог нэмэх;

5/ энэ хуульд заасны дагуу шагналын хоног олгох.

2. Ялын талаас доошгүйг эдэлсэн, сахилгын зөрчил гаргаж байгаагүй, хөдөлмөрийн үүргээ амжилттай биелүүж сайншаагдаж байсан хоригдын эл эдэлж байгаа дэглэмийг бууруулах тухай шүүхэд тодорхойлох.

Энэ заалт нь онц аюултай гэмт хэрэгтэн, онц хүнд гэмт хэрэгт шийтгүүлсэн болон санаатай гэмт хэрэгт удаа дараа хорих эл шийтгүүлж байсан этгээдэд хамаарахгүй.

97 дугаар зүйл. Хоригдолд хүлээлгэх сахилгын шийтгэл

1. Хууль зөрчсөн нь гэмт хэргийн шинжгүй, түүнчлэн ажлаас зайлсхийх зэргээр хорих анги дахь дэг журам зөрчсөн хоригдолд Хорих ангийн даргын шийдвэрээр дараахь сахилгын шийтгэлийг өөрт нь танилцуулж ногдуулна:

1/ ээлжийн бус ажил хийлгэх;

2/ хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх;

3/ сахилгын байранд хорих;

4/ тухайн улирал эсхүл жилд олгосон шагналын хоногийг хасах.

2. Насанд хүрсэн эрэгтэйчүүдийг сахилгын байранд 30 хүртэл хоног, насанд хүрээгүйчүүд болон эмэгтэйчүүдийг 15 хүртэл хоног, онцгой тохиолдолд насанд хүрсэн эрэгтэйчүүдийг 60 хүртэл хоног, насанд хүрээгүйчүүд болон эмэгтэйчүүдийг 30 хүртэл хоног тус тус торно.

3. Хорих ангийн аюулгүй байдлыг хангах, хоригдол гэмт хэрэг үйлдэх болон бусад сөрөг нөлөө үзүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хорих ангийн жижүүрийн шийдвэрээр 72 цаг хүртэл сүтэцаагаар хоригдлыг тусгаарлах тасалгаанд түр шилжүүлж болно.

4. Сахилгын байр, тусгаарлах тасалгааны нөхцөл, журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн Хууль зүйн сайд тогтооно.

5. Сахилгын байранд хорьсон, тусгаарлах тасалгаанд шилжүүлсэн хоригдлын эрүүл мэндэд эмч хяналт тавина.

6. Жилд хоёроос дээш удаа сахилгын шийтгэл хүтээсэн хоригдол дахин ноцтой зөрчил гаргавал хорих ял эдлүүлэх дэглэмийг чангатгах тухай саналыг Хорих ангийн дарга шүүхэд гаргаж болно.

7. Сахилгын байранд хоригдсон, тусгаарлагдах тасалгаанд шилжигдсэн хоригдлын ээлжит түр болон урт хугацааны уулзалтыг хасахыг хориглоно.

8. Сахилгын нэг зөрчил гаргасан хоригдолд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийтгэлийг давхардуулан оногдуулахыг хориглоно.

98 дугаар зүйл. Хоригдлын ахуйн нөхцөл

1. Хоригдлыг эрүүл ахуй, ариун цэврийн тусгайлан тогтоосон шаардлага хангасан байр, ахуйн нөхцөлөөр хангана.

2. Хоригдлыг ор, хөнжил, гудас, цагаан хэрэгслэл болон хүйтэн дулааны улирлын зориулалттай нэг загварын гадуур хувцасаар хангана.

Хоригдол хувиасаа дотуур хувцас, дулаан хантаал, цамц, бээлий, өвөл, зуны гутал өмсөхийг зөвшөөрнө.

3. Хоригдлын хоолны илчлэгийн хэмжээг хорих байгууллагын төрөл, хоригдлын ажлын нөхцөлийг харгалзан ялгамжтай тогтооно.

4. Эмнэлгийн комиссын дүгнэлтийг харгалзан жирэмсэн болон өвчтэй хоригдлыг нөхцөлийг нь сайжруулсан байранд байлгаж, хоолны илчлэгийн хэмжээг нэмэгдүүлнэ.

5. Хөртой, хүнд нөхцөлд ажиллаж байгаа хоригдолд Хөдөлмөрийн хууль тогтоомжид заасан тусгай зориулалтын хувцас олгоно.

6. Хорих байрны эрүүл ахуйн шаардлага, хоригдолд олгох хоолны илчлэгийн хэмжээ, хувцасны тоо, эдлэх хугацааг холбогдох байгууллагын саналыг үндэслэн Хууль зүйн сайд тогтооно.

7. Хорих ял эдэлж байхдаа нас барсан хоригдлын тухай ар гэрт нь мэдэгдсэнээс хойш 7 хоногийн дотор хариу ирээгүй бол хорих байгууллага өөрийн зардлаар оршуулна.

99 дүгээр зүйл. Хоригдлыг суллах үндэслэл

Хоригдлыг дараахь үндэслэлээр сулдана:

1/ шүүхийн шийдвэрээр оногдуулсан ялын хугацаа дууссан;

2/ өршөөл, уучлал үзүүлсэн;

3/ шүүхээс хэргийг хэрэгсэхгүй болгосон;

4/ ялаас хугацааны өмнө тэнсэн суллах буюу өвчний учир хугацааны өмнө ялаас чөлөөлөх, эсхүл хорих ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих тухай шүүхийн шийдвэр гарсан;

5/ хуульд заасан бусад үндэслэл.

100 дугаар зүйл. Хоригдлыг суллах журам

1. Хоригдлын ялын хугацаа дууссан бол тухайн өдөрт, бусад үндэслэлээр уг хоригдлыг суллах тухай шийдвэрийг хүлээн авсан өдөрт нь багтаан суллана. Хоригдлыг суллах тухай шийдвэр гаргах эрх бүхий байгууллага тухайн шийдвэрийг хорих ангид хүргүүлэх хугацааг харгалзсан байна. Хоригдлыг суллах тухай шийдвэрийг ажлын цаг дууссаны дараа хүлээн авсан бол дараагийн өдөрт багтаан суллана.

Хоригдлын ялын хугацаа дуусах өдөр амралт, баяр ёслолын өдөр байвал өмнөх өдөр нь суллана.

2. Суллагдсан хүнд хувийн бичиг баримт, эд зүйлийг нь болон суллагдсан тухай албан бичиг олгож, хоригдлын хувийн хэрэгт зохих гэмдэглэл хийнэ.

3. Шаардлагатай бол суллагдаж байгаа хүнд тухайн улирлын хувцас, байнга оршин суух газартаа очих уналга, хоолны зардлыг хорих байгууллагаас олгож болно. Уналгын зардлыг автомашин, төмөр замын тухайн үед мөрдөж байгаа үнэлгээгээр тооцож олгоно.

4. Гянданд ял эдэлж байсан буюу гэмт хэрэг саналтай үйлдэж хоёроос дээш удаа хорих ял шийтгүүлд байсан хоригдол суллагдвал энэ тухай цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.

5. Мансууруулах болон хордуулах үйлчилгээний бодис байнга хэрэглэдэг, түүнчлэн ил хэлбэрийн сүрьеэ өвчтэй болон дархлалын олдмол хомсдлоор халдварласан буюу өвчилсөн хоригдол суллагдвал энэ тухай эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэнэ.

101 дүгээр зүйл. Хорих ял эдэлж суллагдсан хүнд олгох тэтгэвэр

Хорих ял шийтгүүлэхээс өмнө тэтгэвэр авч байсан хүнд суллагдсаны дараа урьд тогтоосон тэтгэврийг нь үргэлжлүүлэн олгоно.

ТАВДУГААР БҮЛЭГ

Цаазаар авах ялыг гүйцэтгэх

102 дугаар зүйл. Цаазаар авах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх

1. Цаазаар авах-буудан алах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанаар баталсан бол уг шийдвэрийг ялтанд 10 хоногийн дотор мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдсэнээс хойш 15 хоногийн дотор анхан шатны шүүх ялтнаар амь уучлахыг хүссэн өргөдөл гаргуулах буюу хэрэв өргөдөл гаргуулах хүсэлгүй бол энэ тухай протокол үйлдэж, Улсын дээд шүүхэд ирүүлднэ.

2. Улсын дээд шүүх өргөдөл буюу протоколыг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор хэргийн хамт Монгол Улсын Ерөнхийлөгчид хүргүүлнэ.

3. Монгол Улсын Ерөнхийлөгч хэргийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор ялтанд уучлал үзүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг 30 хүртэл хоногоор сунгаж болно.

4. Ялтанд уучлал үзүүлсэн эсэх тухай хариуг прокуророор дамжуулан өгнө.

5. Монгол Улсын Ерөнхийлөгч ялтанд уучлал үзүүлээгүй бол ялыг зохих журмын дагуу гүйцэтгэнэ.

6. Цаазаар авах ялыг гүйцэтгэх журмыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батална.

7. Уучлалын асуудлыг шийдвэрлэх хүртэл цаазаар авах ял оногдуулсан шүүхийн шийдвэр биелүүлэхийг туагэлзүүлнэ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

103 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын данс

1. Шүүхийн шийдвэр биелүүлэх газар болон аймаг, нийслэл дэх шүүхийн шийдвэр биелүүлэх тасаг нь банкинд данстай байна.

2. Шүүхийн шийдвэр биелүүлэх газар нь банкинд гадаад төлбөр тооцооны данстай байна.

3. Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын данс, бүртгэлийн хөтлөлт, тайлан тэнцлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон хууль тогтоомжийн дагуу гартасан журмын дагуу хөтөлнө. Шүүхийн шийдвэр биелүүлэх ажлын онцлогийг тусгасан данс, бүртгэл, тайлан тэнцлийн тухай журмыг Сангийн яамтай зөвшилцөн Хууль зүйн сайд батална.

104 дүгээр зүйл. Тусгай хэрэгсэл

1. Шийдвэр гүйцэтгэгч дараахь тусгай хэрэгсэл хэрэглэнэ:

1/ бороохой;

2/ нулимс астаруулагч;

3/ амьсгал боогдуулагч.

2. Хорих байгууллага дараахь тусгай хэрэгсэл ашиглана:

1/ гар, хөт, хурууны гав;

2/ хүлэг, ороох цамц;

3/ резинэн, цахилгаан бороохой;

4/ нулимс астаруулагч, амьсгал боогдуулагчаар нэнэглэсэн буу;

5/ резинэн ба хувцандар сумтай буу.

3. Хорих байгууллагын ажилтан дор дурдсан тохиолдолд тусгай хэрэгсэл ашиглаж болно:

1/ хоригдол хорих байгууллагад мөрдөх журмыг биелүүлдэггүй, хорих байгууллагын ажилтны хууль ёсны шаардлагыг эсэргүүцсэн, эсхүл биелүүлдэггүй;

2/ хоригдол хорих байгууллагын ажилтанд хүч хэрэглэн халдсан;

3/ хорих ангис өргөсөн хоригдлыг баривчлах үед;

4/ бусад хоригдлын болон хорих байгууллагын ажлуугүй байдалд хохирол учруулж болохоор үймээн гарсан;

5/ энэ хуулийн 105 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхцөл байдал бий болсон

105 дугаар зүйл. Галт зэвсэг

1. Хорих байгууллагын ажилтан албан үүртээ гүйцэтгэж байх үедээ галт зэвсэг биедээ авч явах эрхтэй бөгөөд гэмт үйлдлийг өөр арга хэрэгслээр таслан зогсоох боломжгүй бол дараахь тохиолдолд галт зэвсэг хэрэглэж болно:

1/ хоригдлын дайран довтолсон үйлдэл нь бусдын амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах нь илт байвал;

2/ хоригдол өргөн зугтсан буюу оргохыг завдсан;

3/ зэвсэглэсэн оргодол баривчлах үед;

4/ хорих байгууллага, түүний харуул хамгаалалт, ажилтанд галнаас хүч хэрэглэн довтолсон;

5/ хуяглан хүргэж байгаа хоригдлыг суллахаар зэвсэг хэрэглэн, эсхүл бүтэглэн довтолсон;

6/ хорих ангид эмх замбараагүй байдал, үймээн гарснаас хүний амь нас, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах бодит нөхцөл бий болсон;

7/ бусдыг барьцаанд авсан.

2. Боломжтой бүх тохиолдолд галт зэвсэг хэрэглэхийн өмнө урьдчилан сануулна.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1, 3-т заасан, түүнчлэн бүтэглэн довтолсон буюу нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон үед дотор нь ялгах боломжгүй онцгой тохиолдлоос бусад үед үүхэд болон жирэмсэн болох нь илэрхий мэдэгдэж байгаа хүний эсрэг тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэхийг хориглоно.

4. Галт зэвсэг хэрэглэсэн тохиолдолд энэ талаар Шүүхийн шийдвэр биелүүлэх газарт мэдэгдэнэ.

5. Тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн Хууль зүйн сайд батална.

106 дугаар зүйл. Тоо бүртгэл

1. Хорих ял болон хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, засан

хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг тэнссэн болон насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэр биелүүлэхийг хойшлуулсан этгээд болон эдгээр ял, арга хэмжээний хэрэгжилтийн талаархи нэгдсэн тоо бүртгэлийг шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллага эрхлэн гүйцэтгэнэ.

2. Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан, хорих, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг тэнссэн болон насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэр биелүүлэхийг хойшлуулсан шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 5 хоногийн дотор шүүх энэ тухай бичгээр шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллага болон цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.

107 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналт

1. Хууль зүйн яам, орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга эрх хэмжээнийхээ хүрээнд шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавина.

2. Хорих, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэхэд Улсын Ерөнхий прокурор, түүний харьяа прокурорууд хяналт тавина.

108 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын ажилтны шийдвэр, үйл ажиллагаанд гомдол гаргах

1. Энэ хуулийн 20 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын ажилтны шийдвэр, үйл ажиллагааны тухай гомдлыг холбогдох этгээд уг шийдвэрийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор дээд шатны албан тушаалтанд гаргана.

2. Дээд шатны албан тушаалтан гомдлыг холбогдох хууль тогтоомжид заасан хугацааны дотор шалгаж шийдвэрлэнэ.

3. Дээд шатны албан тушаалтны шийдвэрийг эс зөвшөөрвөл түүнийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор гомдлоо шүүхэд гаргаж болно.

Монгол Улсын Их Хурлын дарга

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 11 дүгээр
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 187 дугаар зүйлийн дараа дараахь агуулгатай 187¹ дүгээр зүйл нэмсүгэй:

“187¹ дүгээр зүйл. Биелэгдсэн шийдвэрийг цуцлах
тухай шийдвэр

Биелэгдсэн шийдвэрийг давж заалдах болон хяналтын журмаар, эсхүл шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүх хүчингүй болгож байгаа бол биелэгдсэн шийдвэрийг цуцлах тухай асуудлыг өөрөө шийдвэрлэх, эсхүл анхан шатны шүүхээр шийдвэрлүүлэхээр шилжүүлэх үүрэгтэй.”

2 дугаар зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар бүлгийг хүчингүй болсонд тооцугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 11 дүгээр
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль батлагдсантай холбогдуулж Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн харнууллагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх тухай, Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны тухай хуулиудыг тус тус хүчингүй болсонд тооцугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 11 дүгээр
сарын 28-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН 1997 ОНЫ УЛСЫН ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын төвлөрсөн төсвийн 1997 оны орлогын нийт дүн, нэр төрлийн хэмжээг дор дурдсангаар баталсугай.

/мянган төгрөгөөр/

Улсын төвлөрсөн төсвийн орлого-бүгд	157802089.0
1. Албан татварын орлого	109957109.8
1/ орлогын албан татвар	29813911.4
2/ галийн албан татвар	20754900.0
3/ худалдааны албан татвар	20610362.9
4/ онцгой албан татвар	9942000.0
5/ автобензин, дизелийн түлшний албан татвар	4839700.0
6/ бусад албан татвар	1185451.5
7/ нийгмийн даатгалын шимтгэл	22810784.0
2. Татварын бус орлого	20844979.2
1/ хувьцааны ногдол ашиг	7454176.8
2/ бусад орлого	3131000.0
3/ төсөвт байгууллагын өөрийн орлого	9359802.4
4/ түрээсийн орлого	900000.0
3. Хөрөнгийн орлого	20000000.0
1/ өмч хувьчлалын орлого	20000000.0
4. Гадаад туслэмжийн орлого	7000000.0

2 дугаар зүйл. Улсын төвлөрсөн төсвийн 1997 оны зарлагын нийт дүн, үүний дотор цалин, хөрөнгө оруулалт, нийтийн ерөнхий үйлчилгээний зардал, батлан хамгаалах арга хэмжээний зардал, төвлөрүүлэн захирагчийн санхүүжилт, тэтгэврийн даатгалын сан болон аймгийн төсөвт өгөх татаасны хэмжээг дор дурдсанаар баталсугай:

/мянган төгрөгөөр/

Улсын төвлөрсөн төсвийн зарлага-бүгд	184105831.9
1/ цалингийн сан	13492685.2
2/ хөрөнгө оруулалт	20350300.0
Үүнээс шинээр эхлэх барилга объектын төсөвт өртөг	9909500.0
Үүний дотор 1997 онд санхүүжүүлэх хэмжээ	5525900.0
3/ нийтийн ерөнхий үйлчилгээний зардал	10032597.5
4/ батлан хамгаалах арга хэмжээний зардал	14885396.1
5/ Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхийлөгчийн Тамгын газрын төсөв	100384.9
6/ Монгол Улсын Их Хурлын төсөв	1012168.0
7/ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн төсөв	13058.7
8/ Шүүхийн төсөв	727485.1
9/ Прокурорын төсөв	459362.3
10/ Тагнуулын төв газрын төсөв	965178.3
11/ тэтгэврийн даатгалын санд өгөх татаас	9777400.0
12/ аймгийн төсөвт өгөх татаас	24133648.1

3 дугаар зүйл. Улсын төвлөрсөн төсвөөс аймгийн төсөвт өгөх татаасны хэмжээг дор дурдсанаар хуваарилан тогтоосугай:

Архангай	1791381.2
Баян-Өлгий	1570772.3
Баянхонгор	1735549.1
Булган	475511.3
Говь-Алтай	1779307.7
Дорноговь	1292999.8
Дорнод	1267495.1
Дундговь	1122118.8
Завхан	1976856.9
Өвөрхангай	1145728.1
Өмнөговь	1208337.5

Сүхбаатар	1737191.1
Увс	1528781.6
Ховд	1562248.3
Хөвсгөл	2101906.8
Хэнтий	1453485.2
Говь-Сүмбэр	383977.3

Монгол Улсын Их Хурлын дарга

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 12 дүгээр
сарын 5-ны өдөр

Улаанбаатар
хот

ХЭЛЭЛЦЭЭРҮҮДИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ ТЭДГЭЭРТ НЭГДЭН ОРОХ ТУХАЙ

Тариф, худалдааны тухай 1994 оны Ерөнхий Хэлэлцээр болон 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Хэлэлцээрийг тус тус хүлээн зөвшөөрч, тэдгээрт нэгдэн орсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 12 дүгээр
сарын 5-ны өдөр

Улаанбаатар
хот

КОНВЕНЦ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

I дүгээр зүйл. Швейцар Улсын Базель хотноо 1989 оны 3 дугаар сард гарын үсэг зурсан "Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенц"-ийг соёрхон баталсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 12 дүгээр
сарын 13-ны өдөр

Улаанбаатар
хот

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. "Гурван улсын улсын хилийн уулзваруудын цэгийг тодорхойлох тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр", "Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын гурван улсын улсын хилийн Зүүн уулзварын цэгийн тухай Тодорхойлолт-протокол", түүний хавсралт болох "Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын улсын хилийн Зүүн уулзварын цэгийн орчмын газрын зураг", "Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын улсын хилийн Зүүн уулзварын цэгийн хилийн гэмдгийн протокол", "Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын гурван улсын улсын хилийн Баруун уулзварын цэгийн тухай Тодорхойлолт-протокол", түүний хавсралт болох "Монгол Улс, БНХАУ, ОХУ-ын улсын хилийн Баруун уулзварын цэгийн орчмын газрын зураг"-ийг Засгийн газрын өргөн мэдүүлсний дагуу соёрхон баталсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 12 дүгээр
сарын 13-ны өдөр

Улаанбаатар
хот

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1996 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан "Цэргийн салбар дахь солилцоо, айлчлалын тухай Монгол Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр"-ийг Засгийн газрын өргөн мэдүүлсний дагуу соёрхон баталсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1996 оны 10 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 47

Улаанбаатар
хот

Ерөнхийлөгчийн хоригийн тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45¹ дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн ТОГТООХ нь:

Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл дэх Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн нэг дэх догол мөрд оруулсан өөрчлөлтөд Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг хүлээн авах боломжгүй гэж үзсүгэй.

Дарга

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1996 оны 10 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 48

Улаанбаатар
хот

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тухай

Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1996 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн хуулийн 1 дүгээр зүйлд заасан заалтын талаар Үндсэн хуулийн цэцээс гаргасан 07 тоот дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45², 50 дугаар зүйлийг Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1996 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн хуулийн 1 дүгээр зүйлд заасан Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг "Монгол Улсын Хууль зүйн сайд ... Засгийн газрын гишүүний хувьд ... шүүхийн байгууллагын зохион байгуулалт, санхүү, материал-техникийн хангамж үйлчилгээ ... -ний хүрээний стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хөтөлбөр зохиох, зохицуулалт, хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлж дүгнэх ажлыг эрхэлнэ." гэж өөрчилсөн заалт нь Монгол Улсын

Үндсэн хуулийн дэчин есдүгээр зүйлийн 3, 4, 5 дахь хэсгийн заалтыг зөрчөөгүй байна гэсэн Үндсэн хуулийн дэчийн 1996 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 07 тоот дүгээлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

Дарга

Р. ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 10 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 49

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Засгийн газраас өргөн барьсан Монгол Улсын иргэнд газар өмчлүүдэх тухай хуулийн төсөлд газрыг Монгол Улсын иргэний өмчлөлд шилжүүлэх асуудал, хувийн өмчийн газартай холбогдсон харилцааны зохицуулалт иж бүрнээрээ тусгагдаагүй байна гэсэн үндэслэлээр Улсын Их Хурлын олонхи гишүүдийн сансрын дагуу төслийг гүйцээн боловсруулахаар хууль санаачлагчид буцаасугай.

2. Монгол Улсын иргэнд газар өмчлүүдэх тухай хуулийн төслийг 1996 оны 12 дугаар сарын 1-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газар /М. Энхсайхан/-г даалгасугай.

Дарга

Р. ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 10 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 50

Улаанбаатар
хот

**"Ардын эрх" сонинны Ерөнхий эрхлэгчийг
томилгох тухай**

Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Төрийн төв хэвлэл "Ардын эрх" сонинны ерөнхий эрхлэгчээр Жамбалын Мягмарсүрэнг томилсугай.

Дарга

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1996 оны 10 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 51

Улаанбаатар
хот

Засгийн газрын гишүүнийг
томилгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайдаар Шүхэрийн Алтангэрэлийг томилсугай.

Дарга

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1996 оны 10 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 52

Улаанбаатар
хот

Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнийг
чөлөөлөх, нөхөн томилгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 50 дугаар зүйл, Шүүхийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийн 1, 7, 8 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Галнжуурын Ганбалдыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээс чөлөөлсүгэй.

2. Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Дэлгэрмааг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр нөхөн томилсугай.

Дарга

Р. ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 10 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 54

Улаанбаатар
хот

**Орон сууцны хөлсний дээд хэмжээ
тогтоох тухай**

Шүүхийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 9 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн орон сууцны хөлсний улсын төсвөөс санхүүжүүлэх дээд хэмжээг тухайн үед дагаж мөрдөж байгаа улсын орон сууцны 42 ам метр талбайд ногдох хөлсөөр тооцон олгож байхаар тогтоосугай.

2. Энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн орон сууцны хөлсийг Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1994 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн хуулийн дагуу 1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн олгохоор тогтоосугай.

Дэд дарга

Ц. ЭЛБЭГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 10 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 55

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны 7 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн "Төрийн дээд шагналын тухай" Монгол Улсын хуулийн төсөлд улс орны хөгжлийн шинэ чөхцөл байдал, төрийн дээд шагнал олгодог үндэсний уламжлалыг зүрэн харгалзаагүй байна гэж үзэж уг төслийг дахин боловсруулахаар хууль санаачлагчид буцаасугай.

Дэд дарга

Ц. ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

1996 оны 10 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 56

Улаанбаатар
хот

Шүүхийн тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай хуулийг
хэрэгжүүлэх зарим арга
хэмжээний тухай

Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсноос хойш нэг сарын хугацаанд багтаан Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албыг орон тоо, төсөв, хөрөнгийн хамт Хууль зүйн яаманд шилжүүлэхийг Улсын дээд шүүх /Д. Дэмбэрэлцэрэн/-д даалгасугай.

2. Шүүгчийн ёс зүйн хэм хэмжээний тухай дүрмийг 1997 оны эхний хагаст багтаан гаргахыг Шүүхийн ерөнхий зөвлөл /Ж.Амарсанаа/-д даалгасугай.

Дэд дарга

Ц. ЭЛБЭГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 10 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 57

Улаанбаатар
хот

**Шүүгчид нэмэгдэл олгох журам
батлах тухай**

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалт, 6 дахь хэсэг, Шүүхийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. "Шүүгчийн шүүн таслах ажлын онцгой нөхцлийн нэмэгдэл, түүнийг олгох журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Шүүгчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, түүнийг олгох журам"-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрдмийн зэрэг, цолтой шүүгчдэд эрдмийн зэрэг, цолны нэмэгдэл олгохдоо Засгийн газраас баталсан Төрийн албан хаагчид эрдмийн зэрэг, цолны нэмэгдэл олгох журмыг баримталж байхаар тогтоосугай.

3. Шүүгчид шүүн таслах ажлын онцгой нөхцлийн болон төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг олгоход шаардагдах зардлыг шүүхийн жил бүрийн төвлөрсөн төсөвт тусгаж байхаар тогтоосугай.

Дээд дарга

Ц. ЭЛБЭГДОРЖ

Монгол Улсын Их Хурлын
1996 оны 57 дугаар тогтоолын
1 дүгээр хавсралт

**ШҮҮГЧИЙН ШҮҮН ТАСЛАХ АЖЛЫН ОНЦГОЙ
НӨХЦЛИЙН НЭМЭГДЭЛ, ТҮҮНИЙГ ОЛГОХ
ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалт, 6 дахь хэсэг, Шүүхийн тухай хуулийн 64

дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын шүүхийн шүүгчид шүүн таслах ажлын онцгой нөхцлийн нэмэгдэл олгоход энэ журмыг мөрдөнө.

2. Шүүн таслах ажлын онцгой нөхцлийн нэмэгдэл нь шүүгчээс шүүх эрх мэдлийг хараат бусаар, гагцхүү Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад албан үүргийг гүйцэтгэсний нь төлөө төрөөс олгож байгаа урамшуулал, шүүгчийн хараат бус байдлын баталгааны нэг мөн.

Хоёр. Шүүн таслах ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийн хэмжээ, түүнийг олгох

3. Шүүгчийн шүүн таслах ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийг тухайн шүүгчийн авч байгаа албан тушаалын үндсэн цалингийн 15 хувиар бодож сар бүр олгоно.

4. Шүүн таслах ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийг бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч, шүүгчийг орлон ажиллаж байгаа туслах шүүгч болон өндөр насны тэтгэвэрт байгаа шүүгчид шүүгчийн албан тушаалд ажиллаж байгаа хугацаанд нь олгоно.

5. Энэ журмаар тогтоосон нэмэгдлийг 1996 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн олгоно.

Монгол Улсын Их Хурлын
1996 оны 57 дугаар тогтоолын
2 дугаар хавсралт

ШҮҮГЧИЙН ТӨРИЙН АЛБА ХААСАН ХУГАЦААНЫ НЭМЭГДЭЛ, ТҮҮНИЙГ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалт, 6 дахь хэсэг, Шүүхийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын шүүхийн шүүгчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгоход энэ журмыг мөрдөнө.

2. Шүүгчид олгох төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл нь шүүгчийг тогтвор суурьшилтай ажиллуулах, шүүгчийн хараат бус байдлыг хангах баталгааны нэг мөн.

Хоёр. Шүүгчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн хэмжээ, түүнийг олгох

3. Шүүгчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн шүүгчийн төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан түүний албан тушаалын сарын цалингаас дор дурдсан хувиар бодож олгоно:

Төрийн алба хаасан хугацаа /жилээр/	Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн хэмжээ /хувиар/
5-10	5
11-15	10
16-20	15
21-25	20
26 ба түүнээс дээш	25

4. Шүүгчийн төрийн алба хаасан хугацаанд дараахь хугацааг оруулан тооцно:

1/ төрийн албанд ажилласан;
 2 /өмгөөлөгчөөр ажилласан;
 3/ төрийн алба хаах болон өмгөөлөгчөөр ажиллах хугацаандаа мэргэжил, мэргэшлээ дээшлүүлэх, дахин мэргэших, шинээр мэргэжил эзэмших, дамжаа болон магистрантур, аспирантур, докторантурт суралцсан;

4/ төрийн алба хаах болон өмгөөлөгчөөр ажиллах хугацаандаа жирэмсний, амаржсаны болон хууль тогтоомжийн дагуу чөлөөтэй байсан;

5/ төрийн болон өмгөөлөх байгууллагын дотоод дүрэмд заасны дагуу чөлөөтэй байсан;

6/төрийн алба хаах болон өмгөөлөгчөөр ажиллах үедээ ажлаас үндэслэлгүй халагдсаны улмаас ажилгүй байсан болон хэргийг нь шүүхээс хэрэгсэхгүй болгосон, цагаатгагдсан хүмүүсийн мөрдөгдсөн ба ял эдэлсэн /өршөөл, уучлалаар суллагдсан хүмүүс үүнд хамаарахгүй/.

5. Төрийн алба хаасан хугацааг шүүхийн тамгын хэлтсээс тодорхойлж, шүүгчид олгох төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн хувийг Улсын Дээд шүүх болон аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар тогтоож байна.

6. Төрийн алба хаасан хугацааг тогтоох үндсэн баримт нь хөдөлмөрийн дэвтэр, нийгмийн даатгалын дэвтэр болно.

7. Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч, шүүгчийг орлон ажиллаж байгаа

туслах шүүгч болон өндөр насны тэтгэвэрт байгаа шүүгчид олгоно.

8. Энэ журмаар тогтоосон нэмэгдлийг 1996 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн олгоно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1996 оны 10 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 58

Улаабаатар
хот

Прокурорт нэмэгдэл олгох журам батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалт болон 6 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Прокурорт албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдэл олгох журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Прокурорт төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрдмийн зэрэг, цолтой прокурорт эрдмийн зэрэг, цолны нэмэгдэл олгохдоо Засгийн газраас баталсан Төрийн албан хаагчид эрдмийн зэрэг, цолны нэмэгдэл олгох журмыг баримталж байхаар тогтоосугай.

3. Прокурорт албан ажлын онцгой нөхцлийн болон төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг олгоход шаардагдах зардлыг прокурорын байгууллагын жил бүрийн нэгдсэн төсөвт тусгаж байхаар тогтоосугай.

Дэд дарга

Ц. Элбэгдорж

Монгол Улсын Их Хурлын 1996 оны
58 дугаар тогтоолын 1 дүгээр
хавсралт

ПРОКУРОРТ АЛБАН АЖЛЫН ОНЦГОЙ НӨХЦЛИЙН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

1. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасны дагуу төрийн тусгай албан тушаал эрхэлж буй прокурор хэрэг бүртгэх,

мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралданд төрийн нэрийн өмнөөс оролцох хариуцлагатай үүргийг гүйцэтгэж байгаа хугацаанд нь албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдэл олгоход энэ журмыг мөрдөнө.

2. Улсын ерөнхий прокурор, түүний орлогч, туслах, аймаг, нийслэл, тээврийн прокурор, тэдгээрийн орлогч болон сум, сум дундын буюу дүүргийн ахлах прокурорт албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийг тухайн албан хаагчийн сарын цалингийн 15 хувиар, бусад прокурорт 10 хувиар тус тус бодож олгоно.

Улсын Их Хурлын 1996 оны 58
дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ПРОКУРОРТ ТӨРИЙН АЛБА ХААСАН ХУГАЦААНЫ НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

1. Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий бүх шатны прокуроруудыг тогтвор суурьшилтай ажиллуулах, төрийн тусгай албыг бэхжүүлэх зорилгоор төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгоход энэ журмыг мөрдөнө.

2. Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн ажилтны төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан түүний албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож олгоно:

Төрийн алба хаасан хугацаа /жилээр/	Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн хэмжээ /хувиар/
5-10	5
11-15	10
16-20	15
21-25	20
26 ба түүнээс дээш	25

3. Төрийн алба хаасан хугацаанд дараахь хугацааг оруулан гооцно:

а/ төрийн албанд ажилласан;

б/ төрийн албанд ажиллах хугацаандаа мэргэжил, мэргэшлээ дээшлүүлэх, дахин мэргэших, шинээр мэргэжил эзэмших дамжаа болон магистрантур, аспирантур, докторантурт суралцсан;

в/ төрийн албанд ажиллах хугацаандаа жирэмсний, амаржсаны болон хууль тогтоомжийн дагуу чөлөөтэй байсан;

г/ төрийн байгууллагын дотоод дүрэмд заасны дагуу чөлөөтэй байсан;

д/ төрийн байгууллагад ажиллах үедээ ажлаас үндэслэлгүйгээр халагдсаны улмаас ажилгүй байсан болон хэргийг нь шүүхээс хэрэгсэхгүй болгосон, цагаатгагдсан хүмүүсийн мөрдөгдсөн ба ял эдэлсэн /өргөөл уучлалар суллагдсан хүмүүс үүнд хамаарахгүй/;

4. Төрийн алба хаасан хугацааг Улсын ерөнхий прокурорын Хэрэг эрхлэх газар тодорхойлж, Улсын ерөнхий прокурорын тушаалаар нэмэгдэл олгох хувийг тогтоож байна.

5. Төрийн албанд ажилласан хугацааг тогтоох үндсэн баримт нь хөдөлмөрийн дэвтэр, нийгмийн даатгалын дэвтэр болно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1996 оны 10 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 59

Улаанбаатар
хот

**Д. Моломжамцыг үүрэгт ажлаас нь
чөлөөлөх тухай**

Монгол Улсын Төв банкны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 3-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ нь:**

Өөрийнх нь хүсэлтийг харгалзан Дэмчигжавын Моломжамцыг Монголбанкны Ерөнхийлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Дэд дарга

Ц. Элбэгдорж

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 10 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 60

Улаанбаатар
хот

**Монголбанкны Ерөнхийлөгчийг
томилгох тухай**

Монгол Улсын Төв банкны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1,3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Монголбанкны Ерөнхийлөгчөөр Жигжидийн Үнэнбатыг томилсугай.

Дэд дарга

Ц. ЭЛБЭГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 11 дүгээр
сарын 8-ны өдөр

Дугаар 62

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 1996 оны 10 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их хуралд өргөн мэдүүлсэн "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль"-ийн төсөл нь Үндсэн хууль болон холбогдох бусад хуулийн зарчимтай нийцэхгүй байна хэмээн үзэж Улсын Их Хурлын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

"Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль"-ийн төслийг дахин боловсруулахаар хууль санаачлагчид буцаасугай.

Дарга

Р. ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 11 дүгээр
сарын 15-ны өдөр

Дугаар 63

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын гишүүн Б. Дэлгэрмаагаас Улсын Их хуралд 1996 оны 11 дүгээр сарын 8-нд өргөн барьсан Монгол Улсын Эрүүгийн хуулийн 224, Иргэний хуулийн 368, Мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, банкны хээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хууль санаачлагчид буцаасугай.

Дарга

Р. ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 11 дүгээр
сарын 15-ны өдөр

Дугаар 64

Улаанбаатар
хот

**Үндсэн хуулийн нэнийн
дүгнэлтийн тухай**

Өршөөл үзүүлэх тухай 1996 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн Монгол Улсын хуулийн заалтын талаар Үндсэн хуулийн цэцэс гаргасан 08 тоот дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45², 50 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монголын тулгар төрийг үүсгэн байгуулсны 790 жилийн ойг тохиолдуулан насанд хүрээгүй этгээд, эмэгтэйчүүд, 60, түүнээс дээш насны эрэгтэйчүүдэд өршөөл үзүүлэх тухай Монгол Улсын хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчөөгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 08 тоот дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

Дарга

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

1996 оны 11 дүгээр
сарын 15-ны өдөр

Дугаар 65

Улаанбаатар
хот

Эдийн засаг, худалдааны чөлөөт
бүс байгуулах бэлтгэл ажлыг эр-
чимжүүлэх талаар авах зарим
арга хэмжээний тухай

Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл
баримтлалыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлаас
ТОГТООХ нь:

1. Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын нутагт "Алтанбулаг"
эдийн засаг, худалдааны чөлөөт бүс байгуулах бэлтгэл ажлыг
эрчимжүүлэхэд чиглэгдсэн дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг
Засгийн газар /М. Энхсайхан/-г даалгасугай.

1/ бүсийн хөгжлийн ерөнхий төсөл /мастер төлөвлөгөө/-ийг
боловсруулан, тэргүүн ээлжинд хэрэгжүүлэх төслүүдийг сонгон
тогтоох;

2/ тэргүүн ээлжийн төслийг хэрэгжүүлэхэд улсаас дэмжлэг
үзүүлж, хөрөнгийн шаардлагатай эх үүсвэрийг бүрдүүлэх асуудлыг
султан шийдвэрлэх;

3/ "Алтанбулаг" эдийн засаг, худалдааны чөлөөт бүсийн
ашиглалтын өмнөх захиргаанд хөрөнгө, санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

4/ гадаад орны чөлөөт бүсийн туршлага судлуулах, мэргэжилтэй
боловсон хүчин бэлтгэх тодорхой арга хэмжээ авах;

5/ "Алтанбулаг" эдийн засаг, худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн
зохицуулалтын асуудлыг боловсруулж, 1996 онд багтаан Улсын Их
Хуралд өргөн мэдүүлэх.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төсөн,
санхүү, эдийн засгийн бодлогын байнгын хороо /Д. Ганболд/-нд
даалгасугай.

Дарга

Р. ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 11 дүгээр
сарын 15-ны өдөр

Дугаар 66

Улаанбаатар
хот

Хилийн зааг тогтоох тухай

"Алтанбулаг" эдийн засаг, худалдааны чөлөөт бүс байгуулах бэлтгэл ажлыг эхлэх үүднээс Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

"Алтанбулаг" эдийн засаг, худалдааны чөлөөт бүс нь Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын нутаг дэвсгэрийн хилийн цэсийн дотор 500 га талбай газар нутагтай байхаар тогтоож, хилийн заагийг хавсралт ёсоор баталсугай.

Дарга

Р. ГОНЧИГДОРЖ

УИХ-ын 1996 оны 66 дугаар
тогтоолын хавсралт

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН АЛТАНБУЛАГ СУМЫН
НУТАГ ДАХЬ "АЛТАНБУЛАГ" ЭДИЙН ЗАСАГ
ХУДАЛДААНЫ ЧӨЛӨӨТ БҮСИЙН ХИЛИЙН
ЗААГ**

Хөдөө аж ахуйн техникумын байсан хашааны баруун хойд буланг I шон болгон авч зүүн тийш төв замаас салсан замын хойд талаар 120 м явж II шон, II шонгоос хойд зүгт 85 м явж III шон, III шонгоос зүүн тийш 75 м явж IV шон, IV шонгоос урагш 79 м явж V шон, V шонгоос зүүн тийш 250 м явж VI шон, VI шонгоос хойшоо эргэж 491 м явж булгийн зүүн хойд талд VII шон, VII шонгоос баруун тийш хилийн гарц хүртэл 761 м явж VIII шон, VIII шонгоос хойшоо 66 м явж IX шон, IX шонгоос зүүн тийш 748 м явж X шон, X шонгоос зүүн тийш 1085 м явж XI шон, XI шонгоос хойшоо Бүрэгтийн уулын энгэр лүү 911 м явж XII шон, XII шонгоос зүүн тийш 503 м явж XIII шон, XIII шонгоос урагшаа 742 м явж жалга гарсан замын дэргэдэх XIV шон, XIV шонгоос зүүн тийш 957 м явж XV шон, XV шонгоос зүүн урагш Агитын ухаагийн баруун хажуу руу 1253 м явж XVI шон, XVI шонгоос баруун урагш 1636 м явж XVII шон, XVII шонгоос баруун хойшоо 965 м явж

ХҮШ шон, ХҮШ шонгоос гэр хорооллын араар 923 м явж XIX шон, XIX шонгоос хойшоо 377 м явж XX шон, XX шонгоос баруун тийш 253 м явж XXI шон, XXI шонгоос урагш 351 м явж XXII шон, XXII шонгоос баруун тийш 235 м явж XXIII шон, XXIII шонгоос хойшоо эргэж төв засмал замын дагуу 397 м явж I шон хүрч хиллэнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1996 оны 11 дүтээр
сарын 28-ны өдөр

Дугаар 67

Улаанбаатар
хот

Улсын төвлөрсөн төсвийн
адлагдлыг багасгах зарим
арга хэмжээний тухай

Эдийн засгийн өсөлтийн үндсийг тавьж, нийгмийн хөгжлийг хангах хөрөнгийн эх үүсвэр бий болгох зорилгоор Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

НЭГ. Дор дудсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай:

1. Мөнгө, төсөв, төлбөрийн тэнцэл, үндэсний тооцооны үзүүлэлтүүдийн талаар 1997 онд дэвшүүж буй зорилтуудыг хэрэгжүүлэх, төгрөгийн үнэгүйдлийг багасгах, инфляцийн өсөлтийг хязгаарлах, арилжааны банкуудын тогтолцоо, үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн тууштай арга хэмжээг Монголбанктай хамтран авч хэрэгжүүлэх.

2. Зээл, тусламж, өрийн удирдлага, зохицуулалтыг боловсронгуй болгож, санхүү, эдийн засгийн үр ашигтай хуваарилалт, хяналтын механизм бий болгох.

3. Хувийн хэвшлийг хөгжүүлэх ажил тэгш, таатай орчин бүрдүүлж, монополийг задлах, шинээр үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

4. Соёл, боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, биеийн тамир, спорт, нийгмийн даатгал, нийгмийн хамгааллын төв, орон нутгийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг зах зээлийн зарчимд нийцүүлэх, тэлгээрт аккредитаци явуулах ажлыг 1997 оноос эхэлж, түүний явц байдлыг Улсын Их Хуралд танилцуулж байх. Үүнд:

а/ орон нутгийн Хурал, захиргааны байгууллагад тодорхой эрх мэдлийг шилжүүлэх үндсэн дээр төрийн захиргааны байгууллагуу-

дын удирдлагыг цомхотгож тохируулагч болон хэрэгжүүлэгч агентуудын бүтэц, орон тоог дахин авч үзэж оновчтой тогтоох;

б/ салбар, орон нутгийн удирдлагын давхардлыг арилгах, ачаалал, ижил үүргийн хуваарийг нь хянан үзэх, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид өөрчлөлт оруулах, аймаг, сум, баг, дүүргийн тоог цөөрүүлэх асуудлыг судалж санал боловсруулах;

в/ соёл, урлаг, биеийн тамир, спорт, радио, телевиз, мэдээллийн байгууллагуудын заримыг хувьчлан бизнесийн үйл ажиллагаатай нягт холбож төрийн оролцоог дэс дараалалтайгаар бууруулах арга хэмжээ авах;

г/ бүх шатны сургуулиудыг хамарсан аккредитаци явуулж, стандартын төвшин бий болгох замаар анги дүүргэлт, нэг багшид ногдох хүүхдийн тоо, багш болон багш бус ажилтны эхлестой харьцаа, хичээл заах цагийн норм зэрэг үзүүлэлтүүдийг сургуулийн төрөл, бүс нутгийн онцлог байдлыг харгалзан хэмнэлттэй ажиллах нөхцөл зарчмаар тогтоохын хамтаар цөөн суралцагчидтай, ижил төрлийн үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа мэргэжлийн сургалт үйлдвэртэлийн төв, коллеж, их, дээд сургуулиудын бүтэц, зохион байгуулалтыг хянан үзэж, төсөл шалгаруулах замаар заримыг нь хувьчлах;

д/ бие хүн өөрийнхөө эрүүл мэндийн төлөө санал тавих хариуцлагыг өндөржүүлэх, эрүүл мэндийн зөвлөх төвийн үйл ажиллагааны давхардлыг арилгах, эмнэлгийн зарим төрлийн үйлчилгээг хувьчлах, орон нутгийн онцлолт нийлсэн нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээний сүлжээ бий болгох, нэг эмнэлгийн ажилтанд хамрагдах хүн амын тоо, нэг өвчтөнд үйлчлэх эмнэлгийн ажилтны тоо зэрэг нормативт үзүүлэлтүүдийг бүс нутгаар тогтооход чиглүүдэж эрүүл мэндийн нийт байгууллагуудыг хамруулан аккредитаци явуулах;

е/ нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын сангуудын зохион байгуулалт, удирдлагыг боловсронгуй болгож, тэтгэвэр, тэтгэмжид хамрагдаж буй өндөр настны амьжиргааг сайжруулахад чиглэсэн шударга зарчмын үндсэн дээр нийгмийн хамгааллыг жинхэнэ эдлэл ёстой хүнд нь хүргэж тэднийг ядуурлаас хамгаалах, нийгмийн халамжийн болон ядуурлыг бууруулах сангийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, ажлын байр шинээр бий болгохыг бүхий л талаар дэмжих;

ж/ шинжилгэх ухааны зарим байгууллагууд нэг чиглэлийн ижил үүрэг бүхий олон жижиг хэсэгт хуваагдаж, шинжилгээ, судалгааны ажилд зориулагдаж буй доронгийн багагүй хэсэг нь захиргаа, үйлчилгээний ажилд зарцуулагдаж байгаад дүгнэлт хийж, бүтцийн дорвитой өөрчлөлт оруулах, аж ахуйн нэгж, байгууллагуудын

захиалга, хөрөнгөөр хийх эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөтгөх арга хэмжээ авч төсвийн хөрөнгийн оролцоог ээлж дараатайгаар бууруулах;

з/ улс орны санхүү, эдийн засгийн хүч болоцоонд тулгуурлан улс төр, эдийн засаг, соёлын хамтын ажиллагаагаа уялдуулан зохицуулах замаар гадаадад суугаа дипломат төлөөлөгчдийн газрын байршлыг оновчтой болгож, тэдгээрийн орон тоог хянаж үзэх;

и/ армид хийх шинэтгэлийг гүнгийрүүлж, хил хамгаалалтаа бэхжүүлэхэд илүү анхаарч хугацаат цэргийн алба хаагчийн тоог эрс хорогдуулж, цэргийн алба хаах насны хүмүүсийг дүйцүүлэх албанд хамруулах, тэдэнд мөнгөн төлбөр ногдуулах асуудлыг судалж санал боловсруулах;

к/ төрийн албанд ажиллагсад өрхийн аж ахуй эрхлэх боломж нөхцөл бүрдүүлэх, тэднээс гэр бүл, үр хүүхдийнхээ хүмүүжилд халамж анхаарал тавих чөлөөт цагийг ихэсгэх, өөрийгөө хөгжүүлэх, нийгмийн бусад асуудлыг шийдвэрлэхэд зориулах цагийг нь нэмэгдүүлэх зорилгоор долоо хоногийн Бямба гаригийг ажлын бус өдөр болгох асуудлыг судалж шийдвэрлүүлэх.

5. Шинэ бүтцэд шилжсэн төсөвт байгууллагууд орон тоогоо бууруулах арга хэмжээ авсан нөхцөлд хэмнэгдсэн цалинг зөвхөн үр дүнтэй идэвхи зүтгэлтэй ажиллаж байгаа ажилтнуудын цалин хөлсийг нэмэгдүүлэх зориулалтаар ашиглах журам тогтоох.

6. Хөдөөгийн сумдын нийт төсөвт байгууллагууд болон аймгийн төвийн сум, нийслэлийн дүүрэгт ойролцоо байршилтай сургууль, цэцэрлэг, ясли зэрэг төсөвт байгууллагуудын аж ахуй, санхүүг нэгдсэн байдлаар зохион байгуулж, материал, техникийн хангамж, үйлчилгээг нь сайжруулах арга хэмжээг орон нутгийн нөхцөл байдалд тохируулан авч хэрэгжүүлэх.

7. Төсвийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад тавих хяналтыг хүчтэй болгох, төсвийн сахилгыг сайжруулах зорилгоор 1997 оноос эхлэн цахилгаан, дулааны эрчим хүч, ус, нүүрс, мод, тээврийн хөлсний зардлыг санхүүжүүлэхдээ тухайн төсөвт байгууллагад үйлчлэгч аж ахуйн нэгж, байгууллагаас өгсөн нэхэмжлэлийг зах зээлийн үнийн төвшинтэй харьцуулан хянаж, төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн батлагдсан төсөвт багтаан төсвийн срөнхийлөн захирагчид шууд санхүүжүүлж байхаар журамлах.

ХОЁР. Энэ тогтоолын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, явц, үр дүнг нь тухай бүр авч үзэж байхыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодод үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 11 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар 70

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Улсын Их Хурлын гишүүн Ж. Бямбадоржийн 1996 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн "Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай" хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэр тодорхойгүй байна гэж үзэж уг төслийг хууль санаачлагчид буцаасугай.

Дарга

Р. ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 12 дугаар
сарын 5-ны өдөр

Дугаар 71

Улаанбаатар
хот

**Дэлхийн худалдааны байгууллагад
 гишүүнээр элссэнтэй холбогдуулан
 авах арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Дэлхийн худалдааны байгууллагад гишүүнээр элссэнтэй холбогдуулан дор дурдсан арга хэмжээ авахыг Засгийн газар /М. ЭНХСАЙХАН/-г даалгасугай:

1/ Монгол Улсын хууль тогтоомжийг Дэлхийн худалдааны байгууллагын Олон талт худалдааны хэлэлцээрүүдэд нийцүүлэн энэ онд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/ Уругвайн үе шатны хэлэлцээний төгсгөлийн баримт бичгийг олон улсын худалдааны байгууллагуудтай хамтран сурталчлах, яам,

газруудын ажилтнуудад зориулж сургалт зохион байгуулах;

3/ Дэлхийн худалдааны байгууллагын Олон талт худалдааны хэлэлцээрүүдийн орчуулгыг хянаж эмхтгэл болгон хэвлэх ажилд зориулан хөрөнгийн эх үүсвэр гаргах;

4/ Дэлхийн худалдааны байгууллагын Олон талт худалдааны хэлэлцээрүүдийг хариуцан хэрэгжүүлэх, тэдгээрт заасан мэдээ, мэдээллийг тогтмол гаргаж байх;

5/ Дэлхийн худалдааны байгууллагад гишүүнээр элссэнтэй холбогдуулан хяналт, зохицуулалтын чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Гадаад харилцааны яамны орон тоо, зохион байгуулалтад холбогдох өөрчлөлт оруулах.

Дарга

Р. ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 12 дугаар
сарын 5-ны өдөр

Дугаар 72

Улаанбаатар
хот

Бүгд Найрамдах Перу Улстай
дипломат харилцаа тогтооход тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь: Бүгд Найрамдах Перу Улстай дипломат харилцаа тогтоосугай.

Дарга

Р. ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 12 дугаар
сарын 6-ны өдөр

Дугаар 73

Улаанбаатар
хот

Төрөөс мөнгөний бодлогын талаар
1997 онд баримтлах чиглэлийг
батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төрөөс мөнгөний бодлогын талаар 1997 онд баримтлах чиглэлийг хавсралтаар баталсугай.

2. Төрийн мөнгөний бодлогын чиглэлийг хэрэгжүүлэх ажлыг Засгийн газартай хамтран зохион байгуулж, дүнг улирал бүр Улсын Их Хуралд танилцуулж байхыг Монголбанк /Ж. ҮНЭНБАТ/-нд даалгасугай.

Дарга

Р. ГОНЧИГДОРЖ

Монгол Улсын Их Хурлын 1996 оны
73 дугаар тогтоолын хавсралт

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 1997 ОНД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

Төрөөс 1997 онд баримтлах мөнгөний бодлогын үндсэн зорилт нь дотоодын үнийн өсөлтийг бууруулж, төгрөгийн худалдан авах чадварыг цаашид тогтворжуулах явдал мөн. Энэхүү зорилтын хүрээнд хэрэгжүүлэх бодлогын чанартай арга хэмжээнүүд нь зах зээлийн харилцааны зарчим, банкны хууль тогтоомжийн үзэл санаанд нийцэж, макро эдийн засгийн бусад бодлоготой уялдахын зэрэгцээ банкны бүтэц, тогтолцоог өөрчлөн сайжруулах, санхүү, зээлийн сахилгыг дээшлүүлэх замаар хадгаламж эзэмшигч, харилцагчдын банкны системд итгэх итгэлийг бэхжүүлэхэд чиглэгдэнэ.

НЭГ. Мөнгөний нийлүүлэлтийн талаар

Мөнгөний бодлогын шууд болон шууд бус арга хэрэгслүүдээр дамжуулан нөөц мөнгө, нийт мөнгөнд нөлөөлөх замаар мөнгөний нийлүүлэлтийг нь зохицуулж, нийт мөнгөний жилийн өсөлтийг 26 хувиас хэтрүүлэхгүй байна. Мөнгөний бодлогын арга хэрэгслүүдийн хоорондын уялдаа холбоог сайжруулан үр нөлөөг нь дээшлүүлнэ.

Мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах, банктай харилцагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор заавал байлгах нөөцийн доод хэмжээг зохистой тогтоож, банк түүнийг тогтмол хангаж байх шаардлагыг хэвшүүлнэ.

Төв Банкнаас нөөц мөнгийг удирдах зорилтод нийцүүлэн үнэт цаасыг үргэлжлүүлэн гаргаж, түүнийг Засгийн газрын үнэт цаасны арилжаатай уялдуулан зохицуулж ажиллана.

Төв Банкнаас олгох зээлийн хэмжээг банкуудын зээлжих чадварын хязгаарт багтаан тогтоож түүнийг хатуу мөрдөх бөгөөд

дахин санхүүжилтийн болон хямдруулалтын зээл нь банкуудын гур хугацааны эх үүсвэрийн хэрэгцээнд зориулан олгох зээлийн үндсэн хэлбэр байх болно. Төв банкнаас эцсийн зээлдүүлэгчийн хувьд олгох зээл нь бүрэн баталгаажсан байх, бүтцийн өөрчлөлтийн дагуу зохих арга хэмжээ авч үр дүнд хүрсэн банкинд хуваарилах зарчим баримтална.

Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн зарим банкинд тэдний зээлийн эх үүсвэр, санхүү төлбөрийн чадварыг харгалзан зээлийн өрийн үлдэгдэлд нь хязгаар тогтооно.

Иргэдийн мөнгөн хадгаламжийг хамгаалах оновчтой тогтолцоог бий болгох арга хэмжээ авч эхэлнэ.

ХОЁР. Банкны системийн бүтэц, тогтолцоог өөрчлөх талаар

1997 онд төрөөс банкны системийн бүтэц тогтолцоог өөрчлөн сайжруулах арга хэмжээ нь харилцагчдын банкинд итгэх итгэлийг даруй бэхжүүлж улмаар зах зээлд үндэслэсэн санхүүгийн нөөцийг үр ашигтай хуваарилах механизмыг бүрдүүлэхэд чиглэнэ.

Банкны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкнаас авах зээл туслалцааг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулахад чиглүүлэн банкуудын санхүү, төлбөрийн чадварыг сайжруулж, өөрийн хөрөнгийг сэргээн нэмэгдүүлэхэд чиглэсэн бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээнүүдийг бодитой хэрэгжүүлнэ.

Хуучин тогтолцооноос шилжиж ирсэн болон Засгийн газрын шийдвэрээр олгосон төлөгдөх найдваргүй өрийг зах зээлийн хүүтэй Засгийн газрын үнэт цаасаар сольж, түүний төлбөр, хүүг төсөвт тусгах замаар арилжланы банкуудад төлж, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг сайжруулах, төлбөрийн чадвар муудсан банкуудын активын хэмжээг бууруулах, бусдад худалдах, удирдлагыг нь өөрчлөх, банкуудын өмчлөлийг шинэчлэн тогтоох, дотоод хяналтыг өндөржүүлэх, банк хоорондын мэдээллийн системийг хөгжүүлэх, үйл ажиллагаа явуулах хууль зүйн орчинг сайжруулах зэрэг болно. Банкуудаар дамжин хийгдэж байгаа төсвийн төлбөр тооцоо, санхүүгийн үйлчилгээг төлбөртэй болгож ашигт ажиллагааны түвшинг нэмэгдүүлнэ.

Банкнаас зээл олгох, баталгаа гаргах, хөрөнгө оруулалт хийхэд хуулиар тогтоосон хязгаарлалтуудыг хатуу мөрдүүлнэ. Банкны худалдан авсан Засгийн газрын бондын хэмжээ нь нийт активын 15 хувиас хэтрэхгүй байхаар хязгаар тогтооно.

Банкны бус санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг

зохицуулах эрх зүйн тогтолцоог бий болгох зорилгоор тэдгээрийг байгуулах зөвшөөрөл олгох, үйл ажиллагаагаа эрхлэх, хязгаарлалт хийх, хяналт тавих, зөвшөөрөл цуцлах журмыг боловсруулж мөрдөнө.

ГУРАВ. Зээл, хүүгийн бодлогын талаар

Монголбанкнаас арилжааны банкинд олгох зээлийн хүү, гаргах үнэт цаасны дээд хүүг үнийн өөрчлөлт, зах зээлийн хүүгийн түвшинд үндэслэн тухай бүр өөрчлөн тогтоож байна.

Банк бүр чөлөөт эх үүсвэр, өөрийн хөрөнгө, төлбөрийн чадвар, зээлийн эрсдэлийн зохистой харьцаны шаардлага, үйл ажиллагааны онцлогтоо нийцүүлэн зээлийн бодлого боловсруулж мөрдөнө.

Зээлийн чанарыг сайжруулах, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авахын зэрэгцээ томоохон хэмжээний, үр ашигтай төслүүдийг санхүүжүүлэх нөхцөлийг сайжруулах зорилгоор банкны хамтын зээлжүүлэлт, түрээсийн зээл, ажил үйлчилгээний баримтаар баталгаажих зээл зэрэг санхүүжилтийн шинэ хэлбэрүүдийг дэмжинэ. Зээл эргэж төлөгдөх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

Санхүүгийн сахилгыг дээшлүүлэх ажлын хүрээнд төлөгдөх хугацаа нь хэтэрсэн зээлийг төлүүлэхэд банк, санхүү, хууль хяналтын байгууллагууд хамтран шаардлагатай бүх арга хэмжээг авна.

Банхууд зээлийн багцыг зөв ангилж, бүртгэлд бодит байдлаар тусгахын зэрэгцээ зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах санг зохих журмын дагуу бүрэн байгуулна. Зээлийн мэдээллийн нэгдсэн санг Монголбанкн дээр бий болгоно.

Дөрөв. Валютын бодлогын талаар

Төгрөгийн гадаад валютаар илэрхийлэгдэх нэгдсэн ханш зах зээл дээр үйлчлэх зарчмыг удирдлага болгох бөгөөд ханшийг бодитой, харьцангуй тогтвортой байлгах зорилтын хүрээнд шаардлагатай арга хэмжээг Засгийн газар, Монголбанкнаас авч хэрэгжүүлнэ.

ОУВС-ийн тухай хэлэлцээрийн 8 дугаар зүйлд Монгол Улс нэгдсэнтэй уялдаж, гадаад төлбөрийн тооцоог хугацаанд нь гүйцэтгэж, хугацаа хэтэрсэн өргүй байх, олон ханшийг халах болно.

Улсын валютын нөөцийг гадаад зах зээл дээр үр ашигтай байршуулах, гадаад валютын банк хоорондын зах зээлийн үйл ажиллагааг жигдрүүлэх, улмаар түүнийг өргөжүүлэх замаар валютын цэвэр нөөцийг нэмэгдүүлж оны эцэст 62,5 сая ам. долларт хүргэнэ. Жил бүр нэмэгдэж буй алтны үйлдвэрлэлийн гадаад цэвэр нөөц

болон дотоодын санхүүгийн зах зээл, валютын ханшид нөлөөлөх нөлөөллийг судалж, алт худалдан авах, худалдах санхүүгийн шинэ арга хэрэгслүүдийг нэвтрүүлнэ.

Банк хоорондын зах зээл дээр валютын арилжааг зохион байгуулах журмыг боловсруулан мөрдөж, валютын арилжааны үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулна.

ТАВ. Банкны бүртгэл, төлбөр тооцооны талаар

Банк хоорондын цахим сүлжээний найдвартай ажиллагааг хангаж, харилцан суутгах тооцооны зарчмыг хэрэгжүүлнэ.

Нийтээр даган мөрддөг бүртгэлийн зарчим, олон улсын жишгийг нэвтрүүлэх ажиллагааг эрчимжүүлж, Төв Банк болон арилжааны банкуудын нягтлан бодох, бүртгэлийн тайлангийн системийг боловсронгуй болгоно.

Банкны үйл ажиллагааг бодитойгоор үнэлж, нийтэд мэдээлэхэд хөндлөнгийн хяналтын байгууллагын үүргийг тодорхой болгож хөгжүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1996 оны 12 дугаар
сарын 6-ны өдөр

Дугаар 74

Улаанбаатар
хот

**"Монгол Улсын эдийн засаг,
нийгмийг 1997 онд хөгжүүлэх
Үндсэн чиглэл"-ийг батлах
тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 1997 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл"-ийг хэвсрэлтгаар баталсугай.

2. "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 1997 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл"-д тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 1997 оны III улиралд Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /М. Энхсайхан/-г даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 1997
ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
--------	-------------------------	---------	---------------

А. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

1. Эдийн засгийн бүтцийн оорчлолтийг эрчимжүүлж, макро эдийн засгийн механизмудын үйлчлэлийг оновчтой ашиглах замаар үндэсний үйлдвэрлэлийг сэргээн тогтворжуулахад чигтэсэн бодлого явуулна.

-1997 онд дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/-ийг 5,8 хувиар нэмэгдүүлэх
-Зах зээлийн эрэлт хэрэгцээг хангах, хүн амын өргөн хэрэглээний бараа үйлчилгээний хангамжийг нэмэгдүүлэх үүдсэн дээр инфляцийн түвшинг 1997 онд 35 хувиас хэтрүүлэхгүй байх
-Эдийн засгийн өсөлт, инфляцтай уялдуулан мөнгөний нийт нийлүүлэлтийг 30 хувиас илүү нэмэгдүүлэхгүй байх
-Аж ахуйн бүх салбарт хуримтлалыг нэмэгдүүлэх замаар ДНБ-д хуримтлалын сангийн эзлэх хувийг 14-өөс доошгүй байлгах
-Галалд валютын цэлэр нооцийг 62,5 сая ам. долларас доошгүй хэмжээнд хургах, гадаад ор төлбөрийг графикайн дагуу хугацаанд...

1997 Засгийн газар

1997 Засгийн газар

1997 Ж Үнэнбат
П. Цагаан

1997 П Цагаан,
аймаг,

1997 Засаг дарга нар

1997 Ж Үнэнбат
П Цагаан

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
<p>2. Төсвийн зарлагын бүтцийг оновчтой болгон зарлага санхүүжилтийг боловсронгуй болгоно.</p>	<p>-ДНБ-д төвлөрсөн төсвийн урсгал орлогын хэмжээг 19,6 хувь, урсгал зарлагын хэмжээг 18,7 хувь болгож, урсгал тэнцлийн ашгийг 0,9 хувьд хүргэж, төсвийн алдагдлыг 3,9 хувиас хэтрүүлэхгүй байх</p> <p>-Нийгмийн үйлчилгээний хүрээний салбаруудад бүтцийн өөрчлөлт хийх арга хэмжээг хэрэгжүүлэх</p> <p>-Төсөв хэмнэх зарлага санхүүжилтийг бууруулах чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэх. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Салбарын болон орон нутгийн удирдлагын зохистой хослолыг бий болгох зорилгоор төрийн захиргааны байгууллагуудын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг дахин хянан үзэж шинэчлэх төрийн захиргааны нэгжийн тоог цөөрүүлэх, тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагуудын бүтэц, бүрэлдэхүүнийг оновчтой тогтоох 	<p>1997</p> <p>1997</p> <p>1997</p> <p>-"-</p> <p>-"-</p>	<p>П. Цагаан</p> <p>П. Цагаан, холбогдох сайд нар</p> <p>-"-</p> <p>-"-</p>
<ul style="list-style-type: none"> • Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг шинэчлэн боловсруулж УИХ-д өргөн барих 		<p>1997 III улирал</p>	<p>Засгийн газар</p>

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
--------	-------------------------	---------	---------------

- Хөдөөгийн сумдын хувьд нийт төсөвт байгууллагууд, аймгийн төвийн сум, нийслэлийн дүүргийн хувьд ойролцоо байршилтай сургууль, цэцэрлэг, ясли зэрэг төсөвт байгууллагуудын аж ахуй санхүүг нэгдсэн байдлаар зохион байгуулж хангамж, үйлчилгээг нь сайжруулах арга хэмжээ авах
- Соёл, урлаг, спорт, биеийн тамир, радио телевиз, мэдээллийн байгууллагын зарим хэсгийг хувьчилж, бизнесийн үйл ажиллагаатай нягт холбож, төсвийн хөрөнгийн оролцоог аажмаар бууруулах алхам хийх
- Цахилгаан, дулаан, эрчим хүч, ус, нүүрс, модны үнэ, тээврийн хөлсний зардалыг хянан санхүүжүүлэхээ тухайн орон нутгийн зах зээлийн үнийн түвшингээр тооцож, ажил үйлчилгээ үзүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагад хянан олгож байх журам боловсруулж мөрдүүлэх

1997
I-II
улирал

П. Цагаан,
холбогдох сайд
нар

1997 III
улирал

Засгийн газар

1997

П. Цагаан

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
•	Бүх шатны сургуулиудыг хамарсан аккредитаци явуулах замаар хэмнэлттэй ажиллах нөхцөл бүрэлдүүлэх, цөөн суралцагчидтай, ижил төрлийн сургалт явуулж байгаа мэргэжлийн сургалт, үйлдвэртэлийн төв, коллеж, их, дээд сургуулиудын бүтэц, зохион байгуулалтыг хянан үзэх, заримыг нь хувьчлах	"-	Ч. Лхагважав П. Цагаан
•	Ерөнхий боловсролын сургуулиуд болон бололцоотой зарим төслийн байгууллагуудыг ажлын 5 өдөрт шилжүүлэх	1997	Ч. Лхагважав П. Цагаан, холбогдох сайд нар
•	Хувь хүн өөрийнхөө эрүүл мэндийн төлөө хариуцах хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр эрүүл мэндийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгож, эрүүл мэндийн төв, зөвлөх төвийн үйл ажиллагааны алхардлыг арилгах, эрүүл мэндийн нийт байгууллагыг хамарсан аккредитаци явуулах	1997	Л. Зориг П. Цагаан
•	Шингэлэх ухааны зарим байгууллагад бүтцийн дорвитой өөрчлөлт хийж, аж ахуйн нэгж, байгууллагуудын захиалга, хөрөнгөөр хийх эрдэм шинжилгээ,		

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
	<p>ажлыг өргөтгөх арга хэмжээ авч, төсвийн хөрөнгийн оролцоог бууруулах талаар журам боловсруулж хэрэгжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> Гадаадын зарим оронд суугаа дипломат төлөөлөгчдийн газрыг татан буулгах, бусад оронд суугаа элчин сайдуудад хавсран гүйцэтгэх боломжийг судлан шийдвэрлэх Армид шинэчлэлийг гүнзгийрүүлж, цэргийн анги, салбар, хугацааг цэргийн албан хаагчдын тоог хорогдуулах, цэргийн дүйцүүлэх албаны тогтолцоот бий болгох арга замыг судалж сандал боловсруулан хэрэгжүүлэх <p>Улирлагын зардалыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх</p>	<p>1997</p> <p>1997</p> <p>1-II улирал</p> <p>1997</p> <p>1997</p>	<p>Ч. Лхагважав П. Цагаан</p> <p>Ш. Алтангэрэл П. Цагаан</p> <p>Д. Дорлигжав П. Цагаан</p> <p>П. Цагаан, сайд нар, аймаг, нийслэлийн Засаг дарга</p> <p>Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг дарга</p> <p>П. Цагаан Ж. Үнэнбат</p>
3. Татвар тэлэгчдөө хамгаалахад чиглэсэн бодлого явуулж, тат-	<p>Хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, байршил зэргийг харгалзан багийн тоог цөөтөх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх</p> <p>-Иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, тэднээс банкнд итгэх итгэлийг бий болгох зорилгоор иргэдийн мөнгөн хадгаламжийн</p>	<p>1997</p> <p>1 сар</p>	<p>П. Цагаан Ж. Үнэнбат</p>

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Анхруулаач
<p>руулах, төсвийн бэл- зыг өргөтгөх, татвар төлөгчдийн хүрээг тэ- лэх, орон нутгийн төсвийн бие даасан байдлыг сайжруулахад анхаарна.</p>	<p>-Тэргүүний технологи, экспортыг дэмжих, байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц- бэлчлийг нөхөн сэргээх, дэд бүтцийг хөг- жүүлэх зориулалтын техник, тоног төхөө- рөмжийн элэгдлийн хэмжээг богино хуга- цаанд нэмэгдүүлж тооцох замаар татварын хөнгөлөлт үзүүлэх тухай журам боловсруулах</p>	<p>1997 III улир</p>	<p>Ц. Адылсүрэн Л. Нямсамбуу П. Цагаан Г. Нямдаваа</p>
	<p>-Хүн амын орлогын албан татварын шат- далыг цөөрүүлж сарын нийт орлого 24000 төгрөг /жилийн 288 мянга/-тэй тэнцэх буюу түүнээс бага орлоготой иргэдийг татаараас чөлөөлөх арга хэмжээ авах</p>	<p>1997</p>	<p>П. Цагаан</p>
	<p>-Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын шатлалыг цөөрүүлж, тат- варын хувь хэмжээг бууруулах арга хэмжээ авах</p>	<p>1997</p>	<p>" "</p>
	<p>-Богд шилжүүлснээр 150-нас доош толгой малтай, малаас өөр орлогын эх үүсвэргүй өрхийг бүх төрлийн татвараас чөлөөлөх -Иргэл, аж ахуйн нэгж, байгууллагын хө- рөнгө оруулах сонирхлыг дээшлүүлэх зорилгоор хувьцааны ноглол ашиг, хувь хүртэгчийн орлогоос авч буй татварын давхардлыг зогсоох</p>	<p>1997</p>	<p>" "</p>
		<p>1997</p>	<p>" "</p>

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
--------	-------------------------	---------	---------------

-Олон нийтийн болон шашны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын дэргэдэх туслах аж ахуй, орон сууц, цэцэрлэг, ясли зэрэг туслан үйлчлэх салбарын орлогод татвар ногдуулах ажлыг зохион байгуулах
 -Монгол улсад оршин суугч бус гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүний манай улсад олсон орлогын дүнгээс хуулийн дагуу татвар ногдуулах ажлыг зохион байгуулах

-Нефть бүтээгдэхүүний онцгой албан татварыг ялгавартай тогтоож байгаа одоогийн нөхцөлийг арилгаж, ижил нөхцөлтэй болгох

-Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд ногдуулах албан татварын хэмжээг нэмэгдүүлэх

-Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгчид ногдуулах татварын хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг боловсруулж хэрэгжүүлэх

-Хуалдааны татварыг үйлдвэртэл, үйлчилгээний бүх хүрээнд нэвтрүүлж, борлуулсны дараах орлогоос авах ажлыг зохион

1997

-"-

1997

-"-

1997

П. Цагаан

1997

П. Цагаан

-"-

-"-

-"-

-"-

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
	байгуулах	1997	П. Цагаан
-Ул хөдлөх хөрөнгийн татварын тухай хууль боловсруулж шийдвэрлүүлэх	татварын элдэв хөнгөлөлт, чөлөөлөлтийг цөөрүүлэх арга хэмжээ авах	1997, IV улир	"-
-Аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлэх татварын элдэв хөнгөлөлт, чөлөөлөлтийг цөөрүүлэх арга хэмжээ авах	-Говийн бүс нутагт ажиллагсдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх явдлыг дэмжих зорилгоор татварын хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж эхлэх	1997	"-
4. Татвараа нуух, татвараа төлөхгүй байх явдалтай хуулийн дагуу эрс шийдэмгий тэмцэл хийнэ.	-Аж ахуй эрхэлж байгаа иргэн анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөөгүй, хатас дутуу хөгөлсөн, орлого, зарлага тодорхойлоогүй бол эрхэлж байгаа үйлдвэртэл, үйлчилгээний салбарыг харгалзан татварын хэмжээг шинэчлэн ногдуулах арга хэмжээг хэрэгжүүлэх	1997 I сарнаас	П. Цагаан
	-Албан татвар төлөхөөс зайлсхийгчдын талаар нийтэд мэдээлж байх	1997	"-
	-Албан татвараа төлөөгүй салгуулсан татвар төлөгчдөд ногдуулах харууллагыг чангатгах зорилгоор хүү, торгуулийн хувь, хэмжээг нэмэгдүүлэх.	1997	"-

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
--------	-------------------------	---------	---------------

-Бүртгэл, хяналтын нэгэмжлэгдсэн үйл ажиллагааны /аудитийн/ тулай хууль боловсруулах

1997 -"-

-Төв, орон нутгийн төсвийн мэдээллийн системийг боловсронгуй шуурхай болгож, компьютерийн сүлжээнд холбох ажлыг эхлэх

1997 -"-

-Төсвийн орлого, зарлагын ангилал, Засгийн газрын төсвийн бүртгэл, статистикийн олон улсын жишигт нийцүүлэн өөрчилж, уг ангиллын дагуу төсвийн тайлан гаргах арга хэмжээ авах

1997
IV улир -"-

-Арилжааны даатгалын хуулийг боловсруулан мөрдүүлэх, даатгалын үйл ажиллагаанд тавих төрийн хяналтын механизм бий болгох, улсын даатгалын байгууллагыг хувьчлах ажлыг эхлэх

1997 -"-

-Улсын татварын албаг Үндэсний татварын алба болгон өөрчилж татварын албыг нэгдмэл, төвлөрсөн удирдлага бүхий зохион байгуулалтад оруулах

1997
II улирал -"-

-Татварын хүү, торгуулийн орлогоос зохиох хувь хэмжээгээр шимтгэл авч сан байгуулсан Үндэсний татварын албаны материаллаг бааз, ажиллагчдын мэдлэг

5. Татварын байгууллагыг бэхжүүлж хяналтыг сайжруулна.

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
	боловсролыг дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэртэхэд зориулах арга хэмжээг авч	1997 III улир- лаас	
6. Мөнгө, зээлийн боллогыг хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх, үнийн осолтийг бууруулах, төгрөгийн худалдан авах чадварыг тогтвортой байлгах, нийгмийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд чиглүүлнэ.	-Мөнгөний хатуу бодлогыг үргэжлүүлж, зээлийн хүүг инфляцийн түвшинтэй уялдуулан бууруулах арга хэмжээ авах	1997	Ж. Үлэнбат П. Цагаан
	-Арилжааны банкуудад бүтцийн өөрчлөлт хийж, хэзэ олгох, төлүүлэх үйл ажиллагааг эрс өөрчилж боловсронгуй болгох, банкны үйл ажиллагаанд тавих хяналтыг хүчтэй болгох	1997	Ж. Үлэнбат П. Цагаан
	-Арилжааны банкны төлбөрийн чадварыг сайжруулах санал боловсруулж шийдвэрлүүлэх -Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшигт бодитой, тогтвортой байлгах зорилгоор нэг ам. доллар, төгрөгийн харьцааг 1:700-аас хэтрүүлэхгүй байх, валютын зах,	1997	Ж. Үлэнбат П. Цагаан

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
7. Эдийн засаг, нийгмийн удирдлагын статистик, мэдээллийн үнэн, бодит байдалыг сайжруулах арга хэмжээ авна.	<ul style="list-style-type: none"> биржүүдийн ажлыг сайжруулах -Улсын статистикийн албаны бүтэц, зохион байгуулалтыг хянан үзэж шинэчлэх 	<ul style="list-style-type: none"> 1997 I улирал 	П. Цагаан
8. Өмч хувьчлалын ажлыг шинэ шатанд гаргаж, хувьчлалын шинэ арга хэлбэрүүдийг нэвтрүүлэн, эрчимжүүлэх арга хэмжээ авна.	<ul style="list-style-type: none"> -Улсын албан ёсны статистик мэдээллийн үзүүлэлт, мэдээллийн тогтолцоог боловсруулж болгох -Хүн амын ээлжит тооллогын бэлтгэл ажлыг эхлүүлэх -Аж ахуйн нэгжийн тооллогыг улс даяар зохион байгуулах -Салбар хоорондын тэнцлийг шинэ арга зүйгээр гаргах -Төрийн өмчийг хувьчлах замаар 20-иас доошгүй тэрбум төгрөгийн орлого төсөвт оруулах 	<ul style="list-style-type: none"> 1997 I сараас 1997 1997 1997 - 	<ul style="list-style-type: none"> П. Цагаан П. Цагаан П. Цагаан П. Цагаан П. Цагаан П. Цагаан Л. Нямсамбуу
	-Арилжааны банкуудын төрийн болон төрийн өмчийн оролцооны хэсгийн хувьчлалыг эхлэх	1997	П. Цагаан Ж. Үнэнбат

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
	-Орон сууц хувьчлалыг хэрэгжүүлж эхлэх	1997	П. Цагаан Г. Нямдавала
	-Газар өмчлөлийн арга хэмжээг зохион байгуулалттай хэрэгжүүлж эхлэх	1997	П. Цагаан Ц. Агваасүрэн Л. Нямсамбуу
	-Байгалийн баялгийг концессоор ашиг-луулах асуудлаар хууль боловсруулах	1997 III-IV улирал	П. Цагаан Ц. Агваасүрэн
	-Төрийн өмчийн тооллого явуулж, үндсэн хөрөнгийн шинэчилсэн үнэдгээг тогтоож, төрийн өмчийн нэгдсэн бүртгэлийн систем бий болгох	1997	П. Цагаан, сайд нар
	-Хувьчилж үл болох болон төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлэх төрийн өмчийн эд хөрөнгийн жагсаалтыг гарган УИХ-д өргөн мэдүүлэх	1996 IV улирал	П. Цагаан Л. Нямсамбуу Г. Нямдавала Л. Зориг Ч. Лхагважав
	-Төрийн өмчид байгаа ашиглалт муутай барилга байгууламжид сулалгаа хийж худалдах, түрээсээр ашиглуулах ажлыг зохион байгуулах	1997	П. Цагаан, Аймаг, нийслэлийн Засаг дарга
	-Иргэдийн хөрөнгийн биржид бүртгэгдсэн хөрөнгө оруулалтын эрхийн бичгийг хөрөнгөөр баталгаажуулах ажлыг дуусгах	..	П. Цагаан

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
9. Эдийн засгийн өсөлтийг хангах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хөрөнгө оруулалт, галаадны эзэл, тусламжийн хэмжээг нэмэгдүүлж, ашиглалтын үр ашгийг нь дээшүүлэх.	<ul style="list-style-type: none"> -Эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн дэд бүтцийн салбарт хувьчлалын оновчтой арга хэлбэрийг ашиглан хувьчлалыг явуулах -Хөрөнгө оруулалтыг ДНБ-ний 24,6 хувьд хүртэх -Хувьцааны захиалга авах аргаар хөрөнгө оруулалт хийж, хувьцаат компани байгуулах аргыг бүх талар дэмжин хөгжүүлэх 	<ul style="list-style-type: none"> -" -" -" 	<ul style="list-style-type: none"> -" -" П. Цагаан, холбогдох сайд нар
	-Эзэл, тусламжийг дотоодын шингээх чадвартай уялдуулан эргэж төлөгдөх баталгатай үр ашигтай төсөл арга хэмжээнд зарцуулах	-	П. Цагаан Ш. Алтангэрэл
	-Эзэл, тусламжийн аль болох олон эх үүсвэрээс авч ашиглан төсөвт учруулах дарамтыг багасгах чиглэл баримтлаж эзлэх	-	-
	-Галаадны эзэл, тусламжийг авах, ашиглахтай холбогдсон үйл ажиллагааг ээлжлүүлэн хувь эрхийн актыг бий болгох	-	-

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
--------	-------------------------	---------	---------------

Б. ҮЙЛДЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО

1. Аж үйлдвэрийн салбарт бүтцийн өөрчлөлт хийж, экспортын болон хүн амын хүнс, өргөн хэрэглээний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, ДНБ, хуримтлал, төсвийн орлогод салбарын эхлэх хувийн жинг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.

-Төрийн өмчийн болон хувийн хэвшлийн зарим аж ахуйн нэгжийг Дэлхийн банкны "Банк, үйлдвэрийн газрын өөрчлөн байгуулалтын зээл"-ийн хөтөлбөрийн хүрээнд хамааруулж, бие дааж үр ашигтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх

1997

Л. Нямсамбуу

-Түлш, эрдэм хүч, уул уурхай зэрэг салбарын зарим үйлдвэрийн техник, технологийн шинэчлэлтэд тэргүүлэх ач холбогдол өгч галийн татварын хувь хэмжээг барааны төрөл, ангиллаар ялгавартай тогтоох

1997

II улирал

П. Цагаан
Л. Нямсамбуу
Г. Нямдаваа

-Дотоодын хөрөнгө оруулагчдыг гадаадын хөрөнгө оруулалтын хуульд заасан

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Харгууцах эзэн
	хөнгөлөлттэй нөхцөлд хамруулах арга хэмжээ авах	-	П. Цагаан
	-Үйлдвэртэл, үйлчилгээний төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд баталгаа гаргах журмыг Монголбанк, олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран боловсруулж мөрдүүлэх	1997 I улирал	П. Цагаан
	-Аж үйлдвэрийн салбарыг мэдээллээр хангах, зөвлөлтөө өгөх, техник технологийн сонголт хийхэд тусалж, дэмжих үйлчилгээний байгууллагыг үүсгэн байгуулахад дэмжлэг үзүүлэх	-	Л. Нямсамбуу
	-“ЖДУ-ийг дэмжих тухай” хууль боловсруулж ЖДУ-ийн шалгуурыг тогтоон ЖДУ эрчимтэй хөгжих эрх зүйн орчин бүрдүүлэх	1997 II улирал	-
	-“ЖДУ-ийг хөгжүүлэх үзэл баримтлал”-ыг УИХ-аар багтуулан мөрдүүлэх замаар орон нутагт ЖДУ хөгжүүлэхэд эдийн засгийн илүү талтай орчинг бүрдүүлэх	1997 III улирал	Л. Нямсамбуу
	-Үйлдвэртэл дэмжих бодлогоо “Экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг дэмжих”, “Жи-жиг, дунд үйлдвэрийг дэмжих” дэд хөтөл-бөрөөр үе шаттайгаар хэрэгжүүлэх	1997	Л. Нямсамбуу

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Харуулах эзэн
	<ul style="list-style-type: none"> -Хувийн аж ахуйн нэгжүүдийг дэмжих төрөлжсөн банк болон эзэлийн баталгааны ба даатгалын сан байгуулах асуудлыг судалж шийдвэртэх 	1997 II улирал	-
	<ul style="list-style-type: none"> -Жоншны боловсруулалтын түвшинг ахиулж чанарыг сайжруулах үндсэн дээр гадаад зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх 	1997	-
	<ul style="list-style-type: none"> -Мардайн уурхайг ашиглах тухай хуулин гэрээ хэлэлцээрийг шинэчилж үйлдвэрлэлийг өөрчлөн зохион байгуулах 	1997 I улирал	-
	<ul style="list-style-type: none"> -Өмчийн бүх хэвшлийн хүрээнд алт олборлолтыг дэмжиж, Монголбанкнид худалдан авах алтын доод хэмжээг 5500 кг-аар, олборлох дээд хэмжээг 6000 кг-аар тус тус тогтоох 	1997	-
	<ul style="list-style-type: none"> -Ноос, арьс ширний салбарын үндсэн түүхий эдийг анхан шатны боловсруулалт хийлгүүгээр экспортлох асуудлыг хязгаарлах арга хэмжээг татварын бодлого болон тарифын бус хэлбэрээр дамжуулан хэрэгжүүлэх 	-	-
	<ul style="list-style-type: none"> -Ноос, ноолуурт гүдгийг боловсруулалт хийхэд анхаарч, алангула ноолуураар эдсийн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэртэж, 		

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
	дэлхийн зах зээлд борлуулах, ноос боловсруулах зарим үйлдвэрт шинэ техник, технологийг нэвтрүүлэхийг дэмжих	"- "	"- "
	-Үндэсний уламжлалт экспортын бүтээгдэхүүний /ноолуур, угаасан ноос, санхин эдлэл гэх мэт/ үйлдвэртэлийг шинэчлэн хөгжүүлэх	"- "	"- "
	-Импортоор авч байгаа зарим материалыг өөрийн оронд үйлдвэрлэх чиглэлээр уртлаг ноосон ээрмэлийн үйлдвэр, нийлэг мяндаас, хөвөн мяндсан ээрмэлийн үйлдвэртэлийг бий болгоход дэмжлэг үзүүлэх	1997	Л. Нямсамбуу
	-"Булигаар" ХК-ийн технологийн шинэчлэлтийг дуусгаж, жилд 280 мян. м ² хромьт экспортлох боломж бүрдүүлэх	"- "	"- "
	-ОХУ-д төлөх урсгал хээлийн өрөнд 1997 онд 7000 гаруй тонн мах гаргах арга хэмжээ авах.	1997	"- "
	-Сэлэнгэ аймгийн Зүүнхараагийн "Спирт бад бурам" ХК-ийн үйлдвэрийн цэвэрлэх байгууламжийг шинэчлэх	1997	"- "
	-Сэлэнгэ аймгийн Зүүнхараагийн элсэн чихрийн үйлдвэрийг ашиглалтад оруулж, эх орны элсэн чихрийг үйлдвэрлэж эхлэх	1997 III улирал	"- "

- "Монгол хүний хоол гэжээ" хөтөлбөрт шаардагдох хөрөнгийг бүрэлдэх арга хэмжээ авч, хэрэгжилтийг эринмжүүлэх
- Бэлтгэл, судалгааг хангасны үндсэн дээр "Монгол-машин", "Монголметалл" нэгтгэлүүдийг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад хувьчлах
- Хар төмөрлөгийн үйлдвэрийг түүхий эзээр хангах, улсын экспортын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор Сэлэнгэ аймгийн Төмөртэйн уурхайг эзэмших, ангижруулсан төмөрийн үйлдвэр байгуулах техник эдийн засгийн үндэсдэл боловсруулах ажлыг олон улсын байгууллага, хандивлагч орнуудын орлолцоотойгоор хийж гүйцэтгэж, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх
- Нүүрсний уурхайнуудын төрийн өмчийн хэсгийг хувьчлах ажлыг үргэлжлүүлж, орон нутгийн зарим уурхайг бүрэн хувьчлах
- Урьд жилүүдэд ойжуулагүй орхисон газрыг ойжуулах, ойг нөхөн сэргээх, ойнд дагалт бүтээгдэхүүнийг ашиглах
- Мод бэлтгэл, ойжуулалтын ажилд дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх замаар байгалийн сэргэн ургалтад туслах

1997

Л. Нямсамбуу

"- "

"- "

1997

II улирал

"- "

"- "

Г. Нямдаваа

1997

Л. Нямсамбуу
Ц. Агьаасүрэн

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
	болон обьжуулалтын ажлыг нэмэгдүүлж бэлтгэсэн модны хэмжээгээр нөхөн ойжуулах хүч чадлыг бий болгох арга хэмжээ авах	"-	"-
	-Ардын уламжлалт аргаар гэрийн мод, модон эдлэл, мал малдаганы тоноглол үйлдвэрлэх үлс, хоршооллын болон хувийн жижиг үйлдвэрлэлийг дэмжих	"-	"-
	-Ой модны нөөцөд үнэлгээ хийж, гуалин экспортлох үйл ажиллагааг зогсоох	"-	"-
2. Малын тоо толгойг өстөхийн зэрэгцээ сүргийн зохистой бүтэц бүрдүүлэх, ашиг шинийн гарч, чанарыг сайжруулна.	-Өрхийн болон хорцсон аж ахуйн эрх зүйн үндсийг бүрдүүлж, бие даан аж ахуйн харилцаанд орох чадвартай малчин өрхийг аж ахуйн нэгжийн эрхтэй болгож, төлбөрийн бэлэн бус тооцооны хэлбэрийг ашиглах нөхцөлийг бүрэлдэх	1997	Л. Нямсамбуу, аймаг, нийслэлийн Засаг дарга нар
	-Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх ажлын чанарыг сайжруулах, мал амьтны гоц халдварт болон халдварт өвчин галаад орнуудас дамжин орж ирэхээс сэргийлэх хяналтын найдвартай систем тогтоох, халдварт, паразит өвчинтэй тэмцэх, сэргийлэх, мал аж ахуйн мэргэжлийн албадын бүтэц, зохион байгуулалтыг	1997	Л. Нямсамбуу, аймаг, нийслэлийн Засаг дарга нар

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
	шуурхай болгох		
	-Цөөн малтай малчин өрхийг малжуулахад чиглэсэн бодлогыг тууштай баримталж хэрэгжүүлэх	"- "	"- "
	-Байгалийн гинэтийн аюулаас мал аж ахуйд учирсан хохирлыг нөхөх даатгалын тогтолцоо бий болгох эрх зүйн үндсийг бүрдүүлэх	"- "	"- "
	-Төрийн өмчид байх цөм сүргийг баталгаажуулж, тэдгээрт үржлийн ажлал явуулах материаллаг баазыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	"- "	"- "
	-Хөдөө аж ахуйг гадаргын өрсөлдөөнөөс хамгаалах арга хэмжээ авах	"- "	"- "
3. Газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээн илрэхжүүлэхэд чиглэгдсэн дэс дараатай арга хэмжээ авна. 1997 онд 300 мянган тонн үр тариа хураан авна.	-Газар тариалангийн хөрөнгө оруулалтыг дэмжих санг байгуулж, техник шинэчлэх, элит, сортын үр үйлдвэртэх, шинэ тех- нологич эзэмшихэд зориулалтын зээл олгох, илүүдэл буудайг Засгийн газрын мэдээд улсын аюулаас хамгаалах болон эргэлтийн нөөцөд худалдан авах замаар газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээхэд санхүүгийн бодитой туслаж үзүүлэх	1997	Л. Намсамбуу, Аймгийн Засаг дарга нар

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хяриулах эзэн
<p>4. Дэд бүтцийн салбаруудад тэргүүлэх ач холбогдол өгч түши, эрчим хүч, зам тээвэр, холбооны төсөв, арга хэмжээг хэрэгжүүлнэ.</p>	<p>-Ур тариа, төмний элит, сортын үр үйлдвэрлэлийг боловсронгуй болгох, үр үйлдвэрлэлийг Засгийн газрын мэдэлд авч зарцуулалтад нь хяналт тавих -Газар тариалангийн аж ахуйн нэгжүүдийг эрх зүй, санхүүгийн боломж, ноцолыг шинэх, төрийн өмчийн компаниудыг хувьчлах, бусад аж ахуйг зохион байгуулалтын хувьд өөрчлөн байгуулж, өмчийг эзэнд нь ойртуулах -Газар тариалангийн техникийн шинэчлэлд Засгийн газраас санхүүгийн дэмжлэг үзүүтэх</p>	<p>1997 1997 1997</p>	<p>Л. Нямсамбуу, аймаг, нийслэлийн Засаг дарга нар Л. Нямсамбуу, аймаг, нийслэлийн Засаг дарга нар П. Цагаан Л. Нямсамбуу</p>
<p>-Багинуурын нүүрсний уурхайн техник технологийн шинэчлэл хийхэд гадаадын эзэл тусламж хөрөнгө оруулалтаар дэмжлэг үзүүлэх</p>	<p>-137 км урт 110 квт-ын болон нийлбэр дүнгээрээ 200 км 35 квт-ын, 162 гаруй км урт 10 квт-ын цахилгаан дамжуулах шугам, дэд өргөөний замт бараж ашиглалтад оруулах</p>	<p>1997 "</p>	<p>П. Цагаан Г. Нямдалал Г. Нямдалал</p>

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
	Шивээ овоогийн нүүрсний уурхайн өргөг- гөлийн хээлийн хэлцээрийг байгуулж, ус шүүрүүлэлтийн систем, нүүрс ачих, алгах байгууламж зэрэг тэргүүн ээлжийн объек- туудыг барьж эхлэх	1997 III улирал	"- "
	-Баянтээгийн нүүрсний уурхайн гүний ус шүүрүүлэх цооногийн системийг шинээр барьж, олборлох хүч чадлыг нэмэгдүүлэх	"- "	"- "
	-Японы Засгийн газрын хээлийн хөрөнгөөр дулааны IV шахилгаан станцын зарим то- ноглолыг хэсэгчлэн шинэчлэх ажлыг эхлэх -Азийн хөгжлийн банк, Нордик сангийн зээл, тусламжийн хөрөнгөөр дулааны III цахилгаан станцын өндөр даралтын хэсгийг өөрчлөх ажлыг үргэлжлүүлэх	1997 II улир.	"- "
	-Чойбалсан хотын дулааны шахилгаан станцын зарим үндсэн тоноглолыг сэргээн засварлах ажлыг төвлөрсөн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх	1997	"- "
	-Чойбалсан-Баруун Уртын 110 кв-ын ша- хилгаан дамжуулах шугамын барилгын ажлыг эхлэх	1997 II улирал	Г. Нямдаваа
	-Хөдөө орон нутгийн шахилгааны хангам- жийг сайжруулах зорилгоор Архангай айм- гийн Цэцэрлэг, Дундговь аймгийн Дэрэн		

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
	зэрэг сумыг ТЭХС-д холбох өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамыг барих	-	-
	-Хөдөөгийн айл өрхийг цахилгааны эх үүсвэртэй болгоход сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах болон бага чадлын усан цахилгаан станцын зураг, төсөл боловсруулах, барих бэлтгэл ажлыг хангахад хөрөнгө оруулалт хийх	-	-
	-Эгийн гол, Дөргөний УЦС-ын санхүүгийн эх үүсвэр болон Даланзадгадын дулааны цахилгаан станцыг БНСУ-ын хээлээр барих хөрөнгийн асуудлыг шийдэх арга хэмжээ авах	-	-
	-Өмнөговь сум-Мянгатын 110кв-ын болон Мянгад сум-Ховдын 35 кв-ын цахилгаан дамжуулах шугамуудын барилга, угсралтын ажлыг дуусгах	1997 III улирал	-
	-Ховд хотыг ОХУ-ын эрчим хүчний системд холбох	-	-
	-Дэлхийн банкны 30 сая ам. долларын зээлийн хөрөнгөөр төмөр зам, хотын тээвэр, авто тээврийг сэргээх төслийг мөнгөжүүлэн хэрэгжүүлэх	1997	Г. Нямдалаа

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
	<p>- Япон улсын булалтгүй тусламжаар хотын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах төслийн хоёрдугаар ээлжийг хэрэгжүүлж 100-200 автобусанд үйлчилгээ хийх эсвэр, үйлчилгээний станц барьж ашиглалтад оруулах</p> <p>- Агаарын навигацийг хөгжүүлэх төслийг олон улсын банк, санхүүгийн байгууллаган зээл тусламжаар хэрэгжүүлэх</p> <p>- "Монголын тээврийг сэргээх" төслийн хүрээнд төмөр замын техникийг шинэчлэх ажил гүйцэтгэх</p> <p>- АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр Буянт-Ухаагийн нисэх төв буудлыг шинэчлэх ажлыг дуусгах</p> <p>- Дотоодын усан замын тээврийн үйл ажиллагааг сэргээх, далайн тээвэр эрхлэх эрх зүйн баталгаа бурадуулэх</p> <p>- Улаанбаатар-Аттанбулагийн замыг шинэчлэх ажлыг эхлүүлж, Налайх-Багануур-Өндөрхаан, Өвөрхангай-Баянхонгор, Ховд-Говь-Алтай, Улаангом-Хандгайтын чиглэлийн хатуу хучилттай замуудыг үргэлжлүүлэн барьж, хөндлөн гол тэнхлэгийн баруун чиглэлийн автозамыг оновчтой тог-</p>	<p>4- 1997 I улирал</p> <p>1997 оноос</p> <p>1997</p> <p>1997 III улирал</p> <p>1997</p>	<p>-"-</p> <p>Г. Нямдаваа</p> <p>-"-</p> <p>-"-</p> <p>Г. Нямдаваа</p>

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
	тоож, түүнд замын сангийн хөрөнгийн дийлэнхийг хувиарлах, Дархан-Эрдэнэт, Налайх-Чойрын авто зам барих бэлтгэлийг хангах	-"-	-"-
	-Налайх-Багануурын замыг Япон улсын тусламжаар барих	-"-	-"-
	-Улс, хот хооронд болон хотын доторх нийтийн тээврийн үйлчилгээнд чөлөөтэй өрсөлдөх бололцоог бүрдүүлэх	1997 оноос	-"-
	-Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудад 48,5 мянган хэрэгтэргчийн хабелийг шинээр суурилуулах, сэргээн засварлах	-"-	-"-
	-Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудад нийт 16 мянган номерын багтаамж бүхий 3 тоон АТС, дэд станц хоёрыг суурилуулах	-"-	-"-
	-Улаанбаатар-Дархан-Эрдэнэтийн чиглэлд орчин үеийн технологи бүхий тоон радио релейний станц /16 ширхэг барьж/ байгуулах	-"-	-"-
	-Радио релейний 46 станцын тэжээлийн байгууламжийг нарны зай үүсгүүрээр солих	-"-	-"-
	-Нийтийн үйлчилгээний 400 ширхэг таксфон утас суурилуулах	-"-	-"-

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
	<ul style="list-style-type: none"> -Төв, Сэлэнгэ, Дорноговь, Хэнтий, Дорнод, Сүхбаатар зэрэг аймагт сумын түвшинд хүргэл, тодорхой бүс нутагт баг, сумын төвийг холбох замаар хөдөөний холбооны сүлжээ байгуулах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх 	-	-
	<ul style="list-style-type: none"> -"BCAT" сансрын холбооны системээр хөдөөг холбоожуулах төслийн хүрээнд сумын төв, зарим баг, жуулчдын бааз, ашигт малтмал олборлох газрууд, хилийн боомт зэрэг суурин газарт сансрын холбооны хэрэглэгчийн станцууд суурилуулан, олоогийн сүлжээг шинэчилж телефон яриа, факс дамжуулах боломжийг бүрдүүлэх 	-	-
	<ul style="list-style-type: none"> -Жилд 0,5-1,0 мегаватт нарны хүч чадалтай зай үйлдвэртэй иж бүрэн жижиг үйлдвэрийг байгуулах 	-	-
	<ul style="list-style-type: none"> -Баянхонгор, Улаангом, Даланзадгал, Дархан хотуудад цэвэр усны болон цэвэртэй байгууламж, шугам, ус нөөцлөх сангийн барилгыг барьж дуусгах 	-	-
<p>5. Монгол орны өвөрмөц онцлог, хөгжлийн харьцангуй дэ-</p>	<ul style="list-style-type: none"> -Хүн амын нутагшилт хөгжлийн ерөнхий төслийг баталгаажуулж, бүс нутгийн зохион байгуулалт, тэргүүдэд чиглэлүүдийг тогтоох 	1997	Г. Нямлаваа

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
--------	-------------------------	---------	---------------

вuu талуудад түшиг-
лэн хот байгуулалтын
бодлогыг тодорхойлж
хэрэгжүүлнэ.

- Хот байгуулалтын хуулийг боловсруулж хэрэгжүүлэх арга хэмжээ авах
- Бүс нутгийн таталлын төвүүд, бүлэг суурингийн төвүүдийг тогтоож, хүн амын шилжих хөдөлгөөнийг тогтворжуулах арга хэмжээ авах
- Орон сууцны хөтөлбөр боловсруулан орон сууцны төрөл, хэв загварыг шинэчлэн тогтоож, амины орон сууц барих санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх
- Хот суурины цэвэр усны шугам цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжийг шинэчлж, ашиглалт, үйлчилгээний түвшинг дээшлүүлэх

В. БАЙГАЛЬ ОРЧИН, ШИНЖЛЭХ УХАМНЫ БОДЛОГО

1. Байгаль хамгаалах, нөөц баялгийг зохио-
той ашиглах эрх зүй,
эдийн засаг, зохион
байгуулалтын үндсийг
арга хэмжээ авах

1997. I
сараас

Ц. Агьясүрэн,
Аймаг,
нийслэлийн
Засаг дарга

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
<p>бэхжүүлэх, байгаль орчны хуулиудын хэрэгжилтийг хангах замаар байгаль орчиндоо зохицон хөгжих утвар нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ.</p>	<p>-Бус нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлого, чиглэлтэй уялдуулан байгаль орчны хамгаалах үйл ажиллагааны хяналт, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, энэ зорилгоор төв, орон нутгийн ИТХ-ын дэргэд олон нийтийн зөвлөл байгуулах</p>	<p>1997. II улирал</p>	
	<p>-Усны хангамж, чанар муутай 8 суманд ус зөөлрүүлэх, цэцэгжүүлэх төхөөрөмж суурилуулах</p>	<p>1997</p>	<p>-"</p>
	<p>-Экологийн гэнцвэрийг хангахад онцгой нөлөө бүхий зарим газар нутгийг тусгай хамгаалалтад авах шийдвэр гаргуулах</p>	<p>1997 IV улирал</p>	<p>Ц. Агьласүрэн</p>
	<p>-Монгол орны нэн ховор зарим амьтан, ургамлыг хамгаалах үндэслэл боловсруулж, Монголын "Улаан ном"-ын хэвлэлд бэлтгэх</p>	<p>-"</p>	<p>-"</p>
	<p>-Ойг хамгаалах, ойжуулалтын ажлын цар хүрээг өргөжүүлж 5,5 мянган га талбайг ойжуулах</p>	<p>1997</p>	<p>Ц. Агьласүрэн, аймаг, нийслэлийн Засаг дарга</p>
	<p>-Төв, суурин газрын бохир ус цэвэрлэх байгууламжуудын ашиглалтыг сайжруулж үйлдвэртэй, ахуйн бохир усны цэвэртэгээний түшиг дээшлүүлэх</p>	<p>-"</p>	<p>-"</p>
	<p>-Байгаль орчинд нөлөөлөх байдлын</p>		

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
<p>2. Шинжлэх ухаан, технологийн бодлогын хүрээнд тус салбарын эрх зүйн үндсийг бүрдүүлж зохицох бусад бий болсон үндэсний шинэ технологи болон гадаадын тэргүүний технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх арга хэмжээ авна</p>	<p>үнэлгээний тухай, агаар бохирдуулсны төлбөрийн тухай, амьтны аймгийг хамгаалах тухай, байгалийн аюул гамшигийн тухай хууль боловсруулах</p> <p>-Албан ба албан бус боловсролын тогтолцооны хүрээнд экологийн боловсрол, хүмүүжил олгох талар журм боловсруулж мөрдүүлэх</p> <p>-Шинжлэх ухааны тухай, технологи дамжуулах тухай хуулиудыг боловсруулж Улсын Их Хурлаар батлуулах</p> <p>-Эрдэм шинжилгээний байгууллагуудын зэрэглэл тогтоож, үйл ажиллагааг нь дэмжих</p> <p>-Салбарын эрдэм шинжилгээний байгууллагуудыг "Судалгаа туршилт-үйлшвэрлэл-бизнес"-ийн ажил эрхэлсэн корпорац хэлбэрээр ажиллуулах арга замыг тодорхойлж туршилтын журмыар ажилдуулж эхлэх</p> <p>-Шинжлэх ухаан, технологийн төсөл ажлыг сонгон шалгаруулах, санхүүжүүлэх ажлыг боловсронгуй болгох арга хэмжээ авч, хөдөө аж ахуй, биотехнологи, химийн салбар болон шинэ материал гаргах</p>	<p>1997 III улирал</p> <p>1997 I-II улирал</p> <p>1997 III улирал</p> <p>1997 оноос</p>	<p>Ц. Агьяасүрэн</p> <p>Ц. Агьяасүрэн Ч. Лхагважав</p> <p>Ч. Лхагважав</p> <p>"-</p> <p>"-</p>

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
	чингэлэйн судалгаа, шинжилгээний ажилд түлхүү анхаарах	1997	Ч. Лхагважав
3. Жуулчны үйлчилгээг сайжруулах, аялал жуулчлалын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бий болгох, жуулчдын тоог нэмэгдүүлэхэд анхаарна.	-Үндэсний уламжлалт технологийг орчин үеийн шинжлэх ухааны ололтоор бэлжүүлэн хөгжүүлж, гадаадын тэргүүний технологийг нэвтрүүлэх эдийн засаг, эрх зүйн таагүй нөхцөлийг бий болгох эхний алхмыг хэрэгжүүлэх -Зочид буудал, жуулчны баазын зэрэглэл тогтоож, үйлчилгээний стандарт боловсруулж мөрдүүлэх	1997	Г. Нямдаваа
		I улирал	-
		II улирал	-
		1997	-
		I сарнаас	-
		II улирал	-
		1997 III улирал	-
		1997	-
		1997	-
		I сарнаас	-
		1997	-
		II улирал	-
		1997	-
		II улирал	-

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
--------	-------------------------	---------	---------------

Г. НИЙГМИЙН БОДЛОГО

1. Нийгмийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгон бэхжүүлэх дээр тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ нь эмзэг хэсгийн амьдралын баталгааг хангахуйц байх нөхцөлийг бүтээжүүлнэ.

-Нийгмийн бүх төрлийн даатгалд хамрагдах хүрээг өргөтгөж, нийгмийн даатгалын шимтгэл, хураамжийн орлогыг хугацаанд нь оруулаагүй, тэтгэвэр, тэтгэмжийг хугацаанд нь олгоогүй нөхцөлд буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх, унирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн үндсийг бүрэлдүүлж, хэрэгжүүлэх арга хэмжээг авах үндсэн дээр даатгалын сангуудыг өөрийгөө санхүүжүүлэх зарчимд шилжүүлэх алхам хийх

-Амьжиргааны түвшний өөрчлөлттэй уялдуулан тэтгэврийг нэмэгдүүлэх асуудлыг тухай бүр шийдвэрлэж байх, ахмад настан, тахир дутуу иргэн, тэжээгчээ алдагчийн тэтгэврийг тэргүүн ээлжинд нэмэгдүүлэх, насны тэтгэврийн зөрүүт арилгах арга хэмжээ авах

-Тэтгэврийн насанд хүрээгүй тэтгэвэр авагч иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, амьдралын баталгааг нь хангах арга хэмжээ авч.

1997
оноос

Л. Зориг

●

1997. 1
сар

-"

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
	даатгалын байгууллагын чадварийг сайжруулах	1997 I улирал	Л. Зориг
	-Эрүүл мэндийн даатгалд хамрагдах эмгэгчдийн үйлчилгээний хүрээг өргөтгөж, эрүүл мэндийн даатгалын төр хариуцах хэсгийг багасгах, эмчилгээний зардлын төлбөрийг тооцох механизмзыг боловсронгуй болгох арга хэмжээ авах	1997	"-
	-Нийгмийн даатгалын сангуудын зохион байгуулалт, менежментийг боловсронгуй болгох, нийгмийн хамгааллыг жинхэнэ эдлэх ёстой хүнд нь хүргэж, тэднийг ядуурлаас хамгаалах, нийгмийн халамжийн болон ядуурлыг бууруулах сангийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах механизм тогтоох	"-	Л. Зориг П. Цагаан
2. Ядууралтай тэмцэх үндэсний сан бий болгож, хөтөлбөр хэрэгжүүлэх.	-Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг цаг үеийн шаардлагатай уялдуулан боджуулж, түүний хэрэгжилтийг эрчимжүүлэх, ядуурлыг бууруулах нэгдсэн сангийн бүтэц, үйл ажиллагааны зарчмыг боловсруулж хэрэгжүүлэх	"-	Л. Зориг
	-Бүтэн өнгөн ба золбин тэнцмэл хүүхдийг халамжих, боловсрол, хуууланг, хөдөлмөрийн дадлага олгох	"-	"-

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
	<p>-Ядуурлыг бууруулах үндэсний хөтөл- борийн хүрээнд гадаад орон, олон улсын байгууллагатай хамтран тодорхой төслүүд хэрэгжүүлэх</p>	-	-
<p>3. Хүн амын хөдөл- мөр эрхлэлт, ажлын байрны тоог нэмэг- дүүлдэг.</p>	<p>-1997 онд нийт 30 орчим мянган хүнийг ажлаар хангаж, ажилгүйдлийн түвшинг эдийн засгийн идэвхтэй хүн амын 7,0 хувиас хэтрүүлэхгүй байх</p>	1997	Л. Зориг
	<p>-Сум, суурин газрын иргэдийг малжуулах замаар хөдөлмөр эрхлэлтийг дээшлүүлэх, зам засах, малын гэжээл бэлтгэх, тариа, хүнсний ногоо тариалах, ургац хураах зэрэг хөдөлмөр зарцуулалт ихтэй, олон нийтийг хамарсан ажилд хамруулах, түр хугацаагаар ажиллуулах арга хэмжээг зохион байгуулах</p>	1997	Л. Зориг Аймаг, нийслэлийн Засаг дарга
	<p>-Ерөнхий боловсролын 8,10 дугаар анги төгсөгчдийн 10-аас доошгүй хувийг мэр- гэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдэд сургах ажлыг зохион байгуулах</p>	1997 III-IV улирал	Ч. Лхагважав, Аймаг, нийслэлийн Засаг дарга
	<p>-Ажилгүй хүмүүст мэргэжил эзэмшүүлэх, даван сургах сургалтын төвүүдийг хөдөл- мөр зохицуулалтын албадын дэргэд зохион байгуулж ажиллуулах арга хэмжээг авч эрхлэх</p>	1997	Л. Зориг, Аймаг, нийслэлийн Засаг дарга

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
4. Хүн амын нөхөн үржих эдийн засаг, нийгмийн таатай орчинг бүрдүүлэхэд анхаарч, эх, нялхсын өвслөл, эндэгллийг бууруулж, хүн амын тогтвортой өсөлтийг хангана.	<p>-Ажилгүйдлийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгож, хөдөлмөр зохицуулалтын албадыг бэхжүүлэх арга хэмжээ авах</p> <p>-Хүн амын өсөлтийг 1,6 хувилас доошгүй байлгах</p> <p>-Эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, өвчнөөс урьдчилан сэргийлэх асуудлаар НУБ-ын төрөлжсөн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх төслийн цар хүрээг нэмэгдүүлэх</p> <p>-Хөдөө сумдад эхүүдийн төрөхийн өмнөх байрыг сэргээж төслөөс санхүүжүүлэх замаар үйл ажиллагааг нь тогтмолжуулснаар гэрийн төрөлтийг 1995 оноос 50 хүртэл хувиар бууруулах</p> <p>-Хүн амын эрүүл мэндийн боловсрол хөтөлбөр болон хавьартай тэмцэх хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж эхлэхийн зэрэгцээ эрүүл ахуй, халдвар судлал болон эмчилгээний чанарын хангалтын албандын тогтолцоог боловсронгуй болгох</p> <p>-Эмчилгээ, оношлогооны стандартыг шинэчлэн боловсруулж, эрүүл мэндийн байгууллага болон хүний эмчийн эмчлэх эрхийг баталгаажуулах арга хэмжээ авах</p>	<p>-"-</p> <p>1997</p> <p>1997</p> <p>-"-</p> <p>-"-</p> <p>-"-</p>	<p>-"-</p> <p>Л. Зориг</p> <p>-"-</p> <p>-"-</p> <p>-"-</p>

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
5. Бүх шатны боловсролын өнөөгийн агуулга, технологид дүн шинжилгээ хийж боловсронгуй болгох, хүн бүр өөрийн аявас сонирхол, чадаарын хэрээр боловсрол эзэмших нөхцөлийг хангасан тогтолцоог төлөвшүүлэх арга хэмжээ авна.	<ul style="list-style-type: none"> -Өрхийн эмчийн тогтолцоог бэхжүүлэн өргөтгөж, хөдөөгийн хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламжийг сайжруулж, сумдын эмнэлгийг түргэн тусламжийн автомашинаар хангах арга хэмжээг үргэлжүүлэх -Бүх түвшний боловсролын стандартыг боловсруулж мөрдүүлэх -Боловсролын хүрээнд бүх шатны сургуулийн бүтэц, хэв шинж байршил, боловсрол олгох, удирдлага, зохион байгуулалтыг оновчтой болгох, бүтцийн өөрчлөлт хийж хувийн хэвшлийн оролцоог өргөжүүлэх -Нийгмийн ухааны сургалтын агуулгыг хүмүүшлэг, ардчилсан нийгмийн иргэн төлөвшүүлэх шинэ хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн үзэл суртлын алиана нөлөөлөөс ангижруулан шинэчилж, суралцагчдын сонголт чөлөөтэй хийх боломжийг хангах 	<ul style="list-style-type: none"> -" 1997 -" -" 	<ul style="list-style-type: none"> -" Ч. Дхагважав -" Ч. Дхагважав
	<ul style="list-style-type: none"> -Хүүхэд, залуусын онцгой авьяас чадварыг багаас нь илрүүлж хөгүүлэн дэмжихийн тулд тэдгээрийг тусгай хөтөлбөрөөр хичээллүүлэх, туршлагатай багш нарыг дайчлан суралцуулах бүх бололцоогоор хангахад төрөөс дэмжлэг, үзүүлэх 	<ul style="list-style-type: none"> -" 	<ul style="list-style-type: none"> -"

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
	-Дотуур байрны ахуй нөхцөл, хоол, хүнсний хангамжийг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх	1997 IX сараас	" "
	-Сургалтын төрийн сангийн зохион байгууллт, мэргэжлийн боловсролын сургуулиудын санхүүжилтийн журмыг боловсронгуй болгох	1997	" "
	-Боловсролын чиглэр, стандартын хэрэгжилтэд хөндлөнтгийн хяналт тавих магадлан итгэмжлэл /аккредитаци/-ийн тогтолцоо бий болгох санал боловсруулах	" "	" "
	-Соёлын хүрээний эрх зүйн шинэчлэлийг гүнгийрүүлж, соёлын бодит бус өвийг хамгаалах, хэвлэлийн үйл ажиллагаа, киноны тухай хуулиудыг боловсруулах	" "	" "
6. Соёл, урлагийг зах зээлийн эдийн засгийн харилцааны тогтоцоонд нийцүүлэн хөгжүүлэхэд анхааралын зэрэгцээ хүн амд үзүүлэх соёлын үйлчилгээг сайжруулахад дэмжлэг үзүүлэнэ.	-Соёлын салбарын менежмент, бүтэц, зохион байгуулалтыг зах зээлийн харилцааны зарчим, бус нутгийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн боловсронгуй болгох арга хэмжээ авах	" "	" "

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хэргүйцэх эзэн
	- "Номын сан" төсөл боловсруулан хэрэгжүүлж эхлэх	"- "	"- "
	- Мэргэжлийн урлагийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх замаар сонгодог, язгуур болон хүүхдэд зориулсан урлагийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	"- "	"- "
	- Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн засварлахад анхаарч "Музейн дохиолол" төсөл хэрэгжүүлж, улсын чанартай томоохон музейнүүдийг дохиолол-тай томоохон музейнүүдийг дохиолол-хамгааллын системд хамруулах	"- "	"- "
	- Түүх, соёлын дурсгалыг хамгаалах томоохон төслүүдийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	"- "	"- "

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 12 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 75

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Үндсэн хуулийн
5 жилийн ойг тэмдэглэх тухай**

Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн 5 жилийн ойг Үндсэн хуулийн өдөр буюу 1997 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр орон даяар тэмдэглэхээр тогтоосугай.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн 5 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах улсын комиссыг хавсралтад дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн 5 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэхийг улсын комисст даалгасугай.

Дарга

Р. ГОНЧИГДОРЖ

Улсын Их Хурлын 1996 оны
75 дугаар тогтоолын хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН
5 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭН
ӨНГӨРҮҮЛЭХ УЛСЫН КОМИССЫН
БҮРЭЛДЭХҮҮН**

Комиссын дарга

-Монгол Улсын Их Хурлын дарга
Р. Гончигдорж

Нарийн бичгийн дарга:

-Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын
газрын дарга Б. Чимэд

Гишүүд:

-УИХ-ын дэд дарга Ц. Элбэгдорж,
-УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын
хорооны дарга С. Зориг
-УИХ-ын гишүүн Н. Багабанди
-Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн
дарга Г. Совад

- Монгол Улсын Гэгээрлийн сайд
Ч. Лхагважав
- УИХ-ын Тамгын газрын ерөнхий нарийн
бичгийн дарга Л. Цог
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
дарга Т. Лхагваа
- ШУА-ийн ерөнхийлөгч Б. Чадрал
- Сангийн яамны төрийн нарийн бичгийн
дарга Д. Махбал

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1996 оны 12 сдугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 76

Улаанбаатар
хот

Улсын Их Хурлын Аюулгүй байслын
дэд хорооны бүрэлдэхүүнийг батлах
тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15^д дүгээр зүйл:
засныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын Аюулгүй байслын дэд хороог дараах
бүрэлдэхүүнтэйгээр баталсугай:

- 1/ Бат-Эрдэнийн Батбаяр
- 2/ Цэндийн Нямдорж
- 3/ Дамдинсүрэнгийн Энхбаатар

Дарга

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1996 оны 12 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 77

Улаанбаатар
хот

Байнгын хорооны гишүүнээс
чөлөөлөх, гишүүнээр батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйл:
засныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Өөрсдийнх нь хүсэлтээр Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүнээс Ринчиннямын Амаржаргалыг, Хууль зүйн байнгын хорооны гишүүнээс Норовын Алтанхуягийг тус тус чөлөөлсүгэй.

2. Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүнээр Норовын Алтанхуягийг баталсугай.

Дарга

Р. ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1996 оны 11 дүгээр
сарын 27-ны өдөр

Дугаар 214

Улаанбаатар
хот

Зэрэг дэв олгох тухай

Улсын Дээд шүүхийн саналыг үндэслэн Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгч Дашдоржийн Дэмбэрэлцэрэнд Монгол Улсын шүүхийн тэргүүн түшээ зэрэг дэв олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. Очирбат

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1996 оны 11 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар 217

Улаанбаатар
хот

**Ч. Дашиямыг албан тушаалаас
чөлөөлөх тухай**

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Чоймжуурын Дашиямыг энэ оны 11 дүгээр сарын 29-нөөр тасалбар болгон Шүүхийн ерөнхий зөвлөлийн нарийн бичгийн даргын албан тушаалаас чөлөөлсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. Очирбат

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1996 оны 12 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 230

Улаанбаатар
хот

Цэрэндашийн Цолмон, Надмидын
Бавуу нарыг элчин сайдын үүрэгт
ажлаас чөлөөлөх тухай

Өөр ажилд шилжих болсонтой нь холбогдуулан Цэрэндашийн Цолмонг Монгол Улсаас Бүгд Найрамдах Болгар Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдын, Надмидын Бавууг Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдын үүрэгт ажлаас тус тус чөлөөлсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1996 оны 12 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 231

Улаанбаатар
хот

Цэрэндашийн Цолмонг элчин
сайдаар томилж тухай

Цэрэндашийн Цолмонг Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суух онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар тохоон томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1996 оны 12 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 232

Улаанбаатар
хот

Тойтогийн Төмөрхүлэгийг элчин
сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх
тухай

Тойтогийн Төмөрхүлэгийг Монгол Улсаас Бүгд Найрамдал
Ардчилсан Лаос Ард Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин
сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1996 оны 12 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 233

Улаанбаатар
хот

Лувсандоржийн Баяртыг элчин
сайдаар томилох тухай

Лувсандоржийн Баяртыг Монгол Улсаас Бүгд Найрамдал
Ардчилсан Лаос Ард Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин
сайдаар тохоон томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

96 оны 12 дугаар
рын 13-ны өдөр

Дугаар 234

Улаанбаатар
хот

**Зарлиг хүчингүй болсонд
тооцох тухай**

“Төр, сүм хийдийн харилцааг зохицуулах тухай” БНМАУ-ын өнхийлөгчийн 1990 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 55 дугаар хлиг, “Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн дүрэм, рэлдэхүүнийг баглах тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 ы 8 дугаар сарын 24-ний өдрийн 172 дугаар зарлигийг тус тус ингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

96 оны 12 дугаар
ын 13-ны өдөр

Дугаар 235

Улаанбаатар
хот

**Багш нарын талаар авах зарим
арга хэмжээтэй холбогдуулан
Засгийн газарт чиглэл өгөх тухай**

Монгол Улсын Засгийн газраас зохион байгуулж хийлгэсэн инголын багш нарын ҮГ их хурал манай орны боловсролын өгийн байдалд дүгнэлт хийж, шинэтгэлийг гүнзгийрүүлэх аргтын талаар боловсролын удирдах ажилтан, багш, сургагүүжүүлэгчдээс арга туршлагаа солилцох, санаа бодлоо илэрхийлж тгэх, энэ талаар төрөөс авах хэмжээний тулгамдсан асуудлыг орхойлоход чухал ач холбогдолтой үйл явдал болсныг тэмдэглэж, ш нарын мэргэжил дээшлүүлэх, тэдний ажил амьдралын цөлийг сайжруулах талаар нэн даруй шийдвэрлэж хэрэгжүүлбэл их асуудлаар Засгийн газарт чиглэл болгох нь:

1/ багш, сурган хүмүүжүүлэгчдийг бэлтгэх тэдний мэргэжлийг шлүүлэх, давтан сургах, шинэ мэргэжлээр багш бэлтгэж хангах

ойрын хугацааны хөтөлбөрийг боловсруулан гаргаж түүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгаж санхүүжүүлэх, мөн гадаадын зээл тусламж, хамтран гүйцэтгэх төслийн хүрээнд зохио арга хэмжээг тусган хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзсүгэй;

2/ багш нарын ажил, амьдралын нөхцөлийг сайжруулахтай холбогдсон дор дурдсан асуудлыг судалж зохих журмын дагуу шийдвэрлэсүгэй:

а/ боловсролын салбарт бүтцийн өөрчлөлт хийж, ажлын нягтралыг сайжруулах, орон тоо, зардал хямдруулах замаар хэмнэгдсэн хөрөнгийг багш нарын цалинг нэмэгдүүлэх эх үүсвэр болгох;

б/ багш, сурган хүмүүжүүлэгчдийн эрүүд мэндийн үзлэгийг 1997 онд багтаан явуулж шаардлагатай хүмүүсийг эмчилгээ, сувилгаанд хамруулах, түүнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төвлөрсөн буюу орон нутгийн төсөвт тусгах замаар хэрэгжүүлэх;

в/ багш, сурган хүмүүжүүлэгчдэд өрхийн аж ахуй эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, тэднээс гэр бүл, үр хүүхдийнхээ хүмүүжилд халамь анхаарал тавих, өөрийгөө хөгжүүлэх, нийгмийн бусад асуудал шийдвэрлэхэд чөлөөт цагийг нь нэмэгдүүлэх.

з/ суурь боловсрол эзэмшвэл зохих насны хүүхдийн сургуули завсардалтыг 1997-1998 оны хичээлийн жилээс эхлэн таслаа зогсоох, өмнөх жилүүдэд завсардсан хүүхдүүдэд зохих шатны боловсрол нөхөн олгох арга хэмжээ авсугай;

4/ Татварын багц хуулинд нэмэлт өөрчлөлт оруулахаар одоо боловсруулж буй төсөлд боловсролын салбарт хөрөнгө оруулсан сургалтын байгууллагад санхүүгийн талаар ивээн тэтгэж, тусламж үзүүлсэн хувийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд албаа татварын зохих хөнгөлөлт үзүүлэх заалт оруулж 1997 оны эхний хагас жилд багтаан шийдвэрлүүлсүгэй.

5/ Төрийн өмчийн сургуулиудад судалгаа шинжилгээ явуула түүнчлэн сургуулийн хамт олны хүчээр туслах аж ахуй эрхэлж олсоо орлого зэрэг өөрсдийн хүч хөдөлмөр, санаачилгаар бий болгосон орлого хуримтлалыг тухайн сургууль өөрийн материаллаг баазыг бэхжүүлэх, багш, ажилтныхаа хөдөлмөр ахуйн нөхцөлийг сайжруулахад зориулан бие дааж зарцуулдаг болгох, түүнийг бүртгэж тайлагнах, үнэлэлт дүгнэлт өгөх журмыг гаргаж мөрдүүлсүгэй;

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

Монгол Улсын Ерөнхий сайд

М. ЭНХСАЙХАН

СЭТҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч	Л. Цог
Хариуцлагатай нарийн бичгийн дарга	Б. Гавбат
Гишүүд:	Б. Цэнддоо Ч. Дашиям Б. Чимид Б. Энэбиш
Техник редактор	С. Итгэлт
Уншиж хянасан	Сан. Жаргалсайхан Б. Янжиглхам

Үйлдвэрт шилжүүлсэн 1997 оны 1-р сарын 9-нд
Өрөлтөд 1997 оны 1-р сарын 13-нд. Хэвлэлтэд
1997 оны 2-р сарын 7-нд. Хэвлэлийн хуудас 7,75
Хэвлэсэн тоо 4453ш

Манай хаяг: Улаанбаатар-12
Төрийн ордон. Утас 322838

Төр, Засгийн Үйлчилгээ Аж Ахуйг
Эрхлэх Газрын харьяа
Хэвлэх үйлдвэр

